

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/2019.01.02-2019.12.10/**

НЭГ. ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

ХАХ	ГАУ	Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуурзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)	
				ХШҮДАГ	ТЭЗ
1	2	3	4	5	6
НИЙТ АРГА ХЭМЖЭЭ, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ					
НЭГ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ ТАЛААРХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХ, БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАР ҮОРОНДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДААГ ХАНГАХ, САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙГ ТӨЛӨВЛӨХ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ БОДЛОГЫН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
1.1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр болон газрын тосны салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хувилбар, төсөл, төлөвлөгөө боловсруулах зорилтын хүрээнд:					
4.	5.	1.1.4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулна. 1. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлж, УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлэх. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар өргөн мэдүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулан улмаар ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьсан. Хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.	.30	30
14.	17-18.	1.1.14. Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “газрын тосны бүртгэл тооцоо” журмыг боловсруулж батлуулна. 1. “Газрын тосны бүртгэл тооцоо” журмын төсөлд яамдаас авсан саналыг тусгаж, эцэслэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа	1. “Газрын тосны бүртгэл тооцооны журам”-ын төсөлд яамдаас санал авч нэгтгэн, ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган эцэслэн боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн ба ЗГ-ын 2019.05.01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 178 дугаар тогтоолоор баталсан.	30	30

		<p>Чанар: Журмыг эцэслэн боловсруулсан байна. Хугацаа: II улиралд</p> <p>2. “Газрын тосны бүртгэл тооцоо” журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Журмын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн байна. Хугацаа: II улиралд</p>			
1.1. Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах зорилтын хүрээнд:					
15.	19.	<p>1.2.1. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчмыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана.</p> <p>1. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчмыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана. Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Ажлын хэсгийн хуралд тогтмол оролцож санал тусган ажилласан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн ээлжит хуралдаанаар орон нутгийн туршилтын төсөл, Дэд зөвлөлийн үйл ажиллагааны явцын талаар хэлэлцсэн. УУХҮЯ-ны ТНБД-ын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны болон нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг ил тод болгох, цахим санд байршуулах ажлыг УУХҮС-ын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, цахим санд 400 гэрээг байршуулсан. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зарчмыг хэрэгжүүлж, ил тод байдлыг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж, ОУИТБС-ын Ажлын албатай хамтран ажиллаж байна. Мөн Монголын ОУИТБС-ын 13 дахь буюу 2018 оны тайланг нэгтгэх ажлыг хамтран зохион байгуулсан.</p>	30	30
16.	20.	<p>1.2.2. Жишиг үнийг холбогдох мэдээллийн эх сурвалжаас бэлтгэж, сар бүрийн эхний 10 хоногт нийтэд мэдээлнэ.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар байгуулагдах байнгын ажлын хэсэгт ажиллана. Тоо хэмжээ: 12 удаа</p> <p>Чанар: Сар бүрийн жишиг үнийг тогтоосон байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>УУХҮС, СС-ын хамтарсан Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 2018.07.27-ны өдрийн 200/A/177 дугаар тушаалын дагуу байгуулагдсан Ажлын хэсэг нь Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, МУ-ын ЗГ-ын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу “Экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний жишиг үнийн мэдээлэл”-ийг www.lme.com, www.mongolbank.mn, www.indmin.com, www.umetal.com, www.asianmetal.com, www.sxcoal.com цахим хуудсаас бэлтгэн боловсруулж, сар бүр жишиг үнийн мэдээллийг олон нийтэд цахимаар мэдээлсэн.</p>	30	30
1.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаарх бодлогын хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах зорилтын хүрээнд:					

17.	21.	<p>1.3.1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг боловсруулж хуулийн хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.</p> <p>1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөлд яамны дотоод газар, нэгжүүдээс санал авч нэгтгэж Сангийн яаманд хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 12 удаа</p> <p>Чанар: Сар бүрийн жишиг үнийг тогтоосон байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг Сангийн яаманд 2019.03.04-ний өдрийн 01/563 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үндсэн чиглэлийн төслийг нийт 11 их наяд 22.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 5 бүлэг, 127 зорилт арга хэмжээтэйгээр УИХ-ын 2019.05.31-ний өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p>	30	30
18.	22-23	<p>1.3.2. 2020 оны Төсвийн төсөл, 2021-2023 оны төсвийн төсөөлөлд санал боловсруулж Сангийн яаманд хүргүүлэх, Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулна.</p> <p>1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засгийн голлох үзүүлэлт, тооцоог боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ.</p> <p>2. 2020 оны төсвийн төсөл, 2021-2023 оны төсөөлөлд тусгуулах ажлыг Сангийн яамтай хамтран зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар:Хуулийн хугацаанд боловсруулж хүргүүлсэн байх.</p> <p>Хугацаа: II улиралд</p>	<p>2020 оны төсвийн төсөл, 2021-2023 оны төсвийн төсөөллийг боловсруулахтай холбогдуулан уул уурхай голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын төсөөллийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Сангийн сайдад 2019.03.29-ний өдрийн 01/845 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>УИХ-ын чуулганы 2019.11.13-ны өдрийн хуралдаанаар 2020 оны Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан.</p>	30	30
19.	24.	<p>1.3.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын олон нийттэй харилцах төлөвлөгөөг боловсруулна.</p> <p>1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын олон нийттэй харилцах (PR) төлөвлөгөөний төслийг салбарын чиглэл тус бүрээр нэгтгэн боловсруулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Салбар бүрийн чиглэлээр нэгтгэн боловсруулсан байна.</p> <p>Хугацаа: II улиралд</p>	<p>УУХҮЯ-ны ТНБД-ын 2019.04.29-ний өдрийн А/73 дугаар тушаалаар “Олон нийтийн уул уурхайн боловсрол хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг байгуулан “Олон нийтийн уул уурхайн боловсрол” /олон нийттэй харилцах төлөвлөгөө/ хөтөлбөрийн төслийг эхний байдлаар боловсруулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдээс санал авч нэгтгэн ажиллаж байна.</p>	30	30

20.	25.	<p>1.3.4. Уул уурхайн салбараас улсын төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх, зах зээлийн судалгаа, эрдсийн бүтээгдэхүүний үнийн судалгаа хийнэ.</p> <p>1. Уул уурхайн гаралтай эрдэс, түүхий эд, баяжмал бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн судалгаа хийх, салбарын статистик, салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар мэдээлэл боловсруулж, дүн шинжилгээ хийх, яамны удирдлагыг энэ чиглэлийн мэдээллээр хангана.</p> <p>Тоо хэмжээ: 12 удаа Чанар: Судалгаа үндэслэлтэй хийгдсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Уул уурхайн гаралтай эрдэс, түүхий эд, баяжмал бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн судалгаа, салбарын статистик, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг тухай бүр нэгтгэн боловсруулж, 7 хоног болон сар, улирлаар удирдлагад танилцуулсан.</p>	30	30
21.	26.	<p>1.3.5. Гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээл, тусламжийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн зохицуулалтыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулна.</p> <p>1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй /хэрэгжих/ төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх, бодлогын уялдааг хангах, хэрэгжилтийг хангуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн зарцуулалт, үр дүн сайжирсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>МУЗГ, ХБНГУ-ын ЗГ хоорондын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны 2018 оны хэлэлцээрийн хүрээнд ХБНГУ-ын ЗГ-ын зээл, тусламжаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх төслийн саналыг бэлтгэн СЯ-тай тохиролцон Германы талд хүргүүлсэн. 2019.06.18-ны өдөр зохион байгуулагдсан Монгол-Германы ЗГ хоорондын ажлын хэсгийн хуралдаанаар УУХҮЯ-ны тавьсан төслийн саналыг дэмжихээр шийдвэрлэсэн.</p> <p>Дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн /МИНИС/ санхүүжилтээр “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага”-ын журмын төслийг боловсруулах саналыг бэлтгэн төслийн Удирдах хорооны хуралд танилцуулан дэмжүүлсэн. Улмаар Дэлхийн банкнаас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу төслийн саналд нэмэлт тодруулга хийж хүргүүлсэн бөгөөд МИНИС төслийн зүгээс СЯ, УУХҮЯ болон төрийн бус байгууллагуудын оролцоотой Үнэлгээний хороог байгуулж төслийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан хэдий ч МИНИС төсөл нь хаагдаж байгаатай холбогдуулан шинээр эхлүүлэхээр төлөвлөж байсан төслүүдийг зогсоох шийдвэрийг СЯ-наас гаргасан тул журмын төслийг боловсруулах ажил хийгдээгүй.</p> <p>“Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр II”-ийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах яамны үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар санал солилцон ажиллаж байна. Энэ хүрээнд төслийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж хүргүүлсэн.</p>	30	30
		<p>1.3.6. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг дээшлүүлнэ.</p>	<p>Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үндсэн үзүүлэлтийг сайжруулах зорилтын хүрээнд холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тухай бүр боловсруулж, удирдлагад танилцуулсан. Энэ хүрээнд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт</p>	30	30

22.	27.	<p>1. Салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалтын үндсэн үзүүлэлтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх. Холбогдох тооцоо судалгаа, мэдээ мэдээллээр удирдлагыг тогтмол хангана.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Салбарын эдийн засгийн суурь үзүүлэлтүүд, томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт сайжирсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын 2018.10.31-ний өдрийн хуралдаан, ЭЗБХ-ны 2018.11.28-ны өдрийн хуралдаан, УИХ-ын 2019.03.26-ны өдрийн чуулганаар тус тус хэлэлцүүлж батлуулсан. Хуулийн төсөл батлагдсанаар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх боломж бүрдсэн.</p> <p>УИХ-ын 2018 оны 73 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор УИХ-ын ЭЗБХ болон УИХ-ын гишүүдээс УУХҮС-д хандан тавьсан асуулгад холбогдох чиглэлээр хариу боловсруулан хүргүүлсэн.</p> <p>Боаогийн азийн эдийн засгийн чуулга уулзалт 2019 оны 08 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулагдсантай холбогдуулан уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд, томоохон төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн Сангийн дэд сайдад хүргүүлсэн.</p> <p>Оюутолгой төслийн жижиг хувьцаа эзэмшигч болох Sailingstone capital partners, Pentwater capital management болон Luminus management ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн уулзалтад оролцож, төслийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй бусад асуудлаар жижиг хувьцаа эзэмшигчдийн байр суурийг сонсож, санал солилцсон.</p> <p>МУ-ын Үндсэн Хуулийн Цэцийн 2019.10.30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим заалтуудыг хүчингүйд тооцохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу рояллиттай холбоотой зарим тооцоо, мэдээллийг нэгтгэн боловсруулсан.</p>		
<p align="center">ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, САЛБАРЫН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:</p>					
<p align="center">2.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн тайланг гаргах, яамны дотоод үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, олон нийттэй харилцах зорилтын хүрээнд:</p>					
24.	29.	2.1.1. 2019 оны үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг нэгтгэн зохион байгуулна.	1.УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны А/11 дүгээр тушаалаар байгуулагдсан Яамны үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөний	30	30

		<p>1. ТЕЗ-аас ЕМ /ТНБД/-тай, ЕМ-ээс нэгжийн дарга нартай Үр дүнгийн гэрээ батлуулж, биелэлтийг нэгтгэн, холбогдох газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Гэрээ байгуулж, биелэлт гарсан байна. Хугацаа: 1, 6, 12 дугаар сард</p>	<p>төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. УУХҮЯ-ны 2019 оны төлөвлөгөөний төслийг тогтоосон хугацаанд боловсруулан УУХҮС-аар батлуулсан. Үр дүнгийн гэрээний биелэлтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэж, ХШҮДАГ-т хүргүүлсэн ба 86,7 оноогоор дүгнэгдсэн. 2. АМГТГ-ын даргын гэрээний төслийг хүлээн авч холбогдох газруудаас санал авч хянан баталгаажуулсан. Газрын дарга нарын үр дүнгийн гэрээний төслийг хүлээн авч яамны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хянаж баталгаажуулах ажлыг хугацаанд нь зохион байгуулсан.</p>		
25.	30.	<p>2.1.2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн холбогдох газарт хүргүүлнэ. 1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн хүргүүлнэ. Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. Хугацаа: Тухай бүр</p>	<p>УУХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 119 заалтыг new.unelgee.gov.mn сайтаас шүүн, 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцыг холбогдох газар хэлтсүүдээс авч нэгтгэн 2019.06.25-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлсэн. УУХҮЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 139 заалтыг new.unelgee.gov.mn сайтаас шүүн, хэрэгжилтийн явцыг холбогдох газар, хэлтсүүдээс авч нэгтгэн 2019.12.25-ны өдөр ХШҮДАГ-т хүргүүлэхээр бэлэн болгосон.</p>	30	30
26.	31.	<p>2.1.3. Засгийн газрын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг тайлагнана. 1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд яамны газар, хэлтсээс санал авч нэгтгэн биелэлтийг тайлагнана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөөний биелэлтийг байна. Хугацаа: 1, 12 дугаар сард</p>	<p>ЗГ-ын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөний дагуу 33 асуудлаас 2019.12.17-ны өдрийн байдлаар 23 асуудал хэлэлцүүлэн батлуулсан.</p>	30	30
27.	32.	<p>2.1.4. Засгийн газар болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хангуулна. 1. Сайдын Албан даалгаврын хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хэрэгжилтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. 1. Сайдын Албан даалгаврын хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хэрэгжилтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөөний биелэлтийг байна. Хугацаа: 1, 12 дугаар сард</p>	<p>МУ-ын Ерөнхийлөгчийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” 2018.09.04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу УУХҮС-ын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийн УУХҮС-ын зөвлөлийн хуралд танилцуулсан. Дүгнэлтээр УУХҮЯ-100% /төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлсэн/, АМГТГ-65.5% /ажлыг эхлүүлсэн/, 21 аймгууд 26.9% /тодорхой ажил хийгээгүй/ хэрэгжилттэй ба нийлбэр дүнгээр 64.1%-тай байна. Сайдаас өгсөн чиглэл дагуу албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах талаар агентлаг, аймгуудын Засаг дарга нарт хүргүүлэх зөвлөмжийг боловсруулан 2019.07.19-ний өдрийн 03/2152, 03/2153, 03/2154, 03/2155 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.</p>	30	30

			<p>МУ-ын Ерөнхийлөгчийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” 2018.09.04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу УУХҮС-ын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 06 тоот албан даалгавар гарч харьяа байгууллага, орон нутгийн Засаг даргын Тамгын газар, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2019 оны 3 дугаар улирлын байдлаар албан даалгаврын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд УУХҮЯ-100% /төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлсэн/, АМГТГ-75% /төлөвлөсөн ажлууд хэрэгжих шатандаа/, 21 аймгууд 67,1% /төлөвлөсөн ажлууд хэрэгжих шатандаа/ хэрэгжилттэй ба нийлбэр дүнгээр 80.7%-тай байна.</p> <p>Жилийн эцсийн биелэлт 2020 оны 1 дүгээр сард гарна.</p>		
28.	33-35	<p>2.1.5. 2019 оны Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг хангуулна.</p> <p>1. Авилгаас урьдчилан сэргийлэх салбарын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, биелэлтийг хангуулах арга хэмжээг тухай бүр авч ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p> <p>2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийн тайланг Авилгатай тэмцэх газарт хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: 02/01-ний дотор</p> <p>3. Төрийн жинхэнэ албан хаагчдын ХАСХОМ баталгаажуулж, ХАСУМ хянуулж, тайланг Авилгатай тэмцэх газарт хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: 03/01-ний дотор</p>	<p>1. УИХ-ын 2016.11.03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор 6 жилийн хугацаанд 2 үе шаттай, нэг дэх үе шат 2016-2019, хоёр дахь үе шат 2020-2023 онд хэрэгжүүлэх “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталж, МУ-ын ЗГ-ын 2017.04.12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд бүх шатны төрийн байгууллагуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасны дагуу “УУХҮЯ-ны 2019 оны авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан ТНБД-аар батлуулж, яамны цахим хуудсанд байршуулж, санал гомдол хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>УУХҮЯ-ны 2018 оны авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тайлан, 2018 оны ХАСХОМ-ийн баталгааны хуудас, ХАСУМ, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд байршуулан, эх баримт бичгүүдийг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн багцалж, архивд хүлээлгэн өгсөн.</p> <p>2. “УУХҮЯ-ны 2019 оны авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд 5 чиглэлээр гүйцэтгэх 15 ажлыг хийж гүйцэтгэхээр баталсан.</p> <p>Төлөвлөгдсөн ажлуудаас 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилт нь хангалтгүй байсан 5 ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх зорилгоор газар, хэлтсүүдэд дотоод бичгээр хүсэлт хүргүүлж, АМГТГ-ын 2019.09.30-ны өдрийн 9/6628 дугаар албан бичгээр ажлын хэрэгжилтийн тайланг хүлээн авч, АТГ-т цахимаар хүргүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд АТГ-аас удаа дараа зохион байгуулан ЭБАТ-дын сургалт семинарт оролцож, тараасан мэдээлэл, ухуулга</p>	30	30

			<p>сурталчилгааны самбарыг УУХҮЯ-ны мэдээллийн буланд байршуулан, гарын авлагуудыг албан хаагчдад хүргүүлсэн. Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын шударга байдлын түвшинг үнэлэх, авлигын эсрэг бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардагдах мэдээллийг цуглуулах зорилготой "Шударга байдлын үнэлгээ"-ний судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг "Эм Эм Си Жи" ХХК-тай хамтран зохион байгуулсан. Мөн олон нийтийн авилгатай тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор яамны бүх өрөө тасалгаа, байгууллагын ойролцоох цайны газар, кофешоп, дэлгүүр зэрэг үйлчилгээний 5 газар, ХУД-ийн 1-р хорооны Наран, Энхтайван хотхоны орцонд 110 утасны дугаартай сурталчилгааны хуудсыг байршуулсан.</p> <p>Нийтийн албанд томилогдох албан хаагчийн Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Үүний үр дүнд МУ-ын ЗГ-ын 2019.04.17-ны өдрийн 150 дугаар "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явуулах тухай" тухай тогтоолын дагуу тус яаманд 2019 оны 10 дугаар сард улсын үзлэгийн комисс ажилласан. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, хүний нөөцийн бүрдүүлэлт, хуулийн хэрэгжилтээр 100 оноотой онц дүнтэй үнэлэгдсэн. УУХҮЯ-ны 2018 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, тайланг гаргаж, АТГ-т хүргүүлсэн.</p> <p>3. Яамны хэмжээнд 2019.12.10-ны өдрийн байдлаар 2018 оны хөрөнгө орлогоо мэдүүлсэн, давхардсан тоогоор 78 албан хаагч байгаагаас их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлсэн 5, ажилд шинээр томилогдсон 8, албан тушаал дэвшсэн 4 албан хаагч байна. УУХҮЯ-ны төрийн албан хаагчдын 2018 оны ХАСХОМ-ийн баталгааны хуудсыг цаасаар болон цахимаар хүлээн авч хянан, хуулийн хугацаанд баталгаажуулсан. 2019 оны 2 дугаар улирлаас урьдчилсан мэдүүлгийг цахимаар хянуулах үйл ажиллагаанд шилжин, энэ онд цаасаар 11, цахимаар 8 нийт 19 албан хаагч ХАСУМ хянуулсан байна. Яамны хэмжээнд 2019 онд зарлагдсан 4 тендерийн комиссод ажилласан 24 албан хаагч ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлснийг бүртгэсэн.</p>		
29.	36-37	<p>2.1.6. Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн албан хаагчдын мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг нэгтгэн зохион байгуулна.</p> <p>1. Яамны Төрийн албаны салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг</p>	<p>1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Салбар зөвлөл 2019 онд 4 удаа хуралдан, хуралдааны тэмдэглэл хөтлөн, 6 тогтоол гаргаж, тодорхой асуудлаар Төрийн албаны зөвлөлд 10, АМГТГ-т 2 албан бичгийг хүргүүлсэн. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө, тайлан, бичиг</p>	30	30

		<p>боловсруулж, Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар батлуулж биелэлтийг төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төлөвлөгөө батлагдсан байна. Төлөвлөгөөний дагуу хуралдааныг зохион байгуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p> <p>2. Төрийн албан хаагчдын мэргэжлийн түвшинг үнэлсэн Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийг үндэслэн шагнаж урамшуулах, зэрэг дэв олгох, бусад арга хэмжээг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 2 удаа</p> <p>Чанар: Шийдвэр гарсан байна.</p> <p>Хугацаа: I, II улиралд</p>	<p>баримтын бүртгэлүүдийг яамны цахим сайтад байршуулан салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2018, 2019 онуудын төлөвлөгөө, тайлан, бүртгэлийн эх бичиг баримтуудыг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн багцалж, архивд хүлээлгэн өгсөн.</p> <p>2. УУХҮС-ын 2019.04.02-ны өдрийн А/67 дугаар тушаалаар яамны 60 төрийн захиргааны албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв ахиулан буюу шинээр олгосон. Мөн УУХҮС-ын 2019.04.16-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар АМГТГ-ын төрийн захиргааны 48 албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон. УУХҮС-ын 2019.01.31-ний өдрийн 1/301 дүгээр албан бичгээр УУХҮЯ-ны ТНБД, ТЗУГ-ын дарга нарт Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох хүсэлт, УУХҮС-ын 2019.06.13-ны өдрийн 1/1790 дүгээр албан бичгээр АМГТГ-ын дарга, дэд дарга нарт Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгох хүсэлтийг холбогдох материалын хамт тус тус хүргүүлсэн.</p> <p>УУХҮЯ-ны албан хаагчдын 2019 оны эхний хагас жилийн байдлаар үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг 2019.06.25-ны өдөр зохион байгуулсан. Нийт албан хаагчид 90-100% үнэлэгдэж төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжүүлсэн гэж үзэн 2019.06.25-ны өдрийн А/102 дугаар тушаалаар албан хаагчдад хагас жилийн ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгосон. Хариуцсан ажилдаа амжилт гаргасан 2 албан хаагч, Засгийн газрын цомын тэмцээнд амжилттай оролцсон тамирчин 7 албан хаагчийг тус тус урамшуулан шагнуулсан. Төрийн албан олон жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан 3 төрийн албан хаагчийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд санал хүргүүлсэн.</p> <p>Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журмын дагуу Төрийн албаны зөвлөл 2019.10 дугаар 30-ны өдрийн 172 дугаар тогтоолоороо УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан.</p> <p>- Шинээр байгуулагдсан Салбар зөвлөл “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь батлах тухай” салбар зөвлөлийн 2019 оны 19/05, “Комисс байгуулах, шалгалт зохион байгуулах тухай” 2019 оны 19/06 дугаар тогтоолыг тус тус батлуулсан. Журмын дагуу тусгай шалгалт авах бэлтгэл хангаж байна.</p>		
30.	38.	<p>2.1.7. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийг нэгтгэн хөтлөх, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргана.</p> <p>1. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийг нэгтгэн хөтөлнө.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Тоо бүртгэлийг хөтөлсөн байх</p>	<p>Төрийн албаны тухай хууль, журамд нийцүүлэн УУХҮЯ-ны төрийн албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу хувийн хэрэгт бүрдүүлэх бичиг баримтыг шинэчлэн бүрдүүлэх талаар албан хаагчдад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, нийт</p>	30	30

		Хугацаа: I улиралд	албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлсэн. Хүний нөөцийн цахим мэдээллийн сан хөтөлж хэвшсэн.		
31.	39.	<p>2.1.8. Яамны ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, шаардлагатай арга хэмжээг авах, шийдвэрлүүлнэ.</p> <p>1. Яамны ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулан, хэрэгжилтийг хангуулан, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, тайлан мэдээг гаргана.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Тодорхой үр дүнд хүрсэн байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>“УУХҮЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлууд бүрэн биелсэн. Үүнд:</p> <p>- Албан хаагчдаас ирүүлсэн 105 өргөдөл, хүсэлтэд хариу өгсөн. Үүнээс тусламж дэмжлэг үзүүлсэн 20, амралт, чөлөө олгосон 23, гадаадад мэс засал хийлгэсэн албан хаагчид эмчилгээний зардлын нөхөх олговор олгосон 1, тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон 1, шагнал урамшуулал олгосон 2 тушаал тус тус гаргаж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж байна.</p> <p>- Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулж байна. 2019 онд газрын тосны сургалтын 100 хувь тэтгэлгээр гадаадад магистрын хөтөлбөрт суралцахаар 2 албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдөн, нөөцөд бүртгэгдсэн. Дотоодын их дээд сургуулийн магистрт 9 албан хаагч суралцаж байгаагаас 3 албан хаагчийн сургалтын төлбөрийг газрын тосны сургалтын зардлаас олгож, бүх суралцагсад цалинтай чөлөө олгон мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.</p> <p>- УУХҮЯ-ны нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгт 2019.04.18, 19-ний өдрүүдэд хамруулсан. Эрүүл мэндийн үзлэгт албан хаагчид 100 хувь хамрагдсан, ноцтой өвдсөн, эрүүл мэнд нь доройтсон албан хаагчгүй дүгнэлт гарсан.</p> <p>- Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, өрөө тасалгааны тохижилт, албан хаагчдын ажиллах нөхцөл, бололцоог судлан, яамны хэмжээнд 3 удаагийн үзлэг хийсэн. ТЗУГ-ын даргаар ахлуулсан уг ажлын хэсэг албан хаагч нэг бүрийн ажиллах орчин нөхцөлтэй танилцсан, шаардлагатай ширээ сандал, техник хэрэгслийн судалгаа гаргаж, 43 компьютер, 5 ширхэг хэвлэх төхөөрөмж, 39 ширээ сандал, шүүгээ шинээр худалдан авч ажиллагсдын ажиллах нөхцөл сайжирсан.</p>	30	30
32.	40-41	<p>2.1.9. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна.</p> <p>1. Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: салбар зөвлөлийн тайланг хүргүүлсэн байна.</p>	<p>1. УУХҮЯ-ны дэргэдэх ЖОТБСЗ-ийн 2018 оны тайлан, 2019 оны төлөвлөгөөг 2019.01.10-ны 03/77 дугаар албан бичгээр Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн.</p> <p>2. Жендэрийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэг 2018.11.02, 2018.12.22, 2018.11.29, 2018.12.06, 2019.02.01, 2019.03.01, 2019.03.15 өдрүүдэд нийт 7 удаа хуралдаж, 2019.02.21-ний өдөр “Бью скай” зочид буудалд СЕСМИМ төслийн дэмжлэгтэйгээр холбогдох байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, 2019.03.05-ны өдрийн</p>	30	30

		<p>Хугацаа: IV улиралд</p> <p>2. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт баримтлах жендэрийн бодлогын баримт бичиг, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Сайдын тушаалаар батлуулсан байна</p> <p>Хугацаа: II улиралд</p>	<p>08/582 дугаар албан бичгээр салбарын аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудруу санал авахаар хүргүүлж, ирүүлсэн саналыг тусган 2019.05.06-ны өдрийн УУХҮС-ын А/114 дүгээр тушаалаар батлуулж яамны сайтад нийтэлсэн.</p> <p>2019.05.10-ны өдөр ТНБД бөгөөд ЖОТБСЗ-ийн даргаар 2019 оны ерөнхий төлөвлөгөөг батлуулсан. Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн тайланг 2020.02.15-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлэн болгосон. /тайлагнах хугацаа болоогүй/.</p>		
33.	42.	<p>2.1.10. Салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалыг хянаж сайдын тушаал гаргаж, Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн материалыг хянаж, зохих байгууллагад хүргүүлнэ.</p> <p>1. Салбарын болон Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн материалыг тухай бүр хянаж, холбогдох арга хэмжээг авч шийдвэрлүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэр гарсан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>2019 онд 310 ААНБ-аас салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн 2100 гаруй анкет материалыг хүлээн авч шалган Сар шинийн баяраар 2019.01.29-ний өдрийн А/20, Науризын баяраар 2019.03.20-ны өдрийн А/57, Эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг тохиолдуулан 2019.05.01-ний өдрийн А/81, Газрын тосны салбарын 98 жилийн ойн баяраар 2019.05.15-ны өдрийн А/118, Улсын баяр наадмаар 2019.07.01-ний өдрийн А/153 дугаар тушаалаар, Геологийн 80 жилийн ойн баяраар 2019.10.07-ны өдрийн А/197, Уул уурхайн 97 жилийн ойн баяраар 2019.12.13-ны өдрийн А/235 дугаар тушаалаар нийт 1388 хүнийг шагнасан.</p> <p>Тухайн жил Улсын баяр наадам болоод Геологийн 80 жилийн ойн баярыг тохиолдуулан салбарын болоод УУХҮЯ-ны албан хаагчдаас Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар ирүүлсэн анкет, материалыг хүлээн авч шалган, шаардлага хангасан 245 хүний материалыг 2019.06.13-ны өдрийн Удирдлагын зөвлөлийн №10 дугаар хурал, 2019.09.30-ны Удирдлагын зөвлөлийн №15 дугаар хурлаар хэлэлцүүлж, тэмдэглэл гаргуулан, 2019.06.13-ны өдрийн 01/1812 дугаар албан бичиг, 2019.10.04 өдрийн 01/2779 дүгээр албан бичгүүдээр тус тус ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>	30	30
34.	43.	<p>2.1.11. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгогдож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нийтэд ил тод мэдээлнэ.</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгогдож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нийтэд ил тод мэдээлнэ.</p> <p>Тоо хэмжээ: тухай бүр</p> <p>Чанар: Мэдээлэл нэгтгэсэн байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээнд олгогдож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэсэн. 2019 байдлаар жилийн эцсийн байдлаар нийт 92 тусгай зөвшөөрөл олгогдсон.</p>	30	30
35.	44.	<p>2.1.12. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгогдох тусгай</p>	<p>УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээнд олгогдох тусгай зөвшөөрлийн өргөдлийг иргэд, ААН, байгууллагаас хүлээн авч хуулийн дагуу зөвшөөрлийг олгож байна. 2019 байдлаар нийт УУХҮС-ын</p>	30	30

		<p>зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэнэ.</p> <p>1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэнэ.</p> <p>/ААҮАТЗТХ-15.10.2, 15.10.4, 15.10.13, 15.10.15, 15.10.17-20, 15,10,21/</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Хүсэлтүүдийг судалж, хариу өгсөн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>тушаалаар 65 тусгай зөвшөөрөл олгогдсоноос 34 шинээр олголт, 31 сунгалт байна.</p> <p>ААҮАТЗТХ-15.10.15 Төмөрлөг боловсруулах машины үйлдвэрлэл эрхлэх</p> <p>Шинээр олгосон: 9</p> <p>Хугацаа сунгасан: 4</p> <p>15.10.2 Үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх:</p> <p>Шинээр олгосон: 0</p> <p>Хугацаа сунгасан: 3</p>		
36.	45.	<p>2.1.13. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний төслийг боловсруулах, холбогдох газруудаас санал авч нэгтгэн, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний төслийг боловсруулж гэрээг байгуулан, биелэлтийг гаргаж холбогдох газарт хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 2 удаа</p> <p>Чанар: Гэрээ байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.</p> <p>Хугацаа: 1, 6 дугаар сард</p>	<p>УУХҮС-ын 2019 онд 21 аймгийн Засаг дарга нартай байгуулах гэрээний төсөлд яамны газар, хэлтсүүд болон аймгуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн гэрээнд тусгасан. Гэрээнд гарын үсэг зурах ажлыг 2019.01.17-ны өдөр Төрийн ордонд ЗГХЭГ-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>Гэрээний биелэлтийг 2019 оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар 21 аймгаас хүлээн авч хяналт-шинжилгээ, үнэлгээг ХШҮДАГ-аар хийлгүүлж, үнэлгээний тайланг тухай бүр удирдлагад танилцуулсан.</p>	30	30
37.	46.	<p>2.1.14. Яамны удирдлагын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулна.</p> <p>1. Шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг холбогдох газар, хэлтэст хүргүүлэн, биелэлтийг тайлагнана.</p> <p>Тоо хэмжээ: 53 удаа</p> <p>Чанар: Үүрэг даалгаврыг хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <p>Хугацаа: 7 хоног бүрийн Даваа гарагт</p>	<p>Долоо хоногийн Даваа гаригт УУХҮЯ-ны удирдлагын шуурхай хуралдааныг зохион байгуулж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, тайлагнах ажлыг зохион байгуулсан. Шуурхай хуралдааны үүрэг, даалгаврын хэрэгжилтийг тухай бүр хөтлөн цахим мэдээллийн сан үүсгэн хадгалж байна. 2019 онд удирдлагын шуурхай хуралдаан нийт 37 удаа хуралдсан. Удирдлагаас давхардсан тоогоор нийт 527 үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг тухай бүр холбогдох газруудаар гаргуулан авч удирдлагад танилцуулж ажилласан.</p>	30	30
38.	47.	<p>2.1.15. Сайдын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх, баталгаажуулах, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулна.</p> <p>1. Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төсөлд гишүүдээс санал авч хуралдааныг зохион байгуулж, гарсан шийдвэрийг баталгаажуулан холбогдох газарт</p>	<p>УУХҮС-ын зөвлөлийн хуралдаан 2019 онд нийт 6 удаа хуралдаж 24 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Шийдвэрийг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан</p>	30	30

		<p>нь хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: Төлөвлөгөөний дагуу</p> <p>Чанар: Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлуулсан байна. Үүрэг даалгаврыг хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <p>Хугацаа: Улирал бүр</p>			
39.	48.	<p>2.1.16. Удирдлагын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулна.</p> <p>1. Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төсөлд гишүүдээс санал авч хуралдааныг зохион байгуулан, гарсан шийдвэрийг баталгаажуулан холбогдох газар, хэлтэст хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: Төлөвлөгөөний дагуу</p> <p>Чанар: Үүрэг даалгаврыг хэрэгжилтийг хангуулсан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>2019 онд удирдлагын зөвлөлийн хурал нийт 16 удаа хуралдаж 43 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.</p> <p>ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд УУХҮЯ-ны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан, Гурван тулгуурт бодлого"-д яамны эрхлэх асуудлаар тусгагдсан арга хэмжээний биелэлтэд хийсэн үнэлгээний дүн, ЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан, МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт яамны эрхлэх асуудлаар тусгагдсан төслүүдийн гүйцэтгэлд үнэлгээ хийсэн дүн /01.30/, УУХҮЯ-ны үйл ажиллагааны нэгдсэн тайлан, Салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүн, "Алт-2" Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүн, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан /03.29/, "МУ-ын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" /01.18/, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр /03.29/, "УУХҮЯ-ны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт" /03.29/, "МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" /06.25, 10.14/, "МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" /08.30, 10.14/, МУ-ын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /09.30, 10.14/-ийн хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний 8 тайлан, танилцуулгыг Удирдлагын зөвлөлийн 8 удаагийн хурлаар тус тус хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргуулан ЗГХЭГ, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тогтоосон хугацаанд нь хүргүүлж ажилласан.</p>	30	30
40.	49.	<p>2.1.17. Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах, гадаад, дотоодын сургалтад хамруулах арга хэмжээг зохион байгуулна.</p> <p>1. 2019 оны сургалтын төлөвлөгөөг гаргаж, нийт ажилтан албан хаагчдыг хамруулах арга хэмжээг авч ажиллаж, биелэлтийн тайланг гаргана.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Албан хаагчдыг жигд хамруулсан байна.</p>	<p>- УУХҮЯ-ны ТНБД-ын 2016.12.28-ны өдрийн Б/140 дүгээр тушаалаар баталсан "2017-2020 онд хэрэгжүүлэх "Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн дагуу "ны албан хаагчдыг 2019 оны сургалтын төлөвлөгөө"-нд ажлын байран дахь мэргэшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх, давтан сургах 4 чиглэлээр 24 сургалт төлөвлөн, зохион байгуулсан байна.</p> <p>- Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулж байна.</p>	30	30

		<p>Хугацаа: Төлөвлөгөөний дагуу</p>	<ul style="list-style-type: none"> - Ажиллагсдын суралцах, мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, урт хугацааны сургалтад: - Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр тэтгэлэгтэй суралцах сонгон шалгаруулалтад тэнцэн гадаадад 2, дотоодод 3 албан хаагч 100 хувь тэтгэлгээр магистрын сургалтад хамрагдаж байна. - 2019 онд тус яамнаас Удирдлагын академид Төрийн захиргааны сургуульд 1, ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуульд 3, МУИС-ийн Хууль эрх зүйн сургуульд 3 төрийн албан хаагч тус тус магистрын хөтөлбөрт, Түшээ дээд сургуульд 1, Билэг их сургуульд 1 албан хаагч эрх зүйн чиглэлээр суралцаж байна. - Суралцаж буй 9 албан хаагчийн ажил үүргийг зохицуулан, цалинтай чөлөө олгож суралцахад нь дэмжлэг үзүүлж байна. - 2019 онд гадаадад мэргэшүүлэх богино хугацааны сургалтад: - КОЙКА олон улсын байгууллагаас БНСУ-ын Сонгнам хотод зохион байгуулсан “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын менежментийн систем” сургалтад 2, АНУ-ын Колумбын их сургуулийн зохион байгуулсан “Олборлох салбар ба тогтвортой хөгжил” сэдэвт сургалтад 2, Япон улсын олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагаас зохион байгуулсан уул уурхайн сургалтад 2 албан хаагч тус тус оролцсон. - Дотоодод зохион байгуулагдсан “Олборлох салбарын тогтвортой хөгжил” богино хугацааны сургалтад 6 албан хаагч мэргэжлийн дагуу хамрагдсан байна. - Яамны 21 албан хаагчийг сургалтын урамшуулалд хамруулан, англи хэлний 40 цагийн ажлын байран дахь сургалтыг II улиралд зохион байгуулсан. - Канад улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй МУ-ын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх СЕСМИМ төслөөс Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, тэдгээрийн гүйцэтгэж буй ажлын чиг үүрэгтэй нь холбоотой сэдвээр мэдлэг чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр Edumine хөтөлбөрийг 2 жил дараалан хэрэгжүүлсэн. 2018-2019 онд Edumine цахим сургалтад салбарын 20 мэргэжилтэн хамрагдсан бөгөөд УУХҮЯ-аас 2 албан хаагч суралцсан. УУХҮЯ-ны ТНБД-ын 2019.03.30-ны өдөр баталсан “Мэдээллийн цаг”-ийн хуваарийн дагуу тухай бүр сургалт, мэдээллийг нийт яамны албан хаагчдад хийсэн. Үүнд: - УУХҮЯ-ны 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийсэн ажлын тайлан. - Монгол орны геологийн тогтоц. -“Төрийн албан хаагчийн манлайлал” - Өмнийн говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн ус хангамжийг шийдвэрлэх Хэрлэн-тооно төсөл. - МУ-ын ашигт малтмалын нөөцийн бүртгэлийн систем. /Монгеомин/ 		
--	--	-------------------------------------	---	--	--

			<ul style="list-style-type: none"> - Монголын геологи ба ашигт малтмал. /Төрийн соёрхол хүртсэн боть бүтээл/ - УУХҮЯ-ны албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгээс ирж мэдээлэл хийх. - Газрын тосны үүсэл, Монгол орны газрын тосны сав газрын геологийн тогтоц. - Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд чиглэл өгөх сургалт. - Англи хэлийг хэрхэн хялбар сурах арга аргачлал. - Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Албан тушаалын тодорхойлолтын тухай. - Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн талаар сургалт, мэдээлэл өгөх. - Сэргээгдэх эрчим хүчний түүхий эдийн судалгаа. - Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар тус тус мэдээлэл хийсэн. 		
41.	50.	<p>2.1.18. Иргэний нийгмийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.</p> <p>1. Иргэний нийгмийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоодын төлөөллийн санал хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллах, иргэний нийгмийн байгууллагууд, салбарын мэргэжлийн холбоодоос зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцоно.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Хууль тогтоомжид нийцсэн, шуурхай байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн уулзалтыг 2019.03.15-ны өдөр УУХҮЯ-наас зохион байгуулсан. Хэлэлцээрт туссан асуудлаар холбогдох салбарын төлөөллүүд санал солилцон хэлэлцэж УУХҮЯ-ны төлөөллүүд, Эрчим хүч, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллүүд, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажил олгогч эздийн төлөөллүүд гарын үсэг зурж баталгаажуулан 2019.04.04-ний өдөр ХНХЯ-нд бүртгүүлсэн.</p> <p>2. УУХҮЯ-наас хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр 2019 онд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан. Төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 86.6%-тай байна.</p> <p>3. УУХҮЯ-ны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргасан ба төлөвлөгөөний хэрэгжилт 75.1%-тай байна.</p> <p>4. УУХҮЯ-ны Эцэг эхийн зөвлөлийн 2019 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг гарган баталгаажуулав. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 86.6%-тай байна. Жилийн эцсийн биелэлтүүд 2020 оны 1 дүгээр сард гарна.</p> <p>УУХҮС-ын 2019 оны А/159 дүгээр тушаалаар томилогдсон, Монголын Тээвэр, холбоо, газрын тосны ҮЭ-үүдийн нэгдсэн холбоо хооронд байгуулсан 2015-2016 оны хамтын хэлэлцээрийг дүгнэх, 2019-2021 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр байгуулах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд гишүүнээр томилогдож, салбарын ҮЭ-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хэлэлцээрийн</p>	30	30

			биелэлтийг дүгнэж ажилласан. 2019-2021 оны хамтын хэлэлцээр байгуулаагүй байна.		
42.	51.	<p>2.1.19. Иргэн, албан тушаалтнаас яамны удирдлагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн гаргаж хүргүүлнэ.</p> <p>1. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 4 удаа</p> <p>Чанар: Цаг хугацаанд шийдвэрлүүлэх талаар хяналт тавьсан байна.</p> <p>Хугацаа: Улирал бүр</p>	<p>УУХҮЯ болон АМГТГ-т 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 674 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 674 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариуг албан бичгээр өгсөн 619, хугацаа болоогүй 32, хугацаа хэтэрсэн 23 өргөдөл ба шийдвэрлэлт 96.5%-тай байна. Нийт 674 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөц, дэмжлэг туслалцаа хүссэн 378 буюу 56%, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 57 буюу 8.4%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар 30 буюу 0.4%, түлш, газрын тосны чиглэлээр 7 буюу 0.1% бусад чиглэлээр 202 буюу 29.9%-тай байна.</p>	30	30
43.	52.	<p>2.1.20. Хүний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг тайлагнана.</p> <p>1. Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой Улсын Их Хурлын Байнгын хорооны 2013 оны 13 дугаар тогтоолын уул уурхайн салбарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлуудын биелэлтийг тогтсон хугацаанд нэгтгэн гаргаж, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссод хүргүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: IV улиралд</p>	<p>НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний 108.108-дахь заалтад “Хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг мөлжлөгт автах, ялангуяа хөдөлмөрийн аюултай нөхцөлд ажиллуулахаас хамгаалах үр нөлөө бүхий арга хэмжээг авах” ажлын хүрээнд:</p> <p>1. МУ-ын Ерөнхийлөгчийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” 2018.09.04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу УУХҮС-ын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд УУХҮЯ-100% /төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлсэн/, АМГТГ-75% /төлөвлөсөн ажлууд хэрэгжих шатандаа/, 21 аймгууд 67,1% /төлөвлөсөн ажлууд хэрэгжих шатандаа/ хэрэгжилттэй ба нийлбэр дүнгээр 80.7%-тай байна.</p> <p>Албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> □ Орон нутгийн Засаг даргын Тамгын газрууд Ажлын хэсэг байгуулан бичил уурхай нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрын жагсаалт”-ын дагуу хяналт шалгалтыг зохион байгуулсан байна. Шалгалтын явцад 1 зөрчил илэрсэн ба Дорноговь аймгийн Айраг суманд үйл ажиллагаа явуулж байсан 3 нөхөрлөлийн үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл түр хугацаагаар зогсоосон. □ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохыг хүсч өргөдөл гаргасан болон бүртгэлтэй нөхөрлөлүүдийн судалгааг шинэчлэн гаргасан. □ Аймгийн Засаг дарга тухайн сум орон нутагт хүүхдийн хөдөлмөрийг үл тэвчих заалтыг тусгайлан оруулах, зөрчсөн этгээдтэй гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлэн ажилласан. 	30	30

			<p>2. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 2.13 дахь заалтад Аж ахуйн нэгж бүр “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг мөрдөн ажиллана” гэсэн заалтыг нэмж тусгасан. Хэлэлцээрт туссан асуудлаар холбогдох салбарын төлөөллүүд санал солилцон хэлэлцэж УУХҮЯ-ны төлөөллүүд, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөллүүд, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын ажил олгогч эздийн төлөөллүүд гарын үсэг зурж баталгаажуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу 2019.04.04-ний өдөр бүртгэсэн. Албан даалгаврын хэрэгжилт жилийн эцсийн биелэлт 2019 оны 1 дүгээр сард гарна.</p> <p>“108.162 дахь заалтад “Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэн орох боломжийг судлан, тодорхой шийдвэр гаргах”-заалтын хүрээнд:</p> <p>“Аюулгүй байдал, хүний эрхийн санаачилгын талаарх Сайн дурын зарчимд нэгдэн орох боломжийг судлан тодорхой шийдвэр гаргах” үүргийг УУХҮЯ, ГХЯ-нд өгсөн. Энэхүү санаачилгад нэгдэх эсэх асуудлаар холбогдох талуудын /салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, холбоодын төлөөлөл/ оролцоотойгоор хэлэлцүүлгийг 2019.02.22-ны өдөр УУХҮЯ-ны Хурлын танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн ирц 100%. Хэлэлцүүлэгт УУХҮЯ-ны төлөөллүүд, ГХЯ, АМГТГ, Нийслэлийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах газар, Эрчим хүч, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Уул уурхайн үндэсний ассоциацийн төлөөллүүд тус тус оролцсон.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийн 92.8%-ийн саналаар Аюулгүй байдал, сайн дурын санаачилгад нэгдэхээс болгоомжлох хэрэгтэй гэсэн саналыг гаргасан.</p> <p>НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу ГХЯ-наас хэрэгжүүлж буй “Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд” үйл ажиллагааны төлөвлөгөөнд аюулгүй байдлын ажиллагааны талаар тусгаж ажиллах нь зөв зүйтэй байна гэж үзсэн. Уг төлөвлөгөөг боловсруулах Ажлын хэсэг нь ГХЯ дээр байгуулагдаж байгаа бөгөөд Ажлын хэсэгт УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Төрийн захиргааны удирдлагын газрын төлөөллүүд ажиллаж байна.</p>		
44.	53.	<p>2.1.21. Салбарын дайчилгаа, гамшгийн асуудлыг хариуцан ажиллана.</p> <p>1. Гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, баримт бичгийг боловсруулж, мэргэжлийн байгууллагаар батлуулах, биелэлтийг хангуулах арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>2019 онд салбарын дайчилгааны талаар Батлан хамгаалах яамнаас үүрэг даалгавар өгөгдөөгүй байна. 2019.05.02-ны өдрийн А/75 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах улсын албаны удирдлагын бүтэц батлах тухай” уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны бүрэлдэхүүнийг томилж 2019.05.21-23-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах улсын үзлэг”-ийн бэлтгэл ажлыг ханган улсын үзлэгийг</p>	30	30

		Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Холбогдох төлөвлөгөөг боловсруулж, цаг үеийн байдалтай холбоотой шаардлагатай мэдээ тайланг тухай бүр нь хүргүүлсэн байна. Хугацаа: II, IV улиралд	зохион байгуулсан. “Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам”, “Дайчилгааны нөөц бүрдүүлэх журам”, “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчийг дайчилсан тохиолдолд нөхөх олговор төлөх журам”, “Дайчилгаатай сургууль явуулах журам” “Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд татан оролцуулсны хөлсийг төлөх журам” “Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжээс дайчилсан санхүүгийн нөөцийг буцаан төлөх журам”-ын төслүүдэд санал хүргүүлсэн.		
2.2. Олон талт гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, зохицуулах зорилтын хүрээнд:					
2.2.1. Монгол Улс болон гадаад улс орнуудын Засгийн газар хоорондын комиссын болон бусад хуралдаанд шаардлагатай мэдээлэл материал бэлтгэх, зохион байгуулах зорилтын хүрээнд:					
45.	54-58	<p>2.2.1.1. Монгол Улс болон гадаад улс орнуудын Засгийн газар хоорондын комиссын болон бусад хуралдаанд шаардлагатай мэдээлэл, материал бэлтгэж зохион байгуулалтын хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>1. “Монгол-Хятадын Эрдэс баялаг, эрчим хүчний зөвлөл”-ийн хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төлөөлөгчдийг оролцуулах, шаардлагатай мэдээлэл, материал бэлтгэх, хамтын ажиллагааны асуудлуудыг тохирох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байх. Хугацаа: II дугаар улиралд</p> <p>2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн хуралдаанд оролцож дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуралдаанд оролцсон байх. Хугацаа: Тохиролцсон хугацаанд</p> <p>3. Монгол-Канадын дугуй ширээний 8 дугаар уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Уулзалт зохион байгуулагдсан байх. Хугацаа: Тохиролцсон хугацаанд</p> <p>4. “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар</p>	<p>1. МУ-ын Шадар сайдын ажлын алба, ГХЯ-наас товыг тохироогүй байна.</p> <p>2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн хуралдаан 2019.08.06-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бөгөөд хуралдаанд ГХАХ-ийн дарга Ч.Анун оролцсон.</p> <p>3. Монгол-Канадын дугуй ширээний уулзалтын 8 дугаар хурлыг 2019.06.04-ний өдөр ГХЯ-тай хамтран амжилттай зохион байгуулсан. Хуралдааныг Монголын талаас УУХҮС Д.Сумъяабазар, Канадын талаас Гадаад хэргийн Туслах дэд сайд Бобиаш нар удирдан явуулсан ба ГХЯ, МУ-аас Канад Улсад суугаа ЭСЯ, Монгол Улсад суугаа Канадын ЭСЯ, Үндэсний хөгжлийн газрын төлөөлөгчид оролцсон.</p> <p>4. “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай МУ-ын ЗГ, ХБНГУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол-Германы ЗГ хоорондын ажлын хэсгийн 7 дугаар хуралдааныг ХБНГУ-ын Берлин хотноо 2019.05.21-ний өдөр ГХЯ, ХБНГУ-ын Холбооны Эдийн засаг, эрчим хүчний яам, ХБНГУ дахь МУ-ын ЭСЯ-тай хамтран зохион байгуулсан. Ажлын хэсгийн 7 дугаар хуралдааныг Монголын талаас УУХҮС Д.Сумъяабазар, Германы талаас Эдийн засаг, эрчим хүчний яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга Оливер Виттке нар удирдан явуулсан. Мөн энэ үеэр ЗГ хоорондын ажлын хэсгийн Эдийн засгийн хорооны 8 дугаар хурлыг 2019.05.20-ны өдөр Берлин хотноо зохион байгуулсан.</p> <p>5. УУХҮС-ын зөвлөх Х.Наранхүү, УУХҮЯ-ны ТЗУГ-ын дарга М.Баяраа нар 2019.04.22-26-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо ажилласан. Айлчлалын үеэр Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГ хоорондын Комиссын хүрээнд Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны асуудлаарх Монгол, Оросын хамтарсан ажлын хэсгийн анхдугаар</p>	30	30

		<p>хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 7 дугаар хуралдаан, Эдийн засгийн хорооны 8 дугаар хуралдаанд оролцож, хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэж хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Хуралдаанд оролцсон байх.</p> <p>Хугацаа: Тохиролцсон хугацаанд</p> <p>5. ОХУ болон Монгол Улс хооронд шатахуун түгээх хоолой, шинэ нисэх онгоцны буудал болон нисэх онгоцны буудлын шатахуун түгээх станцын бүтээн байгуулалтын талаар уулзалт, хэлэлцээрийн шаардлагатай материал, бэлтгэл ажлыг хангаж ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Уулзалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байх.</p> <p>Хугацаа: Тохиролцсон хугацаанд</p>	хуралд оролцсон бөгөөд ОХУ-ын "Роснефть" компанийн төлөөлөгчидтэй албан уулзалт хийсэн.		
2.2.2. Салбарын гадаад харилцааны чиглэлээр гадаад улс орнууд, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээр, бодлогын бичиг баримтад УУХҮЯ-ны саналыг тусгах, Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргыг шаардлагатай мэдээллээр хангах зорилтын хүрээнд:					
46.	59.	<p>2.2.2.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Гадаад улс орнуудын холбогдох яамд олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, бодлогын бичиг баримтад яамны саналыг тусгаж, удирдлагыг шаардлагатай мэдээлэлээр хангаж ажиллана.</p> <p>1. Байгуулагдах санамж бичиг, гэрээ хэлэлцээрийн төсөлд УУХҮЯ-ны саналыг тусгаж, яамны удирдлагад танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Санамж бичиг, гэрээ, хэлэлцээрийн саналыг хүргүүлсэн байх</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>1. МУУҮА болон УУХҮС-ын санаачилгаар 2019.06.20-ны өдөр Хариуцлагатай уул уурхайн сайн жишгүүдийг дэмжих, нэвтрүүлэх зорилго бүхий "Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс"-т нэгдэж буй салбарын 16 аж ахуйн нэгжтэй санамж бичиг байгуулсан.</p> <p>2. "Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай МУ-ын УУХҮЯ болон БНХАУ-ын Байгалийн нөөц баялгийн яам хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төслийг санаачлан боловсруулж ГХЯ-аар хянуулан Хятадын талтай тохиролцсон.</p> <p>3. "Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай МУ-ын УУХҮЯ болон Бүгд Найрамдах Чили Улсын УУЯ хоорондын Харилцан ойлголцлын Санамж бичиг"-ийн төсөлд УУХҮЯ-ны саналыг тусган ГХЯ-аар дамжуулан Чилийн талд хүргүүлсэн.</p> <p>4. "Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай МУ-ын ЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл"-д УУХҮЯ-ны тусгах саналыг 2019.03.29-ний өдрийн 01/839 дүгээр албан бичгээр МУ-ын Шадар сайд Ө.Энхтүвшинд хүргүүлсэн.</p> <p>5. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины МУ-д хийсэн айлчлалын хүрээнд 2019.09.03-ны өдөр МУ-ын АМГТГ болон ОХУ-ын "Росгеологи" хувьцаат нийгэмлэг хооронд байгуулсан Хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулсан.</p>	30	30
2.2.3. Яамны удирдлага болон төлөөллийн гадаад улс орнуудын элчин сайд, төрийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй уулзах уулзалтыг зохион байгуулах хүрээнд:					

47.	60.	<p>2.2.3.1. Яамны удирдлагыг гадаад улс орнуудын Элчин сайд, төрийн болон олон улсын байгууллагуудын төлөөлөгчидтэй хийх уулзалт, хэлэлцээрийг зохион байгуулна.</p> <p>1. Зохион байгуулж буй уулзалтын чиглэлээр шаардлагатай материал, ярианы сэдвийг газар хэлтсүүдээс авч яамны удирдлагад танилцуулах.</p> <p>Уулзалтын тэмдэглэл, хэлэлцсэн асуудлыг яамны удирдлагад танилцуулан, уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох газруудад хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Уулзалт, хэлэлцээрийг зохион байгуулсан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>УУХҮЯ-ны удирдлагын гадаад улс орнуудын Элчин сайд, төрийн болон олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хийх уулзалтыг тухай бүр зохион байгуулж ажилласан.</p>	27	27
<p>2.2.4. Төр, засгийн тэргүүн болон яамны удирдлагын гадаад улс оронд хийх айлчлалын бэлтгэлийг хангах, зохион байгуулахад оролцох зорилтын хүрээнд:</p>					
48.	61-68	<p>2.2.4.1. Яамны удирдлага болон албан хаагчдын гадаад улс оронд хийх айлчлал, олон улсын хурал, чуулганд оролцох, сургалтад хамрагдах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж бэлтгэлийг хангаж ажиллана.</p> <p>1. Төр, засгийн тэргүүний өндөр, дээд хэмжээний айлчлалын уулзалт, ярианы сэдэвт салбарын холбогдох мэдээлэл, саналыг хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Санал, мэдээллийг хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p> <p>2. Яамны удирдлага, албан хаагчдын гадаад улс оронд хийх айлчлалын томилолтын тушаал, удирдамжийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, томилолтын мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулж илтгэх хуудсыг нэгтгэнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Гадаад томилолтыг ЗГ-ын хуралдаанаар оруулж, илтгэх хуудсыг нэгтгэсэн байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p> <p>3. Яамны албан хаагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор гадаад улс оронд богино хугацааны сургалт, семинарт</p>	<p>1. Төр, засгийн тэргүүний өндөр, дээд хэмжээний айлчлалын үеэр хийх уулзалтын ярианы сэдэвт тусгах саналыг тухай бүр холбогдох газруудад хүргүүлсэн. Тухайлбал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сард БНХАУ-д хийсэн төрийн айлчлал, 2019 оны 6 дугаар сард БНКиУ-д болсон ШХАБ-ын төрийн тэргүүнүүдийн өргөтгөсөн хуралдааны үеэр хийсэн МУ, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалт, УИХ-ын дарга Г.Занданшатарын ШХУ-д хийсэн айлчлал, БНХАУ-ын дэд дарга Ван Чишаний 2019 оны 7 дугаар сард МУ-д хийсэн айлчлал, БНХАУ-ын ӨМӨЗО-ны тэргүүн Бу Шяолиний 2019.06.27-ны өдөр МУ-д хийсэн айлчлал.</p> <p>2. УУХҮС Д.Сумъяабазарын гадаад улсад хийсэн айлчлалтай холбогдуулан тухай бүр холбогдох яамдуудаас санал авч, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд: ХБНГУ-д 2019.01.21-25-ны өдрүүдэд хийсэн айлчлал, ШХУ-ын Давос хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт”, 2019.02.09-11-ний өдрүүдэд БНЭУ-д зохион байгуулагдсан “Петротек-2019” олон улсын арга хэмжээ, 2019.02.12-13-ний өдрүүдэд БНХАУ-д хийсэн айлчлал, ИБУИНХУ-д 2019.02.28 өдрүүдэд хийсэн айлчлал, Канад Улсад зохион байгуулагдсан “PDAC-2019” арга хэмжээнд 2019.03.03-07-ны өдрүүдэд оролцсон, 2019.11.24-29-ний өдрүүдэд ИБУИНХУ-ын Лондон хотноо зохион байгуулагдсан “Mines and Money London 2019” чуулга уулзалт оролцсон, БНФУ-д хийсэн айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, ЗГ-ын хуралдаанаар айлчлалыг хэлэлцүүлэн дүнг тухай бүр танилцуулсан. Мөн 2019.09.18-23-ны өдрүүдэд Япон Улсын Токио хотноо айлчилж, Монголын Уул уурхайн хөрөнгө оруулалтын форумыг зохион</p>	30	30

	<p>хамруулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана. Тоо хэмжээ: /-/ Чанар: Албан хаагчид сургалтад хамрагдсан байна. Хугацаа: Тухай бүр 4. БНЭУ-д зохиогдох “Петротек-2019” арга хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон дагалдах төлөөлөгчдийг оролцуулах бэлтгэл ажлыг хангана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: I улиралд 5. Канад Улсын Торонто хотноо зохион байгуулагддаг Олон Улсын Уул Уурхайн Чуулга Уулзалт /PDAC 2019/-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон яамны төлөөлөгчид оролцох бэлтгэл ажлыг хангана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: I улиралд 6. БНХАУ-д зохион байгуулагддаг олон улсын арга хэмжээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон яамны төлөөлөгчид оролцох бэлтгэл ажлыг хангана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: III улиралд 7. “Эрдэс баялаг, уул уурхай-2019” чуулга уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Чуулга уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: III улиралд 8. Австрали Улсын Мелбурн хотноо зохион байгуулагддаг Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалтад /IMARC-2019/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон яамны төлөөлөгчид оролцох бэлтгэл ажлыг хангана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Бэлтгэл ажлыг хангасан байна. Хугацаа: III улиралд</p>	<p>байгуулж, 2019.10.10-12-ны өдрүүдэд МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн БНКаУ-д, 2019.12.03.06-ны өдрүүдэд ОХУ-д хийсэн айлчлалын бүрэлдэхүүнд ажилласан УУХҮС Д.Сумъяабазарын бэлтгэл ажлыг тус тус хангаж ажилласан. 3. УУХҮЯ-ны удирдлага, албан хаагчдын гадаадад албан томилолтоор ажиллах тушаалыг тухай бүр боловсруулан бэлтгэл ажлыг хангаж, илтгэх хуудсыг хүлээн авч нэгдсэн бүртгэлийг хөтөлж байна. УУХҮЯ-ны албан хаагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зарим албан хаагчдыг БНФиУ-д зохион байгуулагдсан “Ази, номхон далайн бүс нутаг дахь олборлох үйлдвэрлэлийн ашиг хүртэгч жинхэнэ эзэмшигч” сэдэвт семинарт, АНУ-д зохион байгуулагдсан “Глобал эдийн засаг дахь хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, Канад Улсад зохион байгуулагдсан “МУ-ын уул уурхайн салбарын засаглал, эрх зүйн зохицуулалтыг нэг цонхны бодлогоор дамжуулан сайжруулах” сэдэвт сургалт, БНХАУ-ын Бээжин хотын Газрын тосны их сургуулийн туршлага солилцох сургалт, БНСУ-ын Сонгнам хотноо зохион байгуулсан “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын менежментийн систем” сэдэвт сургалт, АНУ-ын Колумбын Их сургуульд “Олборлох салбар ба тогтвортой хөгжил” сэдэвт сургалт, Япон Улсад зохион байгуулагдсан Уул уурхайн сэдэвт сургалт, БНСУ-д зохион байгуулагдсан Уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн менежмент, хаагдсан уурхайг эдийн засгийн эргэлтэд оруулсан туршлага сэдэвт сургалтад тус тус хамруулсан. 4. УУХҮС Д.Сумъяабазар 2019.02.09-11-ний өдрүүдэд БНЭУ-ын Шинэ Дэли хотноо зохион байгуулагдсан “Петротек-2019” арга хэмжээнд оролцсон. Энэ үеэр УУХҮС Д.Сумъяабазар БНЭУ-ын Газрын тос, байгалийн хийн сайд Дхармендра Прадхан, ГХЯ-ны ТНБД Вижэй Такур, Эксим банкны Ерөнхий менежер Надим Панжетан болон “Инженерс Индиа Лимитед” компанийн ТУЗ-ын дарга Шри Накра нартай албан уулзалт хийсэн. 5. УУХҮС Д.Сумъяабазар Канад Улсын Торонто хотноо 2019.03.03, 04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын уул уурхайн чуулга уулзалт /PDAC-2019/-д оролцсон. Энэ үеэр “Mongolia@PDAC-2019” форумыг зохион байгуулсан бөгөөд форумд 250 гаруй гадаадын хөрөнгө оруулагчид, геологи уул уурхайн салбарын төлөөлөгчид оролцсон. 6. УУХҮС Д.Сумъяабазар БНХАУ-ын Бээжин хотноо 2019.02.12, 13-ны өдрүүдэд ажлын айлчлал, 2019.11.04-07-ны өдрүүдэд БНХАУ-ын Шанхай хотноо зохион байгуулагдсан “Хятадын олон улсын импортын үзэсгэлэн”-д оролцсон болон УУХҮ-ийн Дэд сайд Д.Загджавын 2019.10.07-11-ний өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотноо зохиогдсон “China Mining-2019” арга хэмжээнд оролцох бэлтгэлийг хангаж ажилласан.</p>		
--	---	---	--	--

			<p>7. “Эрдэс баялаг эмэгтэйчүүд-2019” үндэсний чуулганыг 2019.05.03-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус чуулганд төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллаж буй 500 орчим эмэгтэй оролцож, салбарын эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Эрдэс баялаг-Эмэгтэйчүүд үндэсний II чуулганы оролцогчдоос Зөвлөмж гаргасан.</p> <p>8. Австрали Улсын Мелбурн хотноо зохион байгуулагдсан Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалтад /IMARC 2019/ УУХҮЯ-ны ТЗУГ-ын дарга М.Баяраа, ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү нар 2019.10.27-11.01-ний өдрүүдэд оролцсон.</p>		
2.3. Хууль тогтоомж, шийдвэрийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, уялдаа холбоог хангах, дүрэм, журам, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх гол зорилтын хүрээнд:					
2.3.1. Хууль тогтоомж, дүрэм журам, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилтын хүрээнд:					
49.	69.	<p>2.3.1.1. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.</p> <p>1. Ашигт малтмал, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хуулийн төсөл боловсруулах, батлуулахад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай 2017 оны 11 дүгээр тогтоолд тусгасан тус салбарт холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019.11.07-ны өдрийн 01/3099 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.</p>	30	30
50.	70.	<p>2.3.1.2. Ашигт малтмал, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын асуудлаар батлагдах Засгийн газрын шийдвэр, хуралдааны тэмдэглэлийн төсөл бэлтгэх, боловсруулахад оролцох, туслалцаа үзүүлнэ.</p> <p>1. Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж батлуулахад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр батлагдсан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын явц”-ын талаар ЗГ-ын хуралдааны танилцуулга, “Биржээр арилжаалах ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоол, “Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааг худалдах ажиллагааны тусгай журам”-ыг батлах тухай ЗГ-ын тогтоол, “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн ногдол ашгийн тухай танилцуулга, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын явцын талаарх танилцуулга, “Газрын тосны салбарт авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоолын төсөл, Газрын тосны бүртгэл, тооцооны журам батлах тухай” ЗГ-ын тогтоолын төсөл, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоолын төсөл зэргийг бэлтгэж ЗГ-ын хуралдаанаар танилцуулж, хэлэлцүүлэн тус тус батлуулсан байна. Мөн тус яамны бодлогын газраас хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулж буй асуудлуудад хууль зүйн санал, зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан.</p>	30	30

51.	71.	<p>2.3.1.3. Салбарын хэмжээнд нийтэд дагаж мөрдөгдөх хэм хэмжээ тогтоосон актуудыг улсын нэгдсэн санд бүртгүүлнэ.</p> <p>1. Уул уурхай, геологи, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журмыг хянах, бүртгүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Хууль тогтоомжид нийцсэн байна</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>Салбарын санг баяжуулан ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 25 захиргааны хэм хэмжээний акт Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байна. Мөн Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн эмхтгэлийг Монгол, Англи хэл дээр бэлтгэж, хэвлэлтэд оруулахад бэлэн болсон.</p>	30	30
52.	72.	<p>2.3.1.4. Ашигт малтмал, хүнд үйлдвэр, газрын тосны асуудлаар Засгийн газрын зүгээс байгуулах гэрээ, хэлэлцээрт туслах чиг үүрэгтэй оролцох, судалгаа, шинжилгээ хийнэ.</p> <p>1. Гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулахад оролцох, санал өгөх, энэ чиглэлээр холбогдох албан тушаалтанд хууль, эрх зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Хууль тогтоомжийн хүрээнд ажиллана.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>ЗГ-ын 2018 оны 371 дүгээр тогтоолоор Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордод технологийн туршилт явуулахтай холбогдуулан мөнгөн хөрөнгө байршуулах харилцааг зохицуулсан аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээний төслийг СЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ЦЭК гэсэн байгууллагаас санал авч боловсруулсан ба тус гэрээг 2019.11.15-ны өдөр байгуулсан.</p>	30	30
53.	73.	<p>2.3.1.5. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хууль тогтоомжийг сурталчлан таниулна.</p> <p>1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хууль тогтоомжийг төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд сурталчлан таниулна.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Салбарын үйл ажиллагаа сайжрахад чиглэгдсэн байх;</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>“Уул уурхай, байгаль орчны салбарын бодлого, хууль тогтоомж, хэрэгжилт” сургалт, хэлэлцүүлгийг Баруун бүсийн Ховд, Говь-Алтай аймгуудын нутгийн захиргаа болон өөрөө удирдах байгууллага, иргэдэд, “Мон-Энко” ХХК, “Алтайн хүдэр” ХХК-д 2019.06.21-27-ны өдрүүдэд, Зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар аймгуудад 2019.09.18-09.20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулж, салбарын хууль тогтоомж, төрийн бодлого, тулгарч буй хүндрэлтэй асуудлуудын талаар илтгэл тавьж, оролцогчдыг гарын авлага ханган, салбарын үйл ажиллагааг сурталчилсан.</p> <p>Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх нийгмийн зөвшлийн хамтын хэлэлцээрийн төслийг боловсруулахад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэлэлцээрийг шинэчлэн байгуулсан.</p> <p>Салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг товхимол хэлбэрээр 100 ширхэгийг хэвлүүлж холбогдох аж ахуйн нэгж, байгууллагууд тараан сурталчлан таниулах ажлыг хийсэн.</p> <p>Тус яамнаас ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хэзээ нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 300 хувь хэвлүүлэн холбогдох хүмүүст</p>	30	30

			танилцуулж, хууль батлагдсан гарснаар эрдэс баялгийн салбарт ямар өөрчлөлт оруулах талаарх эерэг саналыг иргэд, аж ахуйн нэгж, Улсын Их хурлын гишүүдэд танилцуулсан.		
2.3.2. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах зорилтын хүрээнд:					
54.	74.	2.3.2.1. Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын батлан гаргах шийдвэрийн төсөл боловсруулахад мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгч ажиллана. 1. Шийдвэрийн төслийг хянах, цаг үеэ олсон, шуурхай, мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр ханган яамны үйл ажиллагаа, үр дүнг дээшлүүлнэ. Тоо хэмжээ: Өдөр тутам Чанар: Төсөлд хууль зүйн, санал, дүгнэлтийг өгсөн байна. Хугацаа: Тухай бүр	Сайд, Дэд сайд, ТНБД-ын шийдвэрийн төслийг батлуулахад тус бүр хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан.	30	30
55.	75.	2.3.2.2. Яамны хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмуудын нэгдсэн санг бүрдүүлнэ. 1. Сайдын тушаалаар батлагдсан уул уурхай, геологи, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмуудын нэгдсэн санг бүрдүүлнэ. Тоо хэмжээ: /-/ Чанар: Нэгдсэн сан үүссэн байна. Хугацаа: Тухай бүр	Тус яаманд 2019 оны 12 дугаар сарын байдлаар Ерөнхий сайдын захирамж 16, МУ-ын ЗГ-ын тогтоол 52, үүнээс тус яаманд үүрэг даалгавар өгөгдсөн 21, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл 69, үүнээс яаманд 38 шийдвэр тус тус хамаарч байна.	30	30
56.	76-77	2.3.2.3. Яам, яамны албан хаагчдын үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, шаардлагад хариу өгөх, шүүхэд төлөөлж ажиллана. 1. Яам, яамны удирдлагатай холбогдуулан гаргасан гомдол, шаардлагатай танилцаж хариу тайлбарын төслийг боловсруулж удирдлагад танилцуулсны үндсэн дээр хариуг тухай бүр өгнө. 2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, яамны удирдлагыг хуульд заасны дагуу шүүх, хууль хяналтын болон холбогдох бусад байгууллагад төлөөлнө. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль зүйн санал дүгнэлт, зөвлөмжийг гарган өгч, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна. Хугацаа: Тухай бүр	1. С.Ган-Очирын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 2. Б.Элбэгзаяагийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 3. "Модот-Уул" ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 4. Ч.Чулуунбатын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 5. УИХ-ын гишүүн С.Эрдэнийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 6. Д.Жавхланболдын нэхэмжлэлтэй иргэний хэрэг, 7. Ц.Одхүүгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 8. Ус-ургамал амьдрал НҮТББ-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 9. Натур Френдли ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг, 10. Чулуун эрдэнэс ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 11. Ганган гялбаа ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 12. Минторес ХХК нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 13. Голденхилл ХХК нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 14. Ноён Уулаа аврах хөдөлгөөн НҮТББ-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 15. ЧД-ын Цагдаагийн 1 дүгээр хэлтэст Эрүүгийн хуулийн 23.2.1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 191100475 дугаартай "Нью Войс"/New Voice/ нэртэй компанийн захирал Мартагийн үйлдсэн эрүүгийн хэрэгт эрүүгийн хэрэг, 16. Б.Батхүүгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг,	30	30

			17. “Бөхөг түргэн” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 18. Д.Даваадоржийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 19. “Жи Ди Би Эн” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг, 20. “Өнгөт Оюу” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг 21. “Персиммон” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт тус тус хариуцагч буюу яам, ЗГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдож, нэхэмжлэлийг гардан авч, хариу тайлбар, нотлох баримтыг тухай бүр ЗХАШШ-д хүргүүлж, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд оролцсон.		
57.	78-79	2.3.2.4. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын хариуг өгнө. 1. Дээд шатны болон төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн албан бичиг, шийдвэрийн төсөлд хууль зүйн үндэслэл бүхий санал өгнө. Тоо хэмжээ: /-/ Чанар: Хууль тогтоомжийн хүрээнд ажиллана. Хугацаа: Тухай бүр 2. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн гомдлын дагуу хууль зүйн дүгнэлт гаргаж удирдлагад танилцуулан хариуг хүргүүлнэ. Тоо хэмжээ: /-/ Чанар: Асуудалд бодитой, оновчтой дүгнэлт өгсөн байх; Хугацаа: Тухай бүр	2019 онд Хуулийн хэлтэст иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс 677 албан бичиг, 34 өргөдөл, гомдолд ирүүлснийг хугацаанд нь шийдвэрлэж, хариу албан бичиг хүргүүлсэн.	30	30
58.	80.	2.3.2.5. Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилт, харьяа байгууллагын үйл ажиллагааг газар дээр нь шалгах ажилд оролцоно. 1. Тайлан, мэдээллийг нь хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж боловсруулж, удирдлагуудад танилцуулна. Тоо хэмжээ: /-/ Чанар: Үйл ажиллагааны үр дүн, ажлын бүтээмж дээшлэхэд чиглэгдсэн байх; Хугацаа: Тухай бүр	ТНБД-ын баталсан удирдамжийн дагуу Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төсөл болон Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт, хөлсөөр ажиллах гэрээг шинэчлэх, мөн үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журмыг судалж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах ажлыг гүйцэтгэсэн. Холбогдох тайлан, санал дүгнэлтийг удирдлагад танилцуулсан. ЗГХЭГ болон Төвлөрлийг сааруулах төслөөс зохион байгуулсан яамны албан хаагчдын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, дахин хуваарилах ажлыг гүйцэтгэж, холбогдох тайланг 2019.10.18-ны өдөр ЗГХЭГ-ын холбогдох хүмүүст 100%-ийн үнэлгээтэй хамгаалсан.	30	30
2.4. Салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багц төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд:					
2.4.1. Салбарын санхүү эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого, боловсруулах, бодлогын удирдамжаар хангах зорилтын хүрээнд:					
59.	81.	2.4.1.1. Хөрөнгө оруулалт болон концессоор хэрэгжүүлэх санал болон хэрэгжиж буй төсөл,	1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар УУХҮС-ын төсөвт Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ	30	30

		<p>арга хэмжээний гүйцэтгэлийг хянан, зохицуулна.</p> <p>1. Төсөл, арга хэмжээний саналыг боловсруулах, хэрэгжиж буй арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, төсөл, арга хэмжээний судалгааг хийж, гүйцэтгэлийн явцын мэдээллээр удирдлагыг хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүрд зохицуулан шийдвэрлүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Гэрээний дагуу санхүүжүүлж, ил тод байдлыг хангасан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>боловсруулах зөвлөх үйлчилгээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсны дагуу зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/128 дугаар тушаалаар батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог УУХҮЯ-ны ТНБД-ын А/16 дугаар тушаалаар байгуулан сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлсэн. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны н/05/05 зөвлөмж, ЗГ-ын 2019 оны 196 дугаар тогтоолыг тус тус үндэслэн тус худалдан авалтыг төрийн нууцад хамааруулах болсонтой холбогдуулан УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны А/203 дугаар тушаалаар дээрх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, сонгон шалгаруулалтын ажлыг эхлүүлсэн.</p> <p>2. “Нейшнл трейдинг энд транспорт групп” ХХК-ийн концессын гэрээгээр хэрэгжүүлж буй “Рашаант дахь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих” төслийн явцтай танилцаж холбогдох шийдвэрийг гаргуулахаар болсон. Төслийн явцын тайланг 2019 оны 3 дугаар улирлын байдлаар хүлээн авч удирдлагад танилцуулсан ба 12 дугаар сард багтаан талуудын уулзалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.</p> <p>3. УУХҮС-ын Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи хайгуул судалгааны ажлын гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулж, удирдлагад танилцуулан, 2019 оны 11 сарын байдлаар 23.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p>		
60.	82.	<p>2.4.1.2. Салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлж, шаардлагатай зохицуулалтаар хангана.</p> <p>1. Салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлж, шаардлагатай зохицуулалтаар хангаж, төслүүдийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас шийдвэрлэх санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг улсын төсөвт тусгах, санхүүжилтийн хуваарийг батлуулан, батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж, тулгамдсан асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/</p> <p>Чанар: Тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлуулж, санхүүжүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн 2019 оны үйл ажиллагааны зардалд 841.15 төгрөгийн эх үүсвэрийг Сангийн сайдын 2019.01.31-ний өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 17 дугаар тушаалаар шийдвэрлүүлж, төсөл тус бүрээр үйл ажиллагааны зардлын төсвийг УУХҮЯ-ны ТНБД-аар батлуулж, батлагдсан төсвийн дагуу санхүүжүүлэх зөвлөмжөөр ханган ажиллаж, 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 323,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. ТХН-үүдийн 2019 оны зардлын төсөвт холбогдох зохицуулалтыг хийж, үйл ажиллагаатай нь уялдуулан санхүүжүүлж, 2019 оны 11 сарын байдлаар 667.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Мөн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл, Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл, шинээр хэрэгжүүлэх Газрын ховор элемент хайх, олборлох, боловсруулах асуудлын хууль, эрх зүйн судалгаа, эдийн засгийн үр ашгийн тооцоо хийх, судалгааны ажил гүйцэтгэх чиглэл зэрэг асуудлыг боловсруулах чиг үүрэг бүхий төслийг хэрэгжүүлэгч нэгжүүдийн 2020 оны үйл ажиллагааны нийт 1.5 тэрбум төгрөгийн зардлыг УУХҮС-ын 2020 оны төсвийн хязгаарын төсөл, 2021-2022 оны төсөөлөлд тусган УУХҮЯ-ны 2019.05.30-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 01/1607 дугаар албан бичгээр</p>	30	30

			Сангийн яаманд хүргүүлсэн. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар дээрх төслүүдийн 2020 оны үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулсан.		
2.4.2. Сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд:					
61.	83.	<p>2.4.2.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны болон харьяа газруудын зарлагын гүйлгээг төсөвт зардлын хүрээнд хянан хүлээн авч, баталгаажуулна.</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын батлагдсан төсвийн зардлыг төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тендерийн бичиг баримт, худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллана. Мөн геологи судалгааны ажлын санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хянаж, хуваарийн дагуу санхүүжүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: /-/ Чанар: Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна. Хугацаа: Тухай бүр</p>	<p>1/ УУХҮС-ын багцын данснуудын орлого, зарлагын гүйлгээг төрийн сангийн өдөр тутмын гүйлгээний төлбөрийн хүсэлт нэг бүртэй мөнгөн дүн, хүлээн авагчийн дансны дугаар, гарах байгууллагын дансны дугаар болон тухай байгууллагын 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны гарын үсэг тамга тэмдэгтэй тулган анхан шатны баримтын иж бүрдлийг тулган, гүйлгээг хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангилал тус бүрээр хянан баталгаажуулсан.</p> <p>2/ Төрийн сангийн нэгжээр 2,622 төлбөрийн хүсэлтээр нийт 54,176,972,079.67 төгрөгийн гүйлгээ хийсэн. Үүнээс УУХҮЯ-ны 100900018001 данснаас 4,492,499,018.60 төгрөг, геологийн байгууллагын 100900018006 данснаас 18,863,311,638.00 төгрөг, АМГТГ-ын ашигт малтмал, газрын тосны газрын 100900018007 данснаас 5,848,801,292.59 төгрөгийн гүйлгээ, АМГТГ-ын ТЗ-ын төлбөр, үйлчилгээний орлогын 100900018008 тоот данснаас 2,401,106,669.14 төгрөгийн гүйлгээ, АМГТГ-ын сургалтын урамшууллын 100900018009 тоот данснаас 2,255,961,137.18 төгрөгийн гүйлгээ, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн 100900018010 тоот данснаас 928,524,280.84 төгрөгийн гүйлгээ, УУХҮЯ-ны барьцаа хөрөнгийн 100900018350 тоот данснаас 55,923,972.00 төгрөгийн гүйлгээ, УУХҮЯ-ны техник хяналтын 100900018370 тоот данснаас 227,468,902.00 төгрөгийн гүйлгээ, УУХҮЯ-ны нэмэлт санхүүжилтийн 100900018403 тоот данснаас 35,973,150.00 төгрөгийн гүйлгээ, АМГТГ-ын сонгон шалгаруулалтын 10090008408 тоот данснаас 18,679,903,940.00 төгрөгийн гүйлгээ, АМГТГ-ын нэмэлт санхүүжилтийн 100900018409 тоот данснаас 387,498,079.22 төгрөгийн гүйлгээ тус тус шилжүүлсэн.</p> <p>3/ УУХҮЯ болон "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл" хэрэгжүүлэгч нэгж, "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл" хэрэгжүүлэгч нэгж, АМГТГ-ын 2019.01.02-12.10-ны өдрийн зарлагын гүйлгээний баримтын төлбөрийн хүсэлт нэг бүрийг ня-бо журналтай тулган баталгаажуулж стандартын дагуу архивын баримт үүсгэсэн.</p> <p>4/ УУХҮС-ын багцын данснуудын орлого, зарлага, ня-бо журнал болон төсвийн багцын үлдэгдлийг өдөрт нь авч шалгаж мемориалын баримт үүсгэн ажиллаж байна. Нийт 2622 ширхэг төлбөрийн хүсэлтийг эмхэлж архивын баримт үүсгэсэн.</p>	30	30
62.	84.	2.4.2.2. Сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2019 оны төсвийн батлагдсан багцад тусгагдсан санхүүгийн нөөцийн санхүүжилтийн хуваарийг байгууллага бүрээр, сар, улирлын	1/ УУХҮС-ын 2019 оны батлагдсан төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, 24.6 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардал, 12.3 тэрбум төгрөгийн урсгал зардлын санхүүжилтийн болон 404.05 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэлтийн хуваарийн саналыг	30	30

		<p>хуваарьтай боловсруулж батлуулах, 2019 оны батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг олгоно.</p> <p>1. Сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2019 оны төсвийн батлагдсан багцад тусгагдсан санхүүгийн нөөцийн санхүүжилтийн хуваарийг батлуулж, батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг гаргах, батлагдсан сар улирлын хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөнд хяналт тавьж, төлөвлөгөөний биелэлтийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 12 удаа Чанар: Хуваарийг батлуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна. Хугацаа: Сар бүр</p>	<p>дараах байдлаар боловсруулж, УУХҮЯ-ны 2018.12.25-ны өдрийн “Санхүүжилтийн хуваарийн санал хүргүүлэх тухай” 01/3478 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • УУХҮЯ-ны 2019 оны зардлын санхүүжилтийн хуваарийн санал; • АМГТГ-ын 2019 оны зардлын санхүүжилтийн хуваарийн санал; • 2019 онд гүйцэтгэх геологи, хайгуул судалгааны ажлын санхүүжилтийн хуваарийн санал; • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарийн санал; • АМГТГ-аас 2019 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарийн санал; <p>2/ Санхүүжилтийн хуваарийг Сангийн сайдын 2018.12.28-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 309 дүгээр тушаалаар батлуулж, Сангийн яамны 2018.12.28-ны өдрийн “Төсвийн хуваарь хүргүүлэх тухай” 4-1/8173 дугаар албан бичгээр хүлээн авч, шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ил тод байдлыг ханган ажилласан.</p> <p>3/ 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийн зохицуулалтыг тухай бүрд хийж, санхүүжилтийн хуваарийг Сангийн сайдын тушаалаар батлуулж, 2019 оны 11 сарын байдлаар нийт 34.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p>		
63.	85-86	<p>2.4.2.3. Сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч/-ын төсвийн багцын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн баталгаажуулж дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/-д танилцуулан хуулийн дагуу холбогдох газруудад хүргүүлнэ.</p> <p>1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар гарган тайлбар, тодруулгын хамт холбогдох газруудад хүргүүлнэ. Сайдын багцын харьяа байгууллага, төслүүдийн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шалгаж хүлээн авна. Сайдын багцын нэгдсэн санхүүгийн тайланг гаргаж, удирдлагад танилцуулан, баталгаажуулна.</p> <p>Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Хуулийн хугацаанд нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн байна. Хугацаа: Хагас, бүтэн жилээр</p> <p>2. Сайдын багцын тайланд нэгтгэгддэг Төрийн өмчит үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдэд</p>	<p>1. Сайдын багцын харьяа байгууллага, төслүүдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2019.01.25-ны өдрийн дотор, аудитлагдсан тайланг 2019.02.25-ны өдрийн дотор шалган, нийт 17 тайланг хүлээн авсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын хөрөнгө оруулалт, улсын төсвөөр хийгдэх геологи судалгааны ажлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган удирдлагад танилцуулж, баталгаажуулан 2019.04.05-ны өдөр Үндэсний аудитын газарт аудит хийлгэхээр хүргүүлсэн бөгөөд “Зөрчилгүй” дүгнэлт гарсан. Аудитлагдсан тайланг сайдын багцын тайланд нэгтгэн Засгийн газрын нэгдсэн тайланд нэгтгүүлэхээр Сангийн яаманд 2019.04.25-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>2. Сайдын багцын 12 ТӨҮГ-ийн санхүүгийн тайланг сайдын нэгдсэн тайланд нэгтгүүлсэн тайлангийн үзүүлэлтүүдэд дүгнэлт хийж удирдлагад танилцуулсан.</p>	30	30

		<p>дүн, шинжилгээ хийж, удирдлагад танилцуулан тулгамдсан асуудлаар холбогдох шийдвэрийг гаргуулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын байгууллагуудын ерөнхий нягтлан бодогч, дотоод аудит хариуцсан ажилчдад Сангийн яам болон Үндэсний аудитын газартай хамтран мэргэжил, арга зүйн сургалтыг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Дүн, шинжилгээ хийгдсэн байна.</p> <p>Хугацаа: II улиралд</p>			
64.	87.	<p>2.4.2.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2022 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах, Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, холбогдох бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний үр дүн, үр ашгийг тооцож, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн аргачлалын дагуу Уул уурхайн салбарын 2020-2022 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлж Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, үүнтэй холбогдсон бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Хуулийн хугацаанд нэгтгэж, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох</p> <p>Хугацаа: 3-6 дугаар сард</p>	<p>1/ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дүгээр заалтын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ЗГ-т хүргүүлдэгтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбараас дунд хугацааны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахад шаардлагатай мэдээллийг холбогдох маягтын дагуу боловсруулж, танилцуулга, тайлбарын хамт ирүүлэх тухай УУХҮЯ-ны 2019.03.01-ний өдрийн “Төсвийн орлогын төсөөлөл боловсруулахад мэдээлэл ирүүлэх тухай” 03/553 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлж, зөвлөмжөөр хангасан.</p> <p>2/ МУ-ын 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2023 оны төсөөлөл, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл боловсруулж буйтай холбогдуулан уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, АМГТГ-аас ирүүлсэн улсын төсөвт төвлөрүүлэх орлогын тооцооллыг СЯ-нд хүргүүлж, тайлбар, үндэслэлээр хангасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын 2018 оны гүйцэтгэл, 2019-2021 оны төсөөлөл • Уул уурхайн салбарын голлох ашигт малтмалын олборлолтын хэмжээ /2020 оны төсөөлөл/ • Уул уурхайн салбарт хүүрсний олборлолтын хэмжээ /2020 оны төсөөлөл/ • Хайгуулын болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, нөхөн төлбөр, бусад үйлчилгээний орлогын төсөөлөл • Тусгай зөвшөөрлийн төлбөрийн 2020 оны орлогын төлөвлөгөөний төсөөлөл • Газрын тосны орлогын төсөөлөл /2020-2022 он/ • 2020 онд улсын төсөвт орох улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын нөхөн төлбөрийн хэмжээний төсөөлөл • Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын 2020-2022 оны газрын тосны борлуулалтын орлогын тооцоо 	30	30

			<ul style="list-style-type: none"> • Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хуваарилалтын тооцоо • Гэрээлэгч компаниудын 2020 онд төлөх тусгай зөвшөөрлийн төлбөрийн хуваарилалтын тооцоо • Бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын 2018 оны гүйцэтгэл, 2019 оны хийгдэж буй гүйцэтгэл, 2020-2022 оны төсөөлөл 2/ МУ-ын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоомжийн төсөл, холбогдох танилцуулгатай танилцаж, саналыг УУХҮЯ-ны 2019.04.23-ны өдрийн “Санал хүргүүлэх тухай” 01/1158 дугаар албан бичгээр, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны тооцоо, судалгааг хийхэд зориулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын дунд хугацааны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын мэдээллийг УУХҮС-ын 2019.03.29-ний өдрийн 01/845 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Уг мэдээлэлд 2020 онд 6.1 сая баррель газрын тос экспортлохоор тооцож хүргүүлсэн байхад МУ-ын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг тооцоходоо газрын тосны экспортын биет хэмжээг 2.05 сая баррелиар нэмэгдүүлж, 8.2 сая баррелиар тооцсон байх тул УУХҮЯ-наас хүргүүлсэн газрын тосны олборлолтын биет хэмжээний мэдээллийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийн үзүүлэлтийг тооцоход харгалзан үзэх талаар албан бичиг хүргүүлсэн. 		
65.	88-89	<p>2.4.2.5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсөөллийг боловсруулан Сангийн яаманд оруулж, Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, үүнтэй холбогдсон бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсөөллийг батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан Улсын төсөвт төвлөрүүлэх орлого, урсгал зардал, хөрөнгө оруулалт тус бүрээр боловсруулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Тооцоо, үндэслэлтэй дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байх</p> <p>Хугацаа: 8/15-ны дотор</p>	<p>1/ УУХҮЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсөөллийг батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан Улсын төсөвт төвлөрүүлэх орлого, урсгал зардал, хөрөнгө оруулалт тус бүрээр боловсруулж, УУХҮС-ын 2019.08.15-ны өдрийн “2020 оны төсвийн төсөл хүргүүлэх тухай” 01/2326 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Үүнд: МУ-ын Төсвийн тухай хууль, МУ-ын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, МУ-ын ЗГ-ын 2019 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн хязгаарыг батлах тухай” 254 дүгээр тогтоолыг баримтлан УУХҮС-ын 2020 оны төсвийн төслийг боловсруулсан.</p> <p>1. Төсвийн ерөнхийлөн захирагч-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2020 оны төсвийн төслийн санал,</p> <p>2. Төсвийн ерөнхийлөн захирагч-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын 2020 оны төсвийн төслийн санал, байгууллага тус бүрээр,</p> <p>3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт МУ-ын төсвийн хөрөнгөөр 2020-2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт,</p>	30	30

		<p>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсөөллийг Сангийн яаманд хүргүүлэн хянуулж, холбогдох тайлбар, үндэслэлээр ханган хамгаалж Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, үүнтэй холбогдсон бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Тооцоо, үндэслэлтэй дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байх</p> <p>Хугацаа: 9/15-11/15-ны дотор</p>	<p>4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн геологи хайгуул, судалгааны зардлын 2020 оны төсөв, 2021-2022 оны төсөөлөл,</p> <p>5. АМГТГ-аас 2020-2022 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төсөөлөл,</p> <p>6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөл,</p> <p>2/ УУХҮС-ын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсөөллийг СЯ-нд хүргүүлэн хянуулж, холбогдох тайлбар, үндэслэлээр ханган хамгаалж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, үүнтэй холбогдсон бүх тооцоо, үндэслэлийг гаргаж яамны удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажилласан.</p> <p>2020 оны төсвийн тухай хуулиар АМГТГ-аас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 335.1 тэрбум төгрөгөөр, УУХҮС-ын багцын нийт зарлагыг 42.9 тэрбум төгрөгөөр тус тус батлуулсан. Үүнээс 24.62 тэрбум төгрөгийг геологи, хайгуул судалгааны зардалд, 6.84 тэрбум төгрөгийг УУХҮЯ-ны зардалд, 7.25 тэрбум төгрөгийг АМГТГ-ын зардалд, 4.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулахаар батласан.</p>		
66.	90.	<p>2.4.2.6. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер зарлах, дүгнэх, шалгаруулах, гэрээ байгуулах хуваарийг боловсруулан батлуулж, худалдан авах үйл ажиллагааг зөвлөмжөөр ханган, хуулийн хугацаанд тайлагнана.</p> <p>1. 2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тендер зарлах, дүгнэх, шалгаруулах, гэрээ байгуулах хуваарийг боловсруулан батлуулж, худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу явуулж, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системд тухай бүрд нь байршуулж ил, тод байдлыг хангаж, хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнана. ХШҮДАГ-тай хамтран Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд /Ашигт малтмал, газрын тосны газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, цахим худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй танилцаж дүгнэлт гаргаж танилцуулах, зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмжөөр ханган ажиллах</p>	<p>1/ УУХҮС-ын 2018.12.12-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/258 дугаар тушаалаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>2/ Батлагдсан төлөвлөгөөг УУХҮЯ-ны 2018.12.31-ний өдрийн “Тушаал хүргүүлэх тухай” 03/3508 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, ил тод байдлыг ханган ажиллахыг зөвлөсөн.</p> <p>3/ Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг УУХҮЯ-ны 2018.12.31-ний өдрийн “Тушаал хүргүүлэх тухай” 03/3509 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, Сангийн яамаар баталгаажуулуулсан ил тод байдлыг хангасан. Мөн өдөр тутмын сонинд тавьж, яамны вейб сайтад байршуулсан.</p> <p>4/ УУХҮЯ-ны ТНБД-ын 2019.02.13-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалаар АМГТГ-ын 2019 оны төсөвт батлагдсан сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын төлөвлөгөөг батлуулж, УУХҮЯ-ны 2019.02.19-ны өдрийн “Тушаал хүргүүлэх тухай” 03/443 дугаар албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн.</p> <p>5/ УУХҮС-ын МУ-ын төсвийн хөрөнгөөр 2019 онд худалдан авах геологи хайгуул, эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон бичиг хэргийн жагсаалт, УУХҮЯ-ны хэвийн үйл ажиллагааг хангах, бүтэц</p>	30	30

		<p>Тоо хэмжээ: Батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэж тайлагнана. Чанар: Төлөвлөгөөг батлуулж, ил тод байдлыг хангасан байх Хугацаа: Тухай бүр</p>	<p>зохион байгуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2019 оны урсгал зардлын батлагдсан төсөвт багтаан худалдан авах бараа үйлчилгээний жагсаалтыг тус тус УУХҮС-ын 2019.01.07-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлуулж, батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахад зөвлөмжөөр хангасан.</p> <p>6/ УУХҮЯ-ны хэвийн үйл ажиллагааг хангах, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, салбарын урт, дунд хугацааны бодлого, үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийг сурталчлах зорилгоор 2019 онд хийх урсгал засварын жагсаалт болон худалдан авах тавилга, тоног төхөөрөмж, мэдээлэл сурталчилгааны жагсаалтыг тус тус УУХҮЯ-ны ТНБД-ын 2019.05.31-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/91 дугаар тушаалаар батлуулж, батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахад зөвлөмжөөр хангасан.</p> <p>7/ МУ-ын ЗГ-ын 2019.01.30-ны өдрийн “Эх оронч худалдан авалтын жил” болгох тухай 59 дүгээр тогтоол болон тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор УУХҮС-ын 2019.05.17-ны өдрийн “Нарийвчилсан төлөвлөгөө батлах тухай” А/123 дугаар тушаалаар үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жил, III улирлын байдлаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>8/ УУХҮС-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох өөрчлөлтийг оруулж батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, Сангийн ямаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>9/ УУХҮС-ын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, улирал бүрээр тайланг гарган СЯ-нд хүргүүлж, сар бүр худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.</p> <p>10/ МУ-ын 2020 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан УУХҮС-ын 2019.11.22-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/223 дугаар тушаалаар УУХҮС-ын МУ-ын төсвийн хөрөнгөөр 2020 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>11/ УУХҮС-ын 2019.11.22-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” А/222 дугаар тушаалаар УУХҮС-ын МУ-ын төсвийн хөрөнгөөр 2020 онд худалдан авах геологи, хайгуул, эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон бичиг хэргийн жагсаалтыг батлуулж ерөнхий төлөвлөгөөнд тусгасан.</p>		
67.	91.	<p>2.4.2.7 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. 1. Хуулийн дагуу худалдан авах ажиллагаа, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын талаарх</p>	<p>Хуулийн дагуу Уул уурхайн олборлолт хөтөлбөр, худалдан авах ажиллагаа, төсвийн талаарх мэдээллүүдийг Шилэн дансанд хугацаанд нь байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан. Үүнд:</p>	30	30

		<p>мэдээллүүдийг Шилэн дансанд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллана.</p> <p>Тоо хэмжээ: Чанар: Холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байх Хугацаа: Жилдээ</p>	<p>-ТЕЗ-ын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт/тухайн оны төлөвлөгөө/ - ТЕЗ-ын төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт/өнгөрсөн оны гүйцэтгэл/ -ТЕЗ-ын тухайн жилийн төсөвт орсон 4 удаагийн нэмэлт өөрчлөлт; -ТЕЗ-ын 2019, 2020 оны батлагдсан төсөв; -ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны 2019, 2020 оны батлагдсан төлөвлөгөө; -ТЕЗ-ын хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл/сар бүр/ -ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны 2018 оны тайлан; -ТЕЗ-ын худалдан авах ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн; -УУХҮЯ-ны тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; -УУХҮЯ-ны 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн ерөнхий мэдээлэл; -АМГТГ-аас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт -УУХҮЯ-ны худалдан авах ажиллагааны тайлан; 2/ УУХҮС-ын 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх УУХҮЯ, Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, УУХҮС-ын 2018 оны нэгтгэсэн тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл.</p>		
ГУРАВ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЗОХИЦУУЛАХ; УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
3.1. Геологийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:					
88.	122-123	<p>3.2.9. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.</p> <p>1. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилэн батлуулах, зөвлөлийн хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна. Хугацаа: Жилдээ</p> <p>2. 2019 онд хэрэгжиж буй 4, үр дүнгийн тайлан хамгаалах 3 төслийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанар</p>	<p>1. УУХҮЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны анхдугаар хуралдааныг 2019.03.14-ний өдөр зохион байгуулсан. Хурлаас гаргасан шийдвэрийг БСШУСЯ-д 2019.04.04-ний өдрийн 01/931 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. 2019 оны 05 дугаар сард УУХҮЯ-ны захиалгаар ШУТСангийн санхүүжилтээр 2020 оноос хэрэгжүүлэх төслийн саналыг БСШУСЯ-ны шинжлэх ухаан, технологийн зөвлөлд танилцуулан, Монгол орны хэмжээнд тархсан "Критикал металлуудын хүдэржилт, хэтийн төлөвийн судалгаа (ГХЭ, ЦАБ, Li, Co, Ta, Nb, Gr, In, Mg гм)", "Нуурын хөндийн хагарлын зүй тогтлын судалгаа" гэсэн 2 судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр болсон. 2019.06.11-ний өдөр дээрх 2 сэдвийн ажлын даалгаврыг боловсруулан БСШУСЯ, ШУТСанд хүргүүлсэн.</p> <p>2. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019.03.14-ний өдрийн хуралдаанаар Түүхий нүүрсний шахсан ба шингэрүүлсэн нийлэг байгалийн хийгээр орлуулах технологийн судалгаа, Сэргээгдэх</p>	30	30

		хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төслийн тайланг хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Хугацаа: Жилдээ	эрчим хүчний технологийн түүхий эдийн судалгаа, Төмрийн хүдрээс төмөрлөг бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн судалгаа, бүтээгдэхүүний стандарт, Ашигт малтмалын ордыг ашиглах дэвшилтэт, шинэ технологи боловсруулан нэвтрүүлэх судалгаа, Монгол орны Газрын ховор элементийн ордын хүдрийг баяжуулах технологи боловсруулах сэдэвт 5 төслийн явцын тайлан, Монгол орны төмрийн хүдрийн зарим ордуудыг түшиглэн өндөр чанартай ган гарган авах технологи, Субдукцын бүсийн геологи, магматизм, хүдэржилтийн судалгаа хэтийн төлөв, Монгол орны говийн бүсийн геологийн сонирхолтой тогтоц, тулгуур зүсэлтийн судалгаа, түүний хамгаалалт сэдэвт 3 төслийн эцсийн тайланг хэлэлцэн хүлээн авсан. УУХҮЯ, БСШУСЯ, ШУТС төсөл хүлээн актыг үйлдэж баталгаажуулсан.		
89.	124.	3.2.10. Геологи-ашигт малтмалын мэдээллийг нэгтгэн боловсруулна. 1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж нөөц нь бүртгэгдсэн ордуудыг ашигт малтмалын төрлөөр ангилах, бүс нутгийн хэмжээнд мэдээллийг нэгтгэн боловсруулах, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Мэдээлэл нэгтгэгдсэн байна. Хугацаа: Жилдээ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж нөөц нь бүртгэгдсэн ордуудын жагсаалтыг гаргаж, ашигт малтмалын төрлөөр нь ялгаж, мэдээллийг нэгтгэн тухай бүр удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.	27	27
3.3. Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах гол зорилтын хүрээнд:					
94.	129.	3.3.5. "Хариуцлагатай уул уурхай" зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана. 1. Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Байгаль орчны засаглал хөтөлбөрийн төсөл, Уул уурхайн үндэсний ассоциаци, Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхай Төрийн бус байгууллагатай хамтран хариуцлагатай уул уурхайг үнэлэх арга аргачлалыг боловсруулах, сурталчилан таниулах, мэдээллэх талаар хамтран ажиллана. Тоо хэмжээ: Тухай бүр, Чанар: Холбогдох байгууллагатай хамтран ажилласан байна Хугацаа: Жилдээ	"Хариуцлагатай уул уурхай" зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБХХ-ийн Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал төсөл, Монголын уул уурхайн үндэсний ассоциа, Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачлага ТББ зэрэг байгууллагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөг баталсан. МУ-ын уул уурхайн салбарт хариуцлагатай уул уурхайн сайн жишгүүдийг хөхүүлэн дэмжих, нэвтрүүлэх, даган мөрдөж бодитой төлөвшүүлэх, улмаар салбарын тогтвортой хөгжлийн төлөө хамтран ажиллах зорилгоор Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодексын хүрээнд томоохон аж ахуйн нэгжүүдтэй "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг байгуулсан.	30	30
95.	130.	3.3.6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны 2019 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулан, салбар хорооны хурлыг 4 удаа	30	30

		<p>салбар хорооны үйл ажиллагааг зохион байгуулна.</p> <p>1. Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хурлыг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>хуралдуулсан. 2019 онд салбар хорооны хэмжээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>Уул уурхайн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрхзүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд одоо мөрдөгдөж буй аюулгүй ажиллагааны дүрмүүдийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг шинэчлэн боловсруулж, УУХҮС-аар батлуулан ХНХСайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ХНХЯ-руу хүргүүлсэн. Мөн Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг боловсруулан, олон нийтээс санал авахад бэлэн болсон.</p> <p>Мэргэшсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо /МОШПА/-тай хамтран салбарын 80 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага ISO45001:2018 стандартыг танилцуулах, мэдлэг олгох сургалтыг 2019.05.10-нд өдөр "Монголын Алт" ХХК-ийн төв байранд зохион байгуулсан.</p> <p>2019.10.01, 02-ны өдрүүдэд Корпорейт конвеншн төвд зохион байгуулагдсан НЭН ТҮРҮҮНД ХАБ-2019 бага хуралд УУХҮЯ-наас Уул уурхайн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрхзүйн орчин, салбар хорооны үйл ажиллагааны талаар илтгэл танилцуулж, нэгдсэн хуралдаан болон салбар хуралдаан, хэлэлцүүлэгт оролцсон.</p> <p>Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбоо "Industri ALL Global Union" Олон Улсын Үйлдвэрчний байгууллагатай хамтран 2019.10.28-ны өдөр зохион байгуулсан ОУХБ-ын Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуй 176 дугаар конвенцын хэрэгжилтийн талаарх зөвлөгөөн, хэлэлцүүлэгт илтгэл тавьж оролцсон.</p> <p>-УУХҮ-ийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны гишүүд Канад Улсын Бритиш Колумб мужийн Эрчим хүч, уул уурхай, газрын тосны нөөцийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн стратегийн яамны төлөөллүүдтэй 2019.11.19-ний өдөр уулзалт хийж, МУ-ын уул уурхайн салбарын ХАБЭА-н өнөөгийн байдал, эрх зүйн орчны талаар танилцуулан, Бритиш Колумб мужийн Уул уурхайн ХАБЭА-н асуудал хариуцсан төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, хууль эрх зүйн чиглэлээр мэдээлэл авч туршлага солилцсон.</p>		
96.	131.	<p>3.3.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан.</p> <p>Дэд хөтөлбөрт тусгагдсаны дагуу Мэргэшсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо /МОШПА/-тай хамтран салбарын 80 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын</p>	30	30

		<p>1. Дэд хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулсан байна. Хугацаа: II улиралд</p>	<p>удирдлагуудад Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага ISO45001:2018 стандартыг танилцуулах, мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Уул уурхайн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрхзүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх ажлын хүрээнд одоо мөрдөгдөж буй аюулгүй ажиллагааны дүрмүүдийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг шинэчлэн боловсруулж, УУХҮС-аар батлуулан ХНХС-ын хамтарсан тушаалаар батлуулахаар ХНХЯ-руу хүргүүлсэн. Мөн Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийн төслийг боловсруулан, олон нийтээс санал авахад бэлэн болсон. Уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд Google form ашиглан эхний судалгааг гарган авч мэдээллийг 2018 оныхоор нэгтгэн боловсруулаад байна. Мэдээллийн сангийн бүтэц болон үйл ажиллагааны талаар Канад Улсын Бритиш Колумб мужийн албаны хүмүүсээс туршлага судалсан.</p>		
98.	133-134	<p>3.3.9. Геологи, уул уурхайн салбарт гадаадаас ажиллах хүч авах ажилд хяналт тавьж, мэдээллийн сан бий болгоно. 1. Гадаадаас авах ажиллах хүчний талаар ирүүлсэн хүсэлтийг судалж, холбогдох байгууллагад уламжилна. /АХГГАХМАТ-8.2.6, АМТХ-43.1, 43.2/ Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Холбогдох байгууллагад уламжилсан байна. Хугацаа: Тухай бүр 2. Гадаадаас авах ажиллах хүчний талаар мэдээллийн санг бий болгоно. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Мэдээлэл нэгтгэсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1.Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалтын дагуу гадаадаас ажиллах хүч оруулж ирэх хүсэлт ирүүлсэн нийт 64 ААН-ийн нийт 81 удаагийн хүсэлтийг холбогдох материалын хамт судлан БНХАУ, Австрали, ХБНГУ, ӨАБНУ, БНЭУ, Канад, Финлянд, ИБУИНВУ, Япон, зэрэг улсаас 2517 хүнийг түр хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх талаар санал боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжилсан. 2.Уул уурхайн салбарт 2019 онд гадаадаас авсан ажиллах хүчний талаар мэдээллийн сан үүсгэн хөтөлсөн.</p>	30	30
100.	136.	<p>3.3.11. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна. 1. Хуулийн үйлчлэлд хамрагдсан тусгай зөвшөөрлүүдийн асуудлыг шийдвэрлэнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Хууль 2009 онд батлагдсанаас хойш уг хуулийн үйлчлэлд нийт 656 ашиглалтын тусгай зөвшөөрөл хамрагдаж, үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болсон. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> • Нүүрсний 79 тусгай зөвшөөрөл, • Барилгын материалын 126 тусгай зөвшөөрөл, • Бусад /алт, мөнгө, зэс, өнгөт метал г.м/ 451 тусгай зөвшөөрөл тус тус байсан. <p>АМГТГ-ын үндсэн чиглэлд дээрх 530 ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарч байна. Үүнээс :</p>	30	30

			<ul style="list-style-type: none"> Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй болсон 261 тусгай зөвшөөрөл байна. Эдгээр нь: Засгийн газрын 289 дүгээр тогтоолоор давхцалгүй болсон 172, цуцлагдсан 78, стратегийн орд 11 байна. Хуулийн үйлчлэлд хамрагдан үлдсэн 190 ашиглалтын тусгай зөвшөөрөл шийдвэрлэгдэх шатандаа явж байна. <p>Усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалтай хэсгийг хасуулж, солбицолд өөрчлөлт оруулах 27, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулсан эсэх талаар дүгнэлт гаргах 27, ойн тухай хуулиар зохицуулах 39, цуцлах 43 байгаа бөгөөд үүнээс нөхөх олговортой цуцлах 27, нөхөх олговоргүй цуцлах 16, (давсны орд 6), гэрээ байгуулах 54, үүнээс гэрээ баталгаажсан 37, гэрээ баталгаажуулах шатандаа яваа 12, гэрээ байгуулах 5 байна.</p>		
101.	137-138	<p>3.3.12. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.</p> <p>1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: /-/ Чанар: Хяналт тавьж, хуралдааныг зохион байгуулсан байна. Хугацаа: Тухай бүр</p> <p>2. Хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмыг боловсруулж, батлуулна.</p> <p>2. Хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа болон үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан, устгасан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэр төрөл, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмыг боловсруулж, батлуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1. Мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг 5 удаа зохион байгуулж, нийт 31 асуудал хэлэлцэн дүгнэлт гаргасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийн сунгалт – 13 - Шинээр олгосон – 5 - ТЭЗҮ хэлэлцэн, хүлээн авсан - 9 <p>2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, худалдах үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрлийн мэдээллийн сан байгуулах ажил хийгдэж байна. Үүнд: Үндэсний дата төвтэй 200 GB-ын багтаамжтай зохиомол сервер ашиглах гэрээ байгуулсан.</p> <p>"Аминнетворкс" ХХК Мэдээллийн нэгдсэн сангийн программ хангамжийг нийлүүлэхээр тендерт шалгарсан, гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн бөгөөд гэрээг дүгнэж, акт үйлдсэн. Хуулийн дагуу мэдээллийн нэгдсэн санг хөтлөх журмыг боловсруулж байна.</p>	30	30
ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭР, ГАЗРЫН ТОСНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ					

АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:

4.2. Хүнд үйлдвэрийн салбарт хар ба өнгөт төмөрлөгийн болон машин байгууламж, металл хийцийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгох, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:

137.	182-184	<p>4.2.20. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлох судалгаа хийнэ.</p> <p>1. Өмнийн говийн газрын доорх усны ордын нөөцийн зураглал гаргана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Усны нөөцийн зураглал гарсан байна. Хугацаа: II улиралд</p> <p>2. Өмнийн говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй томоохон төслүүд /Тавантолгойн орд, Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр г.м/-ийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлно. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Үйлдвэр байгуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. Хугацаа: Жилдээ</p> <p>3. Хэрлэн говь төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх боломжит хувилбарыг тодорхойлно. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1. БОАЖЯ-ны Усны нөөцийн архивд хадгалагдаж байгаа тайлангуудад судалгаа хийж, Өмнөговь аймгийн газрын доорх усны 51-н ордын байршлын зураглалыг 1:2,500,000 масштабээр гаргаж, Таван толгойн нүүрсний уурхайгаас 100, 150, 200 км радиус доторх газрын доорх усны ордуудын байршил бусад шаардлагатай мэдээллийг нэгтгэн боловсруулсан.</p> <p>2. Өмнийн говийн бүсэд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй төслүүдийн ус хангамжийн асуудлыг дараах байдлаар шийдвэрлээд байна. Үүнд: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг судалж, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос үйлдвэрлэлийн С1 зэргээр үнэлсэн 800 л/с нөөцөөс 220 л/с усны хэрэглээг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх боломжтой талаар 2019.03.26-ны өдрийн 01/1787 дугаар албан бичгээр ирүүлсэн. Уг мэдээллийг “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газар болон Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд 2019.04.05-ны өдрийн 03/952, 03/953 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн.</p> <p>Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардагдах усыг Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах талаар МУ-ын ЗГ-ын 2019.05.12-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд ЗГ-аас уг асуудлыг ҮАБЗ-д танилцуулан холбогдох шийдвэр гаргуулахаар тэмдэглэл гарсан. Үүний дагуу ҮАБЗ-ийн 2019.06.04-ний өдрийн хуралдаанд уг асуудлыг танилцуулсан бөгөөд ҮАБЗ-ийн 21/14 дүгээр зөвлөмж гарсан. Улмаар ЗГ-ын 2019.07.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 2019 оны 284 дүгээр тогтоолоор батлуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд БОАЖЯ-ны ТНБД бөгөөд Усны нөөцийн зөвлөлийн дарга Ц.Цэнгэлд 2019.09.07-ны өдрийн 03/2543 дугаар “Санал хүргүүлэх тухай” албан бичгээр хүргүүлсний дагуу Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд ахуйн хэрэгцээнд 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг шийдвэрлэсэн ЗГ-ын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлтийг “Монгол Ус” ТӨААТҮГ-аар гаргуулж, Умард говийн гүвээт</p>	30	30
------	---------	---	--	----	----

			<p>Халхын дунд талын сав газрын захиргаанаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллахыг зөвлөсөн зөвлөмжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.09.23-ны өдрийн 03/6576 дугаар албан бичгээр ирүүлснийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-нд 2019.10.07-ны өдрийн 03/2803 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>3. Хэрлэн-говь төслийн ТЭЗҮ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт шаардлагатай санхүүжилтийг 2020 оны улсын төсөвт суулган, шийдвэрлүүлэх тухай саналыг 2019.09.02-ны өдрийн 01/2473 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн “Өмнийн говьд байгуулагдах Уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх, Хэрлэн-говь төслийн санхүүжилтийн талаар зөвлөлдөх, уулзалт ярилцлагыг салбарын мэргэжилтнүүд, компаниудын төлөөлөл болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, УУХҮЯ-ны ТЗУГ-ын дарга, СТБГ-ын дарга, ГУУБХЗГ-ын дарга, УУХ-ын дарга, ХҮГТБХЗГ-ын дарга, ХҮХ-ийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан 2019.11.15-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан, 2020 оны I улиралд багтаан шаардлагатай санхүүжилтийг уул уурхай, хүнд үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагаас гаргуулан шийдвэрлүүлэхээр урьдчилсан байдлаар тохиролцон, ЗГ-ын тогтоолын төслийг, холбогдох материалын хамт боловсруулан, ажиллаж байна.</p>		
4.3. Газрын тосны салбарын хууль тогтоомж, бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:					
138.	185.	<p>4.3.1. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-т заасан “газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулж, батлуулна.</p> <p>1. Дүрмийн төслийг шинэчлэн боловсруулан, сайдын тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Дүрмийн төслийг боловсруулж батлуулсан байна.</p> <p>Хугацаа: IV улиралд</p>	<p>1. Энэ ажлын хүрээнд АМГТГ-аас ОХУ-ын “Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн орчуулгад тулгуурлан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулсан. Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан тус дүрмийн төслийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан ба дүрмийн төсөлтэй холбоотой тодорхой санал, шүүмжүүдийг ирүүлсэн. Энэхүү дүрмийн орчуулгын эх хувь болох ОХУ-ын “Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм 2018 онд шинэчлэгдсэн, Стандартчиллын үндэсний</p>	27	27

			<p>зөвлөлийн 2018.06.21-ний өдрийн 27 дугаар тогтоолоор MNS ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар” стандартыг баталж, 2018.07.16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн, мөн манай улсын газрын тосны салбарт хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой олон улсын стандартууд, дүрэм, заавар, зааварчилгааг судлан нэгтгэх, дүрмийн төсөлд тусгах, уялдуулах зэрэг нөхцөл, байдал үүссэнтэй холбоотойгоор тус дүрмийн төслийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгараад байна.</p> <p>Иймд “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгаа, газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх олон улсын туршлага, стандарт, дүрэм журмын талаар судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулах эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг УУХҮС-ын 2020 оны багцад тусган батлуулсан. Энэхүү эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд тулгуурлан дүрмийн төслийг эцэслэн боловсруулахаар төлөвлөж байна.</p>		
139.	186.	<p>4.3.2. “Газрын тосны тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг боловсруулж, батлуулна.</p> <p>1. Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Журмын төслийг боловсруулсан байна.</p> <p>Хугацаа: IV улиралд</p>	<p>УУХҮЯ-ны санаачилгаар Газрын тосны хайгуул, нөөцийн тооцооллын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж, заавар боловсруулах ажлыг Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр хийхээр тохиролцсон. Энэ хүрээнд Газрын тосны хайгуул, нөөцийн тооцооллын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж, заавар боловсруулах ажлыг ШУТИС-ийн эрдэмтдийн багтай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн ба тус ажлын гүйцэтгэлийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын хуралдаанаар хэлэлцэн, аргачилсан зөвлөмжийг газрын тосны нөөцийн тооцоололд ашиглаж байхаар шийдвэрлэсэн. "Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага" журмын төслийг боловсруулах ажлыг MINIS төслөөс санхүүжүүлэхээр тохиролцон, ажлын даалгаврыг боловсруулан MINIS төсөлд хүргүүлээд байсан боловч тодорхой шалтгааны улмаас санхүүжилт хийгдэх боломжгүй болсон. Иймд тус журмыг боловсруулахад шаардлагатай суурь судалгаа хийх, олон улсын туршлага, мөрдөж буй арга аргачлалын харьцуулсан судалгаа хийж, манай орны нөхцөлд тохирсон арга, аргачлалын төсөл</p>	27	27

			боловсруулах эрдэм шинжилгээ, судалгааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн төсвийг УУХҮС-ын 2020 оны төсвийн багцад суулган батлаад байна. Энэхүү судалгааны ажлын дүнд тулгуурлан журмын төслийг боловсруулж, батлахаар төлөвлөж байна.		
4.4. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар олборлох, борлуулах хэмжээг нэмэгдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах гол зорилтын хүрээнд:					
155.	211.	4.4.16. Био болон эко түлшний үйлдвэрлэлийг дэмжинэ. 1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төсөл, санаачлагыг дэмжиж ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Улаанбаатар хотын Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт техникийн хаягдал тос боловсруулан дизель түлш үйлдвэрлэх үйл ажиллагааг эрхэлдэг "Алтан оршихуй групп" ХХК-ийн МУ-ын Аж үйлдвэрийн сайдын 2016.07.04-ний өдрийн 114 дүгээр тушаалаар олгогдсон 04/Г дугаар тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай тушаалын төсөл боловсруулан удирдлагуудад танилцуулж байна.	30	30
ТАВ. ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:					
5.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого зарлага, хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:					
169.	234-235	5.3.1. Төсвийн шууд захирагч нарын Үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 1. Төсвийн шууд захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны Үр дүнгийн гэрээний биелэлтэд салбар, нэгж бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулж Сайдад танилцуулна.	ТНБД-ын 2019 оны ҮДГ-нд тусгагдсан 237 арга хэмжээний хагас жилийн биелэлтийг 86,7%-тай үнэлж, дүгнэлт зөвлөмж боловсруулан ТЗУГ-т хүргүүлсэн.	30	30
		2. Төсвийн шууд захирагч /Ашигт малтмал, газрын тосны газрын дарга/-ын 2019 оны Үр дүнгийн гэрээний биелэлтэд салбар, нэгж бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж Сайдад танилцуулна. Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Ажил үйлчилгээг бүрэн хамарсан байна. Хугацаа: 06/25, 12/25-ны дотор	АМГТГ-ын даргын 2019 оны ҮДГ-нд тусгагдсан арга хэжээний жилийн эцсийн биелэлтийг 86,5 %-тай үнэлж, дүгнэлт зөвлөмж боловсруулж ТЗУГ-т хүргүүлсэн.	30	30
172.	238.	5.3.4. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийж, танилцуулга боловсруулан, УЗ -ийн 2019.03.29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн, УУХҮС - ын 2019.03.29- ний өдрийн 01/853 дугаар	30	30

		<p>1. Төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилтот ажлуудын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүнг удирдлагад танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: 2 удаа</p> <p>Чанар: Дүгнэлт зөвлөмжийг удирдлагад танилцуулсан байна.</p> <p>Хугацаа: Тухай бүр</p>	<p>албан бичгээр ЗГХЭГ -т хүргүүлсэн. Хөтөлбөрт тусгагдсан тус яамны хэрэгжүүлэх 4 зорилтын 24 арга хэмжээний биелэлт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 55.7 хувьтай үнэлэгдэв. Танилцуулга нь 6 дүгнэлт, 2 санал зөвлөмж, бүхий 4 хуудас, 17 хуудас хавсралттай. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тухай ХШҮДАГ -ын даргын 2019.02.25 -ны өдрийн дотоод албан бичгийн төслийг боловсруулан, уг дотоод албан бичгийг газрын дарга нарт биечлэн хүлээлгэн өгч, зөвлөмж чиглэлээр ханган ажилласан. Хөтөлбөрийн биелэлтийг журмын дагуу нэгтгэж, биелэлт гаргаагүй, хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээний биелэлтийг ТЗУГ -аар нэмэлтээр гаргуулан, дахин ХШҮ хийсэн. Хөтөлбөрийн биелэлтийг журмын дагуу нэгтгэж, биелэлт гаргаагүй, хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээний биелэлтийг ТЗУГ -аар нэмэлтээр гаргуулан, дахин ХШҮ хийсэн .</p>		
<p>5.4. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гаргах гол зорилтын хүрээнд:</p>					
173.	239.	<p>5.4.1. Яамны 2019 оны Дотоод аудитын төлөвлөгөөг батлуулна.</p> <p>1. Сайдын багцад хамаарах байгууллага, төсөл арга хэмжээ, холбогдох байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийх дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулж батлуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төлөвлөгөөг батлуулсан байна.</p> <p>Хугацаа: 1 улиралд</p>	<p>УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 2019 онд хийх дотоод аудитын төлөвлөгөөний төслийг боловсруулж удирдлагад танилцуулсан.</p>	27	27
174.	240.	<p>5.4.2. Салбарт хэрэгжиж буй төслүүдийн гүйцэтгэлд санхүүгийн дотоод аудит хийнэ.</p> <p>1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологи хайгуулын төслүүдийн санхүүжилт, гүйцэтгэлд төсөл тус бүрээр дотоод аудит хийж дүнг яамны удирдлагад танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төслүүдийг бүрэн хамруулсан байна.</p> <p>Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд</p>	<p>Санхүүгийн дотоод аудит хийгдээгүй.</p>	/-/	/-/
175.	241.	<p>5.4.3. Салбарт хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</p> <p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд төсөл арга хэмжээ бүрээр дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p>	<p>Яамны 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг нэгдсэн тайланд нэгтгүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,836.88 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил хийгдэхээр төлөвлөж, 3,561.2 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна. Нэгдсэн дүнгээр 98,7 оноогоор үнэлэгдсэн.</p>	30	30

		Чанар: Арга хэмжээ бүрийг хамарсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд			
176.	242.	5.4.4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 1. Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд арга хэмжээ бүрээр дотоод аудит хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж дүнг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Арга хэмжээ бүрийг хамарсан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	Яамны 2018 оны худалдан авах ажиллагааны тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тайланг нэгдсэн тайланд нэгтгүүлсэн. УУХҮС-ын багцын хөрөнгөөр 2018 оны жилийн эцсийн байдлаар 6,535.92 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төрлийн худалдан авалтад 6,249.62 сая төгрөг зарцуулсан. Нэгдсэн дүнгээр 97,0 оноогоор үнэлэгдсэн.	30	30
177.	243.	5.4.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсвийн орлого, зарлагын тооцоолол, санхүүжилтийн гүйлгээ, төсвийн тайлан тэнцэлд санхүүгийн дотоод аудит хийнэ. 1. Холбогдох материалыг цуглуулах, нягтлах, газар дээр шалгаж аудитын дүгнэлт, санал зөвлөмжийг боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: ТЭЗ-ийг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Замын-Үүдийн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-т хийх аудитын удирдамжийг боловсруулан 2019.06.10-2019.06.16-ны хооронд шалгалтын ажлыг гүйцэтгэн, шалгалтын тайланг боловсруулж, дүгнэлт зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулсан.	30	30
178.	244.	5.4.6. Хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих. 1. Агентлагийн үйл ажиллагаанд байнгын хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: /-/ Чанар: удирдамжийн дагуу ажилласан байна. Хугацаа: Удирдамжинд заасан хугацаанд	УУХҮС-ын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/51 дүгээр тушаалаар АМГТГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - АМГТГ-ын ХШҮСХ-ийн үйл ажиллагаатай танилцах хүрээнд 2019.02.18-ны өдрийн “Мэдээлэл ирүүлэх тухай” 08/421 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлж, тус газраас ирүүлсэн 2019.02.22-ны өдрийн 1/1091 дугаар албан бичиг, ХШҮСХ-ийн танилцуулга, 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон биелэлттэй танилцсаны үндсэн дээр 2019.02.27-ны өдөр холбогдох танилцуулга, презентаци боловсруулсан. Мөн 2019.03.13-ны өдөр АМГТГ-ын дарга, орлогч даргад УУХҮС-ын тушаал, удирдамжийг танилцуулж, ХШҮСХ-ийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, байнгын удирдамжийн хүрээнд хийгдэх ажлын талаар ярилцаж тохирсон. Байнгын удирдамжийн хүрээнд:	30	30

			<p>- Нөөцгүй болон нөөц нь тодорхойгүй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шалгах хүрээнд 2019.03.26-ны өдөр АМГТГ-т ажилласан бөгөөд тус газрын Нүүрсний судалгааны хэлтсээс боловсруулсан нүүрсний нөөцгүй болон нөөц нь тодорхойгүй ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг 2019.03.27-ны өдөр тус хэлтсийн дарга М.Мэндбаяраас хүлээн авч танилцсан. Улмаар холбогдох дүгнэлтийг 2019.03.29-ний өдөр, Нөөцгүй болон нөөц нь тодорхойгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн байдалд хийсэн шалгалтын тайлангийн төслийг 2019.04.01-ний өдөр нэгтгэн боловсруулж газрын даргад хүргүүлсэн.</p> <p>- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн байдалд хийх хяналт шалгалтын хүрээнд 2019.05.16, 17, 21, 22, 24, 29, 30, 31-ний өдрүүдэд АМГТГ-т ажиллаж Кадастрын хэлтсийн архивд хадгалагдаж буй түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн материалаас Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад олгогдсон 165 тусгай зөвшөөрлийн өргөдлийн дотоод хяналтын хуудастай танилцсан бөгөөд хориглосон, хязгаарласан болон бусад талбайтай давхцалтай эсэх, мөн эрдсийн хуримтлалтай эсэхийг тус газрын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран шүүсэн. Улмаар шалгалтын тайлангийн төслийг 2019.06.03-ны өдөр нэгтгэн боловсруулсан бөгөөд 2019.06.04-ний өдөр холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан тайланг баталгаажуулж, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн танилцуулгын хамт газрын даргад хүргүүлсэн. АМГТГ-ын 2018 оны үйл ажиллагааны тайлантай 2019.02.01-ны өдөр танилцаж, 5 дүгнэлт, 4 зөвлөмж боловсруулсан /3 хуудас/. АМГТГ-ын 2019.02.22-ны өдрийн 1/1091 дугаар албан бичгээр ирүүлсэн тус газрын ХШҮСХ-ийн танилцуулга, үйл ажиллагааны тайлантай танилцан, санал боловсруулсан /02.01, 02.28/.</p> <p>- АМГТГ-ын ажилтнуудын цагийн бүртгэлд хяналт шалгалт хийх хүрээнд 2019.11.22-ны өдрийн 13 цаг 30 минутаас 14 цаг 50 минут хүртэлх хугацаанд тус газарт ажиллаж нийт 101 албан хаагчийг бүртгэсэн ба үүнтэй холбоотойгоор 2019.11.25-ны өдрийн “Арга хэмжээ авах тухай” 08/3292 дугаар албан бичгийг боловсруулан АМГТГ-т хүргүүлсэн.</p>		
179.	245.	<p>5.4.7. Сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит тухай бүр хийнэ.</p> <p>1. Сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн</p>	<p>УУХҮС-ын 2019 оны А/22 дугаар тушаалаар “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ахалж 2019.02.12-15-ны өдрүүдэд компанийн төв офист ажиллаж, тайланг сайдад танилцуулж ажилласан. Дотоод аудитын хүрээнд 19 заалттай зөвлөмжийг ЭТТ компанид хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан. Дотоодын аудитын дүн, сайдаас өгсөн үүргийн дагуу сайдын А/75 дугаар тушаалаар ЭТТ компанийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах ажлын хэсгийн</p>	30	30

		этгээдүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж дүгнэлт, зөвлөмж гарган яамны удирдлагад танилцуулна. Тоо хэмжээ: /-/ Чанар: Удирдлагыг эрсдэлийн удирдлагаар хангасан байна. Хугацаа: Тухай бүр	бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулсан. 2019.12.10-ны өдрийн байдлаар тус тус байнгын удирдамжийн хүрээнд хийсэн ажлын тайланг ЭТТ компаниас авч, өмнөх зөвлөмжийн биелэлтэд гүйцэтгэлийн хяналт тавьж ажилласан. УУХҮС-ын 2019 оны А/139 дүгээр тушаалаар Замын-Үүд суманд дахь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлуулж, 6 сарын 10-аас 14-ний өдрүүдэд газар дээр нь ажиллаж, шалгалтын тайланг боловсруулж, дүгнэлт зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулсан.		
НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДҮН				29.91	29.9

ХОЁР. ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

ХАХ	ГАҮ	Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгууруузүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 оноо)	
				ХШҮДАГ	ТЭЗ
1	2	3	4	5	6
НЭГ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР БОЛОН ГАЗРЫН ТОСНЫ ТАЛААРХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СТРАТЕГИЙГ ТОДОРХОЙЛОХ, БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, САЛБАР ХООРОНДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДААГ ХАНГАХ, САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙГ ТӨЛӨВЛӨХ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ БОДЛОГЫН ХУВИЛБАР БОЛОВСРУУЛАХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
1.1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр болон газрын тосны салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, салбарын хууль тогтоомжийн төсөл, хөгжлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хувилбар, төсөл, төлөвлөгөө боловсруулах зорилтын хүрээнд:					
1.	1-2	1.1.1. Геологийн салбарт мөрддөг дүрэм, журам, зааврыг боловсруулна. /ТЭБСББ-ын 3.1.9, 3.1.10/ 1. Ашигт малтмалын төрлөөр хайгуулын ажлын заавар, зөвлөмжүүдийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох зөвлөмжийг гаргуулна. Тоо хэмжээ: 5 удаа	1. Геологийн салбарт мөрддөг дүрэм, журам, зааврыг боловсруулах ажлын хүрээнд Австрали Улсын ЗГ-ын Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕР)-ийн дэмжлэгтэйгээр “Газрын тос, Au, Fe, CaF ₂ , шороон ордын баялаг, нөөцийн ангиллыг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг боловсруулахаар 2019 оны 1 дүгээр сард эхлүүлсэн. 2019 оны 1-3 сард нийт 3 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, шинжээч томилон ажиллуулсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019.02.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан.	40	40

		<p>Чанар: Заавар, зөвлөмжүүдийг боловсруулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p> <p>2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулах, бүртгүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Бүртгүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Аргачилсан зөвлөмжүүдийг 2019 оны 6-р сард орчуулан хайгуулын ажилд ашиглахад бэлэн болгосон.</p> <p>Зэсийн ордод “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ыг хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулах ажлыг Канадын Засгийн газрын SESMIM төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэн, хэлэлцүүлгийг 2019 оны 7 дугаар сард зохион байгуулсан.</p> <p>ЭМБЗ-ийн 2019 оны 4,7 дугаар сарын хуралдаанаар 6 төрлийн ашигт малтмалын хайгуулын аргачилсан зөвлөмжийг хэлэлцүүлэн хуралдаанаас гарсан саналын дагуу холбогдох засварыг хийж, хэвлэх хувилбарыг бэлтгэн орчуулгад шилжүүлсэн. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮС-ын 2019.10.03-ны өдрийн А/193 дугаар тушаалаар 8 төрлийн ашигт малтмалын зааврыг батлуулан 2019 оны 11 дүгээр сард ЭБМТ-ийн Геологийн баримтын төв архивд холбогдох баримтыг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.</p> <p>2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулахаар ажиллаж байна.</p>		
2.	3.	<p>1.1.2. Геологийн судалгааны ажлын стратегийн төлөвлөгөөний төсөөллийг боловсруулна.</p> <p>/ТЭБСББ-ын 3.2/</p> <p>1. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийж гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний төсөөллийг боловсруулах, цаашдын судалгааны чиг, хандлагыг тодорхойлно.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төлөвлөгөөг боловсруулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Геологийн судалгааны ажлын стратегийн төлөвлөгөөний төсөөллийг боловсруулах хүрээнд ГАСАМ төслийн даалгаврыг 2019 оны 2 дугаар сард боловсруулсан. УУХҮС-ын 2019 оны А/143 дугаар тушаалаар Монгол Улсын урт хугацааны бодлого (2020-2045), уг бодлогыг 2020-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах дэд ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд хийж гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөний төсөөллийг 2025, 2045 онд хүрэх түвшин, зорилтыг тодорхойлохоор ажиллаж байна.</p>	40	40
3.	4.	<p>1.1.3. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулна.</p> <p>/ЗГҮАХ 2.61.2/</p> <p>1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төсөл боловсруулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай бие даасан хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг УУХҮС-ын 2019.05.02-ны өдрийн А/82 дугаар тушаалаар байгуулсны дагуу ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, гишүүдийн ажиллах нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, хууль хэрэгжсэнээр гарах үр дагавар, хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгжээс гарах зардлын тооцооны тайланг нэгтгэн боловсруулсан. Хуулийн төсөл боловсруулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.</p>	40	40
		<p>1.1.5. Уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулна.</p> <p>/ЗГҮАХХАХТ-2.65.1/</p> <p>1. Уул уурхайн дэд бүтэц /төмөр зам, авто зам, усан хангамж, эрчим хүч/-ийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулна.</p>	<p>ТНБД-ийн 2017.10.09-ний өдрийн А/134 дугаар тушаалаар "Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг"-ийн төслийг боловсруулах үүрэг бүхий СЯ, ЭХЯ, ЗТХЯ, холбогдох агентлагаас төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг холбогдох байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг авч нэгтгэн, уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулан салбар хоорондын уялдааг хангах чиг үүргийн дагуу Үндэсний хөгжлийн газарт 2018.10.10-ны</p>	36	36

5.	6.	<p>Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслийг боловсруулсан байна. Хугацаа: IV улиралд</p>	<p>өдрийн 01/2687 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гэвч МУ-ын ЗГ-ын 2018 оны 42 дугаар тогтоолоор Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (2015-2030), МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, Хөгжлийн зам хөтөлбөртэй уялдсан Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг батлан гаргасан. Уг бодлогын баримт бичгийн 3 дугаар зүйлд Бодлогын зорилтыг хангах үйл ажиллагааг зааж өгсөн бөгөөд 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтад “уул уурхайн хөгжлийг дэмжих тээвэр, дэд бүтцийг барьж байгуулах” асуудлыг тусгасан.</p> <p>Мөн УИХ-ын 2018 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан МУ-ын Нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүч, зам тээврийн асуудлуудыг тус тус тусгасан бол, Монгол Улсын Засгийн газрын 2018.10.24-ний өдрийн 325 дугаар тогтоолоор Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018-2023)-ийг, МУ-ын ЗГ-ын 2018.10.24-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”-ыг тус тус баталсан.</p> <p>Дээр дурдсан бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдэд уул уурхайг дагасан бүтээн байгуулалтуудын ажлуудын төлөвлөлтийг тусган баталсан.</p> <p>Уул уурхайн дэд бүтэц /төмөр зам, авто зам, усан хангамж, эрчим хүч/-ийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн талаар Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгуулахаар санал боловсруулж, хүргүүлсэн. Тус урт хугацааны баримт бичиг нь УИХ-аас 2015 онд батлагдсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”, 2010 онд батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”, ЗГ-аас 2018 онд батлагдсан “Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлого”, мөн онд батлагдсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” зэрэг хөгжлийн урт хугацааны баримт бичигт тусгагдсан учраас тусгайлан боловсруулах шаардлагагүй гэж үзсэн. Уг заалтыг ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс хасуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p>		
6.	7.	<p>1.1.6. Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.1.2, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.2.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн-10 дугаар зүйл/ 1. Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа</p>	<p>ЗГ-ын 2019.05.29-ний өдрийн 214 дүгээр тогтоолоор “Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан тул “Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан 2019.07.08-ны өдөр салбарын аж ахуйн нэгжүүдийн хүрээнд хэлэлцүүлэн УУХҮС-ын 2019.08.26-ны өдрийн А/180 дугаар тушаалаар батлуулсан.</p>	40	40

		<p>Чанар: Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр төслийг Засгийн газраар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>			
7.	8.	<p>1.1.7. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.</p> <p>/МУ-ын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл,120, ТАУТББ- 4.2.1.8/</p> <p>1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдах хуулиудын төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төслийг хэлэлцэж батлахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Улсын Их Хурлын холбогдох байнгын хорооны Ажлын хэсэгт ажиллан, бодлогын дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Хуулийн төсөл болон дагалдах хуулиудын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна.</p> <p>Хугацаа: III улиралд</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ЗГ-аас 2019.03.20-ны өдөр УИХ-д өргөн барьсан. УИХ-ын ЭЗБХ-ноос байгуулсан дэд ажлын хэсгийн хуралд УУХҮЯ-ны албан хаагчид оролцсон ба үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдийн талаарх танилцуулга мэдээллийг тодорхой шалгуур, үзүүлэлтээр гарган Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн. Уг хуулийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2019.10.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж, гишүүдийн 72,6 хувийн саналаар дэмжсэн. Мөн 2019.10.18-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар ЭЗБХ-ны дүгнэлтийг хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар УИХ-ын анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг байгуулж, дэд ажлын хэсгийг холбогдох яамд, газруудын төлөөлөлтэйгээр байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд холбогдох судалгаа, мэдээлэл бэлтгэж, УИХ-ын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна. Хуулийн төслийн талаар УИХ-ын ЭЗБХ-нд 2 удаа танилцуулга хийсэн. УИХ-ын ЭЗБХ болон УИХ-ын нэгдсэн чуулганы 2019.10.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Хуулийн хэлэлцүүлэгт бэлтгэх ЭЗБХ-ны дэд ажлын хэсэгт үргэлжлүүлэн ажиллаж байна.</p>	36	36
8.	9.	<p>1.1.8. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг хамруулах ажлыг зохион байгуулалтаар хангана.</p> <p>/ТАУТББ-4.2.8.6/</p> <p>1. Хүнд үйлдвэрийн салбарын дотоодын үйлдвэрлэгчдийн стандарт, чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгө үйлдвэрийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт</p>	<p>Хүнд үйлдвэрийн салбарын дотоодын үйлдвэрлэгчдийн стандарт, чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний шинэчилсэн жагсаалтыг гарган ХХААХҮЯ-нд хүргүүлж, шинэчилсэн жагсаалтыг Засгийн газрын 2019.02.27-ны өдрийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 90 дүгээр тогтоолоор батлуулсан. Энэхүү тогтоол батлагдсанаар дотоодод үйлдвэрлэж буй чанар стандартын шаардлага хангасан бараа тендерт давуу эрх эдлэх боломжтой болсон.</p>	40	40

		<p>оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна.</p> <p>Хугацаа: IV улиралд</p>			
9.	10.	<p>1.1.9. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна. /ЗГҮАХ-2.71.1, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.3.6/</p> <p>1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, үйлдвэрийн усан хангамжийн асуудлаар санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар:Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, үйлдвэрийн усан хангамжийн асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн байна. Хугацаа: III улиралд</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, түүнтэй гэрээ байгуулах зарчим болон үйлдвэрийн салбар төмөр замыг холбох асуудлаар ХҮГТБХЗГ, ГУУБХЗГ-тай хамтран санал боловсруулж, Засгийн газрын 2019.04.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 18 дугаар тэмдэглэл гарсан. Үйлдвэрийн усан хангамжийн асуудлаар Хүнд үйлдвэрийн хэлтэстэй хамтран санал боловсруулсан бөгөөд ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2018.12.12-ны өдрийн "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 378 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын дагуу 2019.04.03-ны өдөр улсын тусгай хэрэгцээнд газрыг ашиглуулах тухай 2019/01 дугаар гэрээг байгуулсан. Мөн төслийн асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулсан бөгөөд ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор "МУ-ын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулсан. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөхийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан өмгөөллийн "Монгол Өмгөөлөгч" ХХН-тэй гэрээ байгуулж, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төсөл, холбогдох тайланг хүлээн авсан. Үүний дагуу "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах журам"-ыг олон улсын жишиг аргачлалын дагуу боловсруулсан.</p>	36	.36
10.	11.	<p>1.1.10. Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /ТАҮТББ-4.1.1/</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Хүнд үйлдвэрийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: IV улиралд.</p>	<p>Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг ХҮГТБХЗГ-тай хамтран боловсруулж байна.</p>	36	36
11.	12.	<p>1.1.11. "Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого"-ыг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХ 2.63.1/</p> <p>1. Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл</p>	<p>"Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого"-ын төслийг боловсруулан бүх яамдаас санал авч нэгтгэн, 2018.05.11-ний өдрийн 01/1298 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн ба ЗГ-ын 2018.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.</p>	40	40

		ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Сайдын тушаалаар батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төлөвлөгөөг боловсруулсан байна. Хугацаа: II улиралд	“Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, УУХҮС-ын 2019.08.08-ны өдрийн А/163 дугаар тушаалаар баталсан ба хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.		
12.	13-14	1.1.12. “Газрын тосны тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. /ЗГҮАХ 2.63.2/ 1. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдах Ажлын хэсгийг мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Ажлын хэсэгт орж ажилласан байх Хугацаа: III улиралд 2. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт тухай оруулах асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Саналыг тусгаж, Ажлын хэсэгт бодлогын дэмжлэг үзүүлсэн байх Хугацаа: IV улиралд	Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ХЗДХС/УУХҮС-ын хамтарсан 2017.12.13-ны өдрийн А/298/А/240 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд “Газрын тосны тухай” хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар саналыг томъёоллыг бэлтгэж, ЗГ-ын 2018.06.06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон бусад хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2019.05.26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч гишүүдийн олонхийн саналаар хуулийн төсөл буцаагдсан. Энэхүү хуулийн төсөл, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд дахин ЗГ-ын хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	40	40
13.	15-16	1.1.13. “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулна. /ЗГҮАХ 2.17.1/ 1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдах Ажлын хэсгийг мэдээллээр хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Ажлын хэсэгт орж ажилласан байх Хугацаа: III улиралд 2. Газрын тосны тухай бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт тухай оруулах асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Саналыг тусгаж, Ажлын хэсэгт бодлогын дэмжлэг үзүүлсэн байх Хугацаа: IV улиралд	1. Тус хуулийг шинэчлэн найруулж буйтай холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой харилцааг зохицуулах талаар санал боловсруулж хүргүүлсэн. 2. ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 дүгээр тушаалаар байгуулагдсан “Эрдэс баялгийн салбарт үйлчилж буй багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах” үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд уг хуулиудын төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлсэн бөгөөд төсөлд УИХ-ын гишүүдийн санал зөвлөмжийг тусган дахин өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаж байна.	40	40
1.3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаарх бодлогын хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх,					

хэрэгжилтийг удирдан зохион байгуулах зорилтын хүрээнд:					
23.	28.	1.3.7. Улсын хөрөнгө оруулалтын 2018-2021 оны хөтөлбөрийн тодотголын төслийг боловсруулна. /ЗГҮАХ 1.3.2/ 1. 2018-2021 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төсөл боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Санал боловсруулж хүргүүлсэн байна. Хугацаа: II улиралд	МУ-ын ЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 2018-2021 оны Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тодотгол оруулах тухай саналыг боловсруулсан. Уг хөтөлбөрт Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслийн талаар тусгуулахаар төлөвлөсөн. МУ-ын ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн хуралдаан дээр Ерөнхий сайдын өгсөн чиглэл, Төсвийн тухай хуулийн 28.1, 28.8, 28.10, 29.2, 29.4, “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ын 2.6 дахь заалтуудад тус тус нийцүүлэн 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголын төсөлд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих шаардлагатай 1 төсөл, шинээр нэмэгдэх 4 төслийн саналыг боловсруулж, танилцуулга мэдээллийн хамт 2019.06.20-ны өдөр 01/1883 дугаар албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Тодотголын төсөлд нийт 22.3 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төслийг хэрэгжүүлэхээр санал оруулсан.	40	40
ГУРАВ. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЗОХИЦУУЛАХ; УДИРДАМЖААР ХАНГАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:					
3.1. Геологийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:					
68.	92.	3.1.1. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба байгуулна. /ЗГҮАХ 2.60.1/ 1. Монгол орны онцлогт тохирсон Үндэсний геологийн алба байгуулах санал боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Тоо, хэмжээ: Тухай бүр Чанар: Саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Монгол орны онцлогт тохирсон Үндэсний геологийн алба байгуулах тухай танилцуулгыг бэлтгэн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 01/1396 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Энэ асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан ирүүлэх чиглэлийг ЗГХЭГ-аас ХЭГ/1546 дугаар албан бичгээр ирүүлсэн. ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу холбогдох материалыг боловсруулж ЗГ-ын 2019.10.16-ны өдрийн хуралдаанаар Үндэсний геологийн алба байгуулахыг дэмжсэн. Асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Үзэл баримтлалыг боловсруулан, ХЗДХЯ-нд хянуулан батлуулахаар хүргүүлсэн.	40	40

69.	93-94	<p>3.1.2. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна. /ЗГҮАХ 2.61.1/ 1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлсэн байна. Хугацаа: II улиралд</p> <p>2. Эрдэс баялгийн салбарын хуулиудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлсэн байна Хугацаа: III улиралд</p>	<p>1. Ашигт малтмалын тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хурлын 2019.03.26-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж батлуулсан. Гэвч “Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай” асуудлыг Үндсэн Хуулийн Цэцийн Их суудлын хуралдаанаар 2019.10.30-ны өдөр хэлэлцэж, Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “Ашигт малтмал худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан хуулийн этгээд ... нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч байх ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцож улсын төсөвт төлнө.” гэсэн заалт болон мөн зүйлийн 47.3 дахь хэсгийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 47.4 дэх хэсэг, 47.5 дахь хэсгийн 47.5.11, 47.5.12, 47.5.13 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь ... аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгох тухай 04 тоот тогтоолыг гаргасан. Иймд Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна" гэснийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүссэн. Иймд дээр дурдсан нөхцөл байдлыг шийдвэрлэх үүднээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь ямар тохиолдолд хэдий хэмжээний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх харилцааг зохицуулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их хурлын 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. 2.Эрдэс баялгийн салбарын хуулиудын хийдэл, зөрчил, давхардлыг арилгах зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар дээрх хуулийн төслүүдийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлсэн.</p>	40	40
70.	95.	<p>3.1.3. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. /ЗГҮАХ 2.61.3/ 1. Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.</p>	<p>Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж байна. Хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	36	36

		Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуулийн үзэл, баримтлал, төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: Жилдээ			
71.	96-97	3.1.4. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ 2.59.7/ 1. Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох судалгаа хийж, санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хууль, эрх зүйн орчны судалгаа хийсэн байна. Хугацаа: Жилдээ 2. “Газрын ховор элемент” хөтөлбөрийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хөтөлбөрийг боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	Цацраг идэвхт ашигт малтмалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал, Цацраг идэвхт ашигт малтмалын тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас баталсан Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох саналыг өгч ажилласан. Газрын ховор элементийн өнөөгийн байдал цаашид авах арга хэмжээний талаар танилцуулгыг ЗГ-ын 2019.01.09-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Танилцуулгын дагуу Газрын ховор элемент хөтөлбөрийг боловсруулан ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг УУХҮС-д даалгахаар тэмдэглэл гаргасан. Хөтөлбөр боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Газрын ховор элементийн төслийн нэгж байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019.04.17-ны өдрийн 01/1098 дугаар албан бичгээр тогтоолын төсөл, холбогдох материалыг хүргүүлсэн. Асуудлыг ЗГ-ын 2019.05.01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Газрын ховор элемент хөтөлбөрийн төслийг боловсруулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу холбогдох хавсралт материалыг бэлтгэн яамдаас санал авахад бэлэн болоод байна. Хөтөлбөрийн төсөлд яамдаас 2019.07.19-ний 01/2151 дүгээр албан бичгээр санал авсан. Ирсэн саналын дагуу засвар өөрчлөлтийг хийж Сангийн яамнаас эрх авахаар ажиллаж байна. Цацраг идэвхт ашигт малтмал олборлохтой холбогдуулан Ураны ислийн нөөц ашиглах төлбөрийг тогтоож, тооцох талаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Эрдэс баялгийн салбарын багц хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгасан. Мөн цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх дүрмийг ЗГ-ын 2019 оны 243 дугаар тогтоолоор батлан эрх зүйн шинэчлэл хийгдэж байна.	40	40
72.	98.	3.1.5. Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ 2.60.2, ТЭБСББ-ын 3.2.2.9, 3.2.2.10/ 1. “Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулж, Сангийн яамнаас холбогдох зөвшөөрлийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хөтөлбөрийн төслийг хүргүүлсэн байна.	“Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөрийн төслийг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам, СЯ-наас өгсөн саналын дагуу боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг СЯ-нд 2019.04.01-ний өдрийн 01/870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. СЯ-наас 2019.04.11-ний өдрийн 5-2/2133 дугаар зөвшөөрөл өгөх тухай албан бичгийн дагуу Хөтөлбөр батлах тухай ЗГ-ын тогтоолын төсөл, холбогдох материалыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019.04.16-ны өдрийн 01/1095 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг асуудлыг 2019.05.01-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, 177 дугаар тогтоолоор баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор буюу Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлахыг УУХҮС-д даалгасны дагуу ТНБД-ын 2019 оны	40	40

		Хугацаа: Жилдээ	А/95 дугаар тушаалаар “Үндэсний геомэдээллийн сан” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг салбар хоорондын уялдааг ханган боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УУХҮЯ, АМГТГ, ҮХГ, БОАЖЯ, ГЗБГЗЗГ, АМЕР, EBRD, BGR, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан батлуулсан. Ажлын хэсэг төлөвлөгөөний төслийг боловсруулан УУХҮС-ын 2019.11.04-ний өдрийн А/216 дугаар тушаалаар батлуулж холбогдох байгууллагуудад 2019.11.06-ны өдрийн 02/3093 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
73.	99-101	<p>3.1.6. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд алтны геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын хэмжээг өсгөн нөөцийн тогтвортой нэмэгдүүлнэ. /ЗГҮАХ 2.69.3, ҮЧ-ийн 5.2/</p> <p>1. “Алт-2” үндэсний хөтөлбөрийн ерөнхий төлөвлөгөөнд 2019 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг зохион байгуулж, удирдлагаар ханган ажиллана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. Хугацаа: Жилдээ</p> <p>2. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс алтны нөөц бүхий эцсийн үр дүнгийн тайланг хүлээн авч, улсын нөөцийн бүртгэлд бүртгэнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Алтны нөөц нэмэгдсэн байна. Хугацаа: Жилдээ</p> <p>3. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа алтны хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажлын хэрэгжилтийг хангаж ажиллана. Тоо хэмжээ: 2 удаа Чанар: Төслийг хэрэгжүүлсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1. УУХҮС-ын 2018.12.03-ны өдрийн А/249 дугаар тушаалаар байгуулагдсан МУ-ын Хөгжлийн банкны стратеги, төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болох уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх боломжтой хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээлэл, санал солилцох, энэ чиглэлээр цаашид хамтран ажиллах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэгт ажиллаж байна. Үүнд: Ажлын хэсгийн 1, 2 дугаар хуралдаанаар хэлэлцсэн алт олборлогч аж ахуйн нэгжүүд санхүүжилт хүсэхэд тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулга хийх хүсэлтийг яамнаас тавьсны дагуу Хөгжлийн банкнаас зохион байгуулсан “Монголиа гоулд 2019” Олон Улсын хуралд илтгэл тавьсан.</p> <p>“Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Монголбанкаас “Банкны хөгжил-95 жил” ойн арга хэмжээг угтан зохион байгуулсан “Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа” аяны нээлтийн ажиллагаанд үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийн талаар ГУУБХЗГ-аас 2019.04.08-нд мэдээлэл хийж оролцсон.</p> <p>“Алт-2” үндэсний хөтөлбөрийн 2017.06.14-ний өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтран баталсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн боловсруулж ХШҮДАГ-т цахимаар хүргүүлсэн. Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хавсралтад дурдсан зорилт тус бүрээр дэлгэрэнгүй гаргаж ирүүлэх тухай 2019.06.27-ны өдөр 01/1959 дүгээр албан бичгээр ЗГХЭГ, Сангийн яам, БОАЖЯ, Монголбанк, АМГТГ-т хүргүүлсэн. Ирүүлсэн тайланг хагас жилийн байдлаар нэгтгэн удирдлагад танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний 2017, 2018 он болон 2019 оны эхний жилийн хэрэгжилтийн тайланг 2019.08.29-ний өдөр УУХҮС-ын зөвлөлийн хуралд танилцуулж хэлэлцүүлсэн.</p> <p>2. 2019 онд хувийн хөрөнгөөр алтны хайгуулын ажил гүйцэтгэсэн 28 үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж алтны үндсэн 3 ордын 50,555.33 кг, шороон 29 ордын 2,832.49 кг буюу нийт</p>	40	40

			<p>53,387.82 кг алтны нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.</p> <p>3. Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлөвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын “ТЗМ-Алт-2017” төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны ажлыг 2017-2018 онд гүйцэтгэж дууссан бөгөөд 521,200.0 кв.км талбай буюу 33.3%-д тархсан алтны хүдэржилт бүхий талбай, дүүрэг, зангилаа, түүнд тогтоогдсон орд, илрэл, эрдэсжсэн цэг, сарнилын хүрээ бүхий хэсгүүдийг нарийвчилсан. Нутаг дэвсгэрийн 33.3%-ийг хамарсан хэсэгт хийгдсэн хээрийн судалгаа ажлын үр дүн, лабораторийн шинжилгээний хариуг нэгтгэн суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>2019 оноос Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны ажлыг “БӨМ-Алт-2019” төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр ажлын геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-ын 2-р сарын 04-ний өдрийн шийдвэрээр, төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар тус тус батлуулсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж УУХҮЯ-2019/11 дүгээр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан</p>		
74.	102-103	<p>3.1.7. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. /ЗГҮАХ 2.62.1/ 1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн солбицлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Солбицлыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: Жилдээ 2. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн солбицлыг тогтоох ажлыг АМГТГ-ын КХ-тэй хамтран боловсруулан ажиллаж байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох журмыг шинэчлэхээр тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын 2019.12.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>2. Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох явцыг эрчимжүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх нөхцөл, шаардлага үүссэн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай /хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох тухай/ холбогдох материалууд /танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл/-ыг боловсруулан, төслийг удирдлагуудад танилцуулсан. Засгийн газарт танилцуулгыг хүргүүлэх шийдвэрийг удирдлагаас хүлээж байна.</p>	40	40

75.	104.	<p>3.1.8. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. /ТЭБСББ-ын 3.1/ 1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажил, хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөц, техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн зохих шийдвэрийг гаргана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн СТР/2019/01-01, 02 хуралдааныг зохион байгуулж, “Цайртминерал” ХХК-ийн Төмөртийн-Овоо цайрын ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, “Шивээ-Овоо” ХК-ийн Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг ашиглах ил уурхайн өргөтгөлийн техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголын хэлэлцэн хүлээж авсан. ЭБМЗ-ийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг боловсруулж албажуулан АМГТГ-т хүргүүлсэн. Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаан жилийн эцсийн байдлаар нийт 6 удаа хуралдаж, нийт 26 төслийн төсвийн тодотгол хэлэлцэж, 5 үр дүнгийн тайланг хүлээн авч, 1 үр дүнгийн тайланг хугацаатай албан даалгавар өгч буцаасан бөгөөд ЭБМЗ-ийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг тухай бүр албажуулсан. Алтны үндсэн орд, шороон орд, төмөр, хайлуур жонш, газрын тос, зэсийн аргачилсан зөвлөмжийг хэлэлцсэн. Хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хэлэлцсэн ЭБМЗ-ийн 18 удаагийн хуралдаан зохион байгуулж нийт хайгуулын ажлын үр дүнгийн 125 тайлан, тодотгол тайлан хэлэлцэж, 113 хүлээн авч 91 дүгнэлт, 90 тэмдэглэл гаргаж, шийдвэр гаргуулан нөөц нь бүртгэгдэн Геологийн төв архивд тушаагдсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хурлыг нийт 11 удаа зохион байгуулж, нийт 138 асуудлыг авч хэлэлцсэн.</p>	40	40
76.	105.	<p>3.1.9. Талбайг “Улсын нөөц”-д авах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан зохих шийдвэр гаргуулна. /ТЭБСББ-ын 3.2/ 1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын талбайг “Улсын нөөц”-д авах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулах, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Хугацаа: I улиралд</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн талбайг улсын нөөцөд авах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019.02.14-ний өдрийн 01/392 дугаар албан бичгээр тогтоолын төсөл, холбогдох материалыг хүргүүлсэн. Асуудлыг 2019.02.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 89 дүгээр тогтоолоор баталсан.</p>	40	40
77.	106.	<p>3.1.10. Эрдэс баялгийн болон ашигт малтмалын ордын нөөцийг үнэлэх олон улсын стандартад шилжинэ. /ТЭБСББ-ын 3.1.9/</p>	<p>Ашигт малтмалын нөөц, балансыг бүртгэх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг ижил төстэй улс орнуудын жишээнд судлан дүн шинжилгээ хийн, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийг УУХҮС-ын 2019.02.27-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулсан. БНКазУ-ын Хөрөнгө оруулалт,</p>	40	40

		1. Ашигт малтмалын нөөц, балансыг бүртгэх, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг ижил төстэй улс орнуудын жишээнд судлан дүн шинжилгээ хийн, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Санал боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	хөгжлийн яамны геологи, газрын хэвлийн зөвлөлийн дарга А.А.Надырбаев-д “Ашигт малтмалын нөөц, түүний ангилал, тайлагнах, нөөцийн бүртгэл” гэсэн сэдвээр санал солилцох хүсэлтийг 2019 оны 06/812 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Ажлын хэсгийн гишүүн Д.Бат-Эрдэнэ БНКазУ-ын КРИРСКО-ын төлөөлөлтэй 2019.03.30-2019.04.03-ны хооронд уулзаж, санал солилцохоор тус улсад ажилласан. Мөн МУ-ын ашигт малтмалын нөөцийн 2017-2018 оны хөдөлгөөний тайланд дүн шинжилгээ хийн, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж байна.		
78.	107.	3.1.11. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ. /ЗГҮАХ-2.67.2/ (2017-2018) 1. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг батлуулж, мөрдүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмын төсөл батлагдсан байна. Хугацаа: II улиралд	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл, нөлөөллийн шинжилгээний тайлан боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УУХҮС-ын 2018.04.24-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулсан. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төслийг эцэслэн боловсруулж, УУХҮС-ын /А/181/ болон БОАЖС-ын /А/458/ хамтарсан тушаалаар батлуулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019.11.21-ний өдрийн 4530 дугаарт бүртгүүлсэн.	40	40
79.	108.	3.1.12. “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ. /ЗГҮАТ-2.69.8/ 1. “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн боловсруулах дотоодын зөвлөхийн сонгон шалгаруулалтыг хийж, улмаар шалгарсан зөвлөлтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан.	40	40
3.2. Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, бүтэц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тогтоох, геологийн шинжлэх ухааны сэдэвчилсэн судалгаа, зураглал, эрлийн ажлыг гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:					
80.	109.	3.2.1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулна. /ТЭБСББ-ын 3.2.1, ЗГҮАХ-ийн 2.59.1, ҮЧ-ийн 5.1/ 1. Шинээр эхлэх 10 төслийн геологийн даалгаврыг батлуулах, сонгон шалгаруулалтыг зарлах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах болон үргэлжлэн хэрэгжих 17, үр дүнгийн тайлантай 4, нийт 31 төслийн төсөв, төлөвлөгөөг батлуулах,	Улсын төсвийн хөрөнгөөр 2012 оноос хэрэгжүүлсэн Бурхант толгой-50, 2013 оноос хэрэгжүүлсэн Дэвсгийн нуруу-50, 2014 оноос хэрэгжүүлсэн Улаан толгой-50, Хулгарын элс-50, Суман хад-50, Хайлааст уул-50, Чандмань уул-50, Өлийн овоот-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн дүгнэлтэд үндэслэн УУХҮС-ын 2019 оны 11, 110, 111, 116, 125, 126, 127, 138 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Дээрх 8 төслийг хэрэгжүүлснээр 35,549.7 кв.км талбай буюу 2.3%-ийг бүрэн хамруулсан ба нийт нутаг дэвсгэрийн 40.5%-ийг бүрэн хамруулаад байна. Эдгээр талбайг зураглалын ажлаар бүрхсэний үр дүнд тухайн районд тархсан төрөл бүрийн хурдас, чулуулгийн тархалт, хил зааг, найрлага, нас зэргийг тодорхойлон зураглаж, геологийн тогтцыг нарийвчлан тогтоосон төдийгүй түүнд	40	40

		<p>ажлын хэмжээ, арга аргачлал, төсөвт тодотгол хийнэ. Тоо хэмжээ: 31 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>үндэслэн ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг тодорхойлж, хэтийн төлөвийг тодруулж, цаашид нарийвчилсэн судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх талбайг ялгасан байна. Эдгээр талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан газруудтай давхцалгүй бөгөөд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайнууд юм. 2019 онд 31 төслийг нутаг дэвсгэрийн 4.2%-д хэрэгжүүлэн ажиллахаар нэгдсэн төсөв, төлөвлөгөөг боловсруулан УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслүүдийн 2019 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтүүдийг үндэслэн УУХҮС-ын 2018.05.03-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар төсөл, төсөвт тодотгол хийж баталсан. 2019 онд шинээр Хулд-50, Халзан-Овоо-50, Алаг баян-50, Өндөрширээт-50, Оорцог уул-50, Хайрхан-Овоо-50, Ширээт уул-50, Борзонгийн говь-50, Гилбэнт уул-50, Зангат-50, нийт 10 төслийг шинээр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгох шалгаруулалтыг 2019.03.25, 2019.04.09-нд тус тус цахимаар нээлттэй зарласан. 10 төслийн хэрэгжүүлэхээр тендерт шалгарсан гүйцэтгэгч нартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Төслүүдийн 2019 оны суурин болон хээрийн судалгааны ажилд шуурхай хяналт хийх, анхдагч материал хүлээн авах төлөвлөгөө, төсвийг ТНБД-ын 2019.05.29-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан. Төслүүдийн 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын анхдагч материалыг хүлээн авсан.</p>		
81.	110.	<p>3.2.2. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэнэ. /ТЭБСББ-ын 3.2.1, ЗГҮАХ-ийн 2.59.2, ҮЧ-ийн 5.1/ 1. Дорнод Монгол-VI, VII төслүүдийн үр дүнгийн тайлан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээн авах, К хавтгайн нэгтгэл төслийг үргэлжлүүлэх, L хавтгайн нэгтгэл төслийг шинээр эхлүүлнэ. Тоо хэмжээ: 4 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Улсын геологийн иж бүрдэл зургийг К номенклатурын хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2017-2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлаар К хавтгайн 65%-д буюу К-48, К-49-ийн нэгтгэл ажил хийгдсэн. Төслийн 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар батлуулсан. 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн 2019.03.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын 2019.05.03-ны өдрийн А/107 дугаар тушаалаар баталсан. Төслийн 2019 оны хээрийн судалгааны ажлыг К номенклатурын 35%-д буюу баруун хэсэгт хэрэгжүүлсэн ба хээрийн материалыг 11-р сарын 20-нд хүлээн авсан. Монгол орны L номенклатурын хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2019 онд эхлүүлэхээр судалгааны ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр, төлөвлөгөө, төсвийг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар тус тус баталсан. Төслийн ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй УУХҮЯ-2019/07 дугаар гэрээг байгуулсан. L номенклатурын нь нийт нутаг дэвсгэрийн 839,481.26 кв.км буюу 53.7%-ийг эзлэх бөгөөд төлөвлөгөөт онд L хавтгайн 15 хувьд хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлсэн.</p>	40	40

			-Дорнод Монгол-VI, VII төслүүдийн үр дүнгийн тайлан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган төслийн үр дүнг Редакцын зөвлөлөөр хэлэлцүүлж байна.		
82.	111.	3.2.3. Монгол улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлнэ. /ТЭБСББ-ын 3.2.1, ЗГҮАХ-ийн 2.59.3, ҮЧ-ийн 5.1/ 1. Ховд-2019 төслийг шинээр эхлүүлнэ. Тоо хэмжээ: 1 төсөл Чанар: Холбогдох шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ	Монгол орны баруун хэсэг буюу 104,044.0 кв.км талбай /6.6%/-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажлыг 2019 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-ын 2019.02.04-ний өдрийн шийдвэрээр, УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан. Ховд-2019 (Ховд-1) төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулсан хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан хуулийн этгээд гараагүй. Зөвлөхийг сонгох тендерийг 2 удаа зарласан ч амжилтгүй болсон. Төслийг 2020 оноос дахин хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2020 оны төсвийн багцад санхүүжилтийн эх үүсвэрийг тусгуулсан.	40	40
83.	112.	3.2.4. Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологи болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ. /ТЭБСББ-ын 3.2.2.4, ЗГҮАХ-ийн 2.59.5, ҮЧ-ийн 5.2/ 1. Улаанбаатар болон Эрдэнэт хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд геоэкологи болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг үргэлжлэн хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: 2 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн төсвийг УУХҮС-ын А/13 дугаар, тодотголыг А/109 дүгээр тушаалаар тус тус баталсан. Төслийн 2019 оны суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.21-ний өдөр хэлэлцэж, УУХҮС-ын А/89 дүгээр тушаалаар батлан энэ оны судалгааны ажлыг эхлүүлсэн. Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2019 оноос хэрэгжүүлэхээр судалгааны ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2-р сарын 04-ний өдрийн шийдвэрээр, төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар тус тус батлуулсан. Судалгааны ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг 2019.03.25-ны өдөр цахимаар зарлан гүйцэтгэчийг шалгаруулж УУХҮЯ-2019/13 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан.	40	40
84.	113-116	3.2.5. Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-ийн 2.59.68 ҮЧ-ийн 5.2/1. Монгол орны бүс нутгийн металлогени, ашигт малтмалын ордуудын зүй тогтлын 1:1000000 масштабын зураг зохиох ажлын үр дүнгийн тайланг хүлээн авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: II улиралд 2. Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын ерөнхий тархалтыг сансрын зураг	1. Монгол орны бүс нутгийн металлогени, ашигт малтмалын ордуудын зүй тогтлын 1:1000000 масштабын зураг зохиох ажлын үр дүнгийн тайланг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2. Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын ерөнхий тархалтыг сансрын зураг ашиглан нэгдсэн боловсруулалт хийх ажлын үр дүнгийн тайланг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 3. Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2019 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар баталсан. Судалгааны ажлын 2019 оны төсөл, төсвийн тодотголыг УУХҮС-ын 2019 оны А/98 дугаар тушаалаар батлуулж, хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлсэн.	40	40

		<p>ашиглан нэгдсэн боловсруулалт хийх ажлын үр дүнгийн тайланг хүлээн авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: II улиралд</p> <p>3. Монгол орны голлох ашигт малтмалын судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслийг хэрэгжүүлсэн байна. Хугацаа: Жилдээ</p> <p>4. Монгол орны баруун бүсэд цул сульфидийн хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох ажлын үр дүнгийн тайланг хүлээн авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: УУХҮС-ын шийдвэр гарсан байна. Хугацаа: II улиралд</p>	<p>Төлөвлөгөөт онд хээрийн судалгааны ажлаар хэтийн төлөв бүхий 78 талбайд нарийвчилсан эрлийн ажил, 24 талбайд уул-өрөмдлөгийн ажил, 278 талбайд эрэл шалгалтын ажил хийхээр төлөвлөж, хээрийн үйлдвэрлэлийн ажлыг 2019.04.15-аас эхэлсэн. Төслийн 2019 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын анхдагч материалыг 2019.11.22-нд хүлээн авсан.</p> <p>4. Монгол орны баруун бүсэд цул сульфидийн хүдэржилтийн тархалтыг 1:1000000-ын масштабын хэтийн төлөвийн зураг зохиох ажлын үр дүнгийн тайланг хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>		
85.	117-118	<p>3.2.6. Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайлан хүлээн авна. /ЗГҮАХ 2.61.5, ҮЧ-ийн 5.2/</p> <p>1. Монгол улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУлс-ын хамтран хэрэгжүүлж байгаа “Хойд, төв, зүүн Азийн металлогени болон гүний процесс” төслийн ажлын 4 дүгээр үе шатны ажлыг үргэлжлүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслийг хэрэгжүүлсэн байна. Хугацаа: Жилдээ</p> <p>2. Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Росгеолфондод хадгалагдаж байгаа 1960-1990 оны хооронд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн 44 геологийн тайланг авах саналыг ОХУ-ын холбогдох газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тайланг хүлээн авах асуудлыг шийдвэрлэсэн байна Хугацаа: Жилдээ</p>	<p>1. МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКазУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/13 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2019 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2019.02.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 5-р сарын 03-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 4-р шат буюу "Их Алтай"-н төслийн хэмжээнд монголын тал Монгол Алтайд судалгааны ажлыг эхэлсэн. Хамтарсан төслийн 17-р ажлын уулзалтыг Улаанбаатар хотноо 2019.08 сард зохион байгуулсан. Төслийн 2019 оны судалгааны ажлын анхдагч материалыг 2019.11.22-нд хүлээн авсан.</p> <p>2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 22 дугаар хуралдааны тэмдэглэлд 1990 он хүртэл Монголын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлсэн геологийн судалгааны нууцын зэрэглэлтэй тайлангуудыг нууцын зэрэглэлээс гарган монголын талд авах ажлыг үргэлжлүүлэх гэсэн саналыг тусгуулсан.</p>	40	40
86.	119.	<p>3.2.7. Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /ТЭБСББ-ын 3.2.2.7, ЗГҮАХ 2.61.6/</p>	<p>Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр “Тогтвортой бичил уурхай төсөл”-ийн хүрээнд Хууль бус олборлолт эрхлэгчдийг албажуулах чиглэлээр эрхзүйн орчин боловсронгуй болгох, бичил уурхай эрхлэгчдийн талаар сайн туршлагын түгээн дэлгэрүүлэх, Канадын Сесмим төслийн хүрээнд Төрийн албыг чадавхжуулах,</p>	40	40

		<p>1. Гадаад орнуудын холбогдох байгууллагаас ирүүлсэн геологийн салбарт хамтран ажиллах саналыг судлан, үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх санал боловсруулж удирдлагад танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Саналыг судалж шийдвэрлэсэн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	салбарыг сурталчлах, бодлого хөтөлбөр боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.		
87.	120-121	<p>3.2.8. Монгол Улсын геологийн тогтцын ялгагдах онцлог байдал, дахин давтагдашгүй онцгой тогтоц, давхарга зүйн тулгуур зүсэлт, эрдэс чулуулгийн ховор олдвор, дээжийг улсын хамгаалалтад авч хадгалах эрх зүйн орчныг бүрдүүлж, үндэсний геопарк байгуулна.</p> <p>/ТЭБСББ-3.1.6/</p> <p>1. “Монгол орны геологийн сонирхолтой тогтоц, тулгуур зүсэлтийн судалгаа, түүний хамгаалалт” төслийн үр дүнгийн тайлан хүлээн авна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Үр дүнг хүлээн авсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p> <p>2. Монгол Улсад геопаркын үндэсний зөвлөл байгуулах асуудлаар судалгаа хийж холбогдох арга хэмжээг авна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Холбогдох саналыг боловсруулж удирдлагад танилцуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>1. “Монгол орны геологийн сонирхолтой тогтоц, тулгуур зүсэлтийн судалгаа, түүний хамгаалалт” төслийн үр дүнгийн тайланг 2019.03.19-ний өдрийн Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан.</p> <p>2. Шинжлэх ухааны академийн Геологийн хүрээлэнтэй хамтран Говийн бүсэд хийгдсэн геологийн сонирхолтой тогтоц, тулгуур зүсэлтийн судалгаа түүний хамгаалалт төслийн үр дүнд тулгуурлан Монгол Улсад Үндэсний геопаркын хороо байгуулахаар санал боловсруулан удирдлагад танилцуулсан. Уг саналын дагуу Үндэсний геопаркийн хороо ямар чиглэлээр байгуулах талаар санал боловсруулах ажлыг хэсэг байгуулахаар тушаалын төслийг боловсруулан ажиллаж байна.</p>	40	40
88.	122-123	<p>3.2.9. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.</p> <p>1. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилэн батлуулах, зөвлөлийн хуралдааны үйл ажиллагааг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p> <p>2. 2019 онд хэрэгжиж буй 4, үр дүнгийн тайлан хамгаалах 3 төслийг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.</p>	<p>1. УУХҮЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019 оны анхдугаар хуралдааныг 2019.03.14-ний өдөр УУХҮЯ дээр зохион байгуулсан. Хурлаас гаргасан шийдвэрийг БСШУСЯ-д 2019.04.04-ний өдрийн 01/931 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2019.05 дугаар сард УУХҮЯ-ны захиалгаар ШУТСангийн санхүүжилтээр 2020 оноос хэрэгжүүлэх төслийн саналыг БСШУСЯ-ны шинжлэх ухаан, технологийн зөвлөлд танилцуулан, Монгол орны хэмжээнд тархсан "Критикал металл"-уудын хүдэржилт, хэтийн төлөвийн судалгаа (ГХЭ, ЦАБ, Li, Co, Ta, Nb, Gr, In, Mg гм), Нуурын хөндийн хагарлын зүй тогтлын судалгаа, гэсэн 2 судалгааны ажлыг ШУТСангийн санхүүжилтээр 2020 оноос хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>2019.06.11-ний өдөр дээрх 2 сэдвийн ажлын даалгаврыг боловсруулан БСШУСЯ, ШУТСанд хүргүүлсэн.</p> <p>2. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2019.03.14-ний өдрийн хуралдаанаар Түүхий нүүрсний шахсан ба шингэрүүлсэн нийлэг байгалийн хийгээр орлуулах технологийн судалгаа, Сэргээгдэх</p>	40	40

		Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төслийн тайланг хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Хугацаа: Жилдээ	эрчим хүчний технологийн түүхий эдийн судалгаа, Төмрийн хүдрээс төмөрлөг бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн судалгаа, бүтээгдэхүүний стандарт, Ашигт малтмалын ордыг ашиглах дэвшилтэт, шинэ технологи боловсруулан нэвтрүүлэх судалгаа, Монгол орны Газрын ховор элементийн ордын хүдрийг баяжуулах технологи боловсруулах сэдэвт 5 төслийн явцын тайлан, Монгол орны төмрийн хүдрийн зарим ордуудыг түшиглэн өндөр чанартай ган гарган авах технологи, Субдукцын бүсийн геологи, магматизм, хүдэржилтийн судалгаа хэтийн төлөв, Монгол орны говийн бүсийн геологийн сонирхолтой тогтоц, тулгуур зүсэлтийн судалгаа, түүний хамгаалалт сэдэвт 3 төслийн эцсийн тайлан хэлэлцэн хүлээн авсан. УУХҮЯ, БСШУСЯ, ШУТС төсөл хүлээн актыг үйлдэж баталгаажуулсан.		
89.	124.	3.2.10. Геологи-ашигт малтмалын мэдээллийг нэгтгэн боловсруулна. 1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж нөөц нь бүртгэгдсэн ордуудыг ашигт малтмалын төрлөөр ангилах, бүс нутгийн хэмжээнд мэдээллийг нэгтгэн боловсруулах, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Мэдээлэл нэгтгэгдсэн байна. Хугацаа: Жилдээ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж нөөц нь бүртгэгдсэн ордуудын жагсаалтыг гаргаж, ашигт малтмалын төрлөөр нь ялгаж, мэдээллийг нэгтгэн тухай бүр нь удирдлагыг мэдээллээр хангасан.	40	40
3.3. Уул уурхайн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах гол зорилтын хүрээнд:					
90.	125.	3.3.1 “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна. /ТЭБСББодлогын 4.2.1/ 1. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг батлуулсан байна. Хугацаа: Жилдээ	УУХҮС-ын 2018 оны А/68 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулсан. Дүрмийн төслийг яамны веб сайтад 2018.11.29-нөөс байршуулан, нийтээс санал авсан ба Ил уурхайн инженерүүд болон мэргэжлийн хүмүүсийн саналыг тусган дахин боловсруулж, УУХҮС-аар батлуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар 2019.11.29-нийн өдрийн 02/3321 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	40	40
91.	126.	3.3.2 “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулна. /ТЭБСББодлогын 4.2.1/ 1. “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулж батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа	УУХҮС-ын 2017 оны А/227 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулсан.	40	40

		Чанар: Дүрмийн төслийг боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ			
92.	127.	3.3.3. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулна. /ТДБТХЭХТТХуулийн 5.1.2/ 1.“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг шинэчлэн боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Дүрмийн төслийг батлуулсан байна. Хугацаа: II улиралд	УУХҮС-ын 2017 оны А/80 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг шинэчлэн боловсруулсан. Улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч Засгийн газрын 2019.08.07-ны өдөр хэлэлцүүлж, Засгийн газрын 313 дугаар тогтоолоор батлуулсан.	40	40
93.	128.	3.3.4. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төслийг боловсруулах. /АМТХ-10.1.12/ 1. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төслийг боловсруулж, сайдын тушаалаар батлуулна Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмыг боловсруулж батлуулсан байна. Хугацаа: Жилдээ	Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дахь заалтад “баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах” гэж заасны дагуу “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж, УУХҮС-ын 2019.10.17-ны өдрийн А/205 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2019.11.04-ний өдрийн 4502 дугаарт бүртгүүлсэн.	40	40
97.	132.	3.3.8. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХ 2.61.4/ 1. Ашиглалтад оруулахад бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна. Хугацаа: Жилдээ	1. Стратегийн ач холбогдол бүхий уурхай, уулын болон баяжуулах үйлдвэр: Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1. дэх заалтыг үндэслэн: Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт үйл ажиллагаа эрхэлж буй “Эрдэнэт үйлдвэр” ХК-ийн уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг УУХҮС-ын 2019 оны А/17 дугаар тушаалаар, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоогийн ураны ордод үйл ажиллагаа явуулж буй “Бадрах Энержи” ХХК-ийн туршилтын уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг Уул уурхай, хүнд үйлдвэр, Барилга, хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2019 оны А/18/16 дугаар тушаалаар тус тус батлуулж тухай бүр Улсын комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг томилон ажиллуулсан. 2. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2. дахь заалтыг үндэслэн:	40	40

			Үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлэн болж Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Дорнод, Булган, Төв, Ховд, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Дархан Уул, Увс, Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй 70 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авах, холбогдох дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий Улсын Комиссыг ТНБД-ын удирдамжаар томилон ажиллуулж, ашиглалтад хүлээн авсан.		
99.	135.	3.3.10. Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар судалж, санал боловсруулна. /ЗГҮАТЗУГАТ-2.66.1/ 1. Холбогдох судалгааг хийж, санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Санал боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	УУХҮЯ-ны бүтцийг Засгийн газрын 2018 оны 370 дугаар тогтоолоор өөрчилж судалгааны нэгжийг яамны дотоод нөөцөд тулгуурлан байгуулсан бөгөөд Эдийн засаг, хөрөнгө оруулалт, судалгааны хэлтэс үйл ажиллагаа явуулж байна.	36	36
3.4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ашигт малтмалын ордуудыг олборлох, баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг төлөвлөх, гэрээ хэлцэлд бэлтгэх, гэрээт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг зохицуулах гол зорилтын хүрээнд:					
102.	139.	3.4.1. Техник, эдийн засгийн үндэслэл нь хийгдсэн, хөрөнгө оруулагч нь тодорхой болсон бэлэн төслүүдийг бүх талаар дэмжиж хэрэгжилтийг эрчимжүүлнэ. /ҮЧ-5.4/, /ЭЗСХ-1.3.8/ 1. Засгийн газрын 2016 оны 208 дугаар тогтоолоор батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-т хамрагдсан уул уурхайн төслүүдийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж ажиллана. Тоо хэмжээ: тухай бүр, Чанар: холбогдох төслүүдийн нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулж ажилласан байна. Хугацаа: Жилдээ	Эдийн засгийн сэргээх хөтөлбөрт хамрагдсан Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын далд уурхайд томилолтоор газар дээр нь ажиллаж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж ажилласан.	40	40
103.	140.	3.4.2. Үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болсон уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулна. /АМТХ-35.4, ЗГҮАТЗУГАТ-2.69.6, ҮЧ-5.4, ЭЗСХ-1.3.8/ 1. Стратегийн ордуудын ашиглалтад оруулахад бэлэн болсон уурхай, уулын баяжуулах	Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1. дэх заалтыг үндэслэн дараах стратегийн ач холбогдол бүхий ордууд дээр ажилласан. Үүнд: Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт үйл ажиллагаа эрхэлж буй "Эрдэнэт үйлдвэр" ХК-ийн уулын болон баяжуулах, үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг УУХҮС-ын 2019 оны А/17 дугаар	40	40

		<p>үйлдвэрийг хүлээн авах ажлыг зохион байгуулна.</p> <p>Тоо хэмжээ: Тухай бүр</p> <p>Чанар: Уурхай, уулын баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>тушаалаар, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоогийн ураны ордод үйл ажиллагаа явуулж буй “Бадрах Энержи” ХХК-ийн туршилтын уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг Уул уурхай, хүнд үйлдвэр, Барилга, хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2019 оны А/18/16 дугаар тушаалаар тус тус батлуулж тухай бүр Улсын комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг томилон ажиллуулсан.</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01 дүгээр сарын 21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2. дахь заалтыг үндэслэн хүсэлт гаргасан Дорнод, Булган, Төв, Ховд, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Дархан Уул, Увс, Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй нийт 70 гаруй уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авах, холбогдох дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий Улсын Комиссыг ТНБД-ын удирдамжаар томилон ажиллуулж, ашиглалтад хүлээн авсан.</p>		
104.	141.	<p>3.4.3. Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>/ЗГҮАТЗУГАТ-1.24.1, ҮЧ-4.3, ЭЗСХ-2.2.1.1/</p> <p>1. Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах оновчтой хувилбарын талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: ЗГ-ын хуралдаанд танилцуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Тус яамнаас “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлж, дэд бүтцийн төслүүдийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх тухай Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2018 оны 73 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Уг тогтоолд Таван толгой ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын зах зээлд арилжиж хөрөнгө босгож, дэд бүтцийн төслүүдийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх талаар тусгагдсан. Уг тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2019 оны 135 дугаар тогтоол, “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоол, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолуудыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулсан.</p>	40	40
105.	142.	<p>3.4.4. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.</p> <p>/ЗГҮАТЗУГАТ-1.24.2, ҮЧ-5.2/</p> <p>1. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явцын тайланг нэгтгэн удирдлагад танилцуулж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>2019 оны 10 дүгээр сарын эцсийн байдлаар:</p> <p>Далд уурхайн гүйцэтгэл -63%</p> <p>Далд уурхайн хөндлөн малталт -1277 м3</p> <p>Налуу буюу конвейрийн малталт -282 м3</p> <p>Босоо ам 3-ын нэвтрэлт –Нэвтрэлтийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдэж байна.</p> <p>Босоо ам 4-ийн нэвтрэлт -нэвтрэлтийн цамхаг барих ажил явагдаж байна.</p> <p>Нийт зардал- 3,173 сая доллар</p> <p>Нийт ажилтны тоо-7,214</p>	40	40

			Монгол ажилтны тоо- 6,403 Гадаад ажилтны тоо-721 Нийт Монгол ажилтан- 89%		
106.	143.	3.4.5. Цагаансуварга төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАТЗУГАТ-1.24.3, ҮЧ-5.4/ 1. Цагаансуварга төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан суваргын зэс-молибдений ордын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах хэрэгжилтийн явц 46.1 хувийн биелэлттэй бөгөөд цаашид төслийг бүрэн хүчин чадлаар ашиглалтад оруулахад 600.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байна. “Монголын алт (МАК)” ХХК нь Цагаан-Суваргын зэс-молибдены ордын зэсийн исэлдсэн хүдрийн нөөцийн тодотголыг хийж улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж улмаар ордын исэлдсэн хүдрийг боловсруулах жилд 5000 тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Цагаан суваргын ордын санхүүжилтийг шийдвэрлэх үүднээс Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тус орд газрын хөрөнгө оруулалтыг тусгасан.	40	40
107.	144-145	3.4.6. Стратегийн орд газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдтэй төрийн эзэмшлийн хувийг тогтоох хэлэлцээ хийж, улмаар ордыг ашиглах гэрээний төслийг хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэх арга хэмжээ авна. /АМТХ 5.3, 5.4, 5.5, 8.1.7, 9.1.5, 9.1.12, 472/ 1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын талбайн хил заагийг тогтоох ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ 2. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох талаар судалгаа хийж, аж ахуйн нэгжтэй байгуулах хэлэлцээрийн төсөл боловсруулна. /АМТХ-5.3, 5.4, 5.5, 8.1.7, 9.1.5, 472/ Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Санал боловсруулсан байна. Хугацаа: Жилдээ	1. Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой, Төмөртэй, Төмөртэйн овоо, Асгат, Бороо, Мардай, Гурванбулаг Дорнодын ордуудын талбайн хил заагийг тогтоох асуудлаар УУХҮС-ын тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд холбогдох саналыг боловсруулж, хил заагийг тогтоохоор ажилласан. Ажлын хэсгийн боловсруулсан саналын дагуу дээрх ордуудын хил заагийн асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган тогтоолын төсөлд яамдаас санал авахаар ажиллаж байна. 2. Стратегийн ордуудын төрийн эзэмшлийн хувь тогтоох болон аж ахуйн нэгжтэй байгуулах хэлэлцээрийн төсөл боловсруулах талаар тодорхой санал ирээгүй байна. -Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1. дэх заалтыг үндэслэн үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлэн болж Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоогийн ураны ордод үйл ажиллагаа явуулж буй “Бадрах Энержи” ХХК-ийн туршилтын уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах комиссыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2019 оны А/18/16 дугаар тушаалаар батлуулж, 2019.01.26-ны өдөр үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалттай газар дээр нь ажиллаж, холбогдох дүгнэлтийг боловсруулсан. Улмаар Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоолын дагуу УУХҮЯ болон Бадрах Энержи” ХХК хооронд байгуулах Зөөвч Овоо ордын технологийн туршилттай холбогдуулан Төрийн санд мөнгөн хөрөнгө	40	40

			байршуулах тухай гэрээний төслийг боловсруулж СЯ, БОАЖЯ, МХЕГ, ЦЕК, АМГТГ-аас санал авч 11-р сарын 15-ны өдөр талууд гэрээг албажуулан байгуулсан. -УИХ-ын 2011 оны 27 дугаар тогтоолын 1 ба 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх, эдийн засгийн эргэлтэд оруулах зохистой хувилбарыг сонгох үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮС-ын 2019 оны А/40 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг нийт 2 удаа хуралдаж холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж, УУХҮС-ын зөвлөлийн хуралдаан болон Засгийн газрын хуралдаанд танилцуулах материалыг нэгтгэн бэлтгэсэн. Одоогоор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.		
108.	146.	3.4.7. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулна. /ЗГҮАХ-2.59.9/ 1. Орд ашиглах гэрээ байгуулсан Гурвансайхан компанийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх, хамтарсан компанийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: IV улиралд	“Гурвансайхан” ХХК-ийн эзэмшиж буй орд газруудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар орд эзэмшигч төрийн өмчит компаниудтай ярилцан тохиролцох ажлыг зохион байгуулсан. Орд эзэмшигчид хооронд хөрөнгө оруулалтын маргаан үүсч Канадын Денисон Майнз компани Чех улсын Ураниум Индастри группийг олон улсын арбитрын шүүхэд өгснөөс шалтгаалан хувьцаа шилжүүлэх үйл ажиллагаа түр хойшлогдоод байна.	40	40
109.	147.	3.4.8. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлнэ. /ЭЗСХ-2.2.1.2/ 1. Гацууртын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлж, гэрээ байгуулахад хамтран ажиллана. Тоо хэмжээ: 1 удаа, Чанар: Бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хугацаа: Жилдээ	Гацууртын ордын нөөцийг шинэчлэн тооцох үүрэг бүхий шинжээчийн хэсэгт байгуулах УУХҮС-ын тушаал батлагдсан. Шинжээчийн хэсэгт ордыг эзэмшигч нартай уулзалт зохион байгуулж, нөөцийн тооцоо бүхий тайлантай танилцахаар тохиролцсон. Ордыг эзэмших асуудал Захиргааны хэргийн шүүх дээр удаа дараа хойшлогдсонтой холбоотойгоор ордын нөөцийг шинэчлэн тооцох ажил хийгдээгүй.	/-/	/-/
3.5. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн бодлого, улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулалтаар хангах гол зорилтын хүрээнд:					

110.	148.	<p>3.5.1. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.61.4/ 1. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бодлогын түвшинд нэгдсэн удирдлагаар хангана. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шийдвэр гарсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, УУХҮС-ын 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2. дахь заалтыг үндэслэн: Үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлэн болж Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Дорнод, Булган, Төв, Ховд, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Дархан Уул, Увс, Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй 70 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг ашиглалтад хүлээн авах, холбогдох дүгнэлтийг боловсруулах үүрэг бүхий Улсын Комиссыг ТНБД-ын удирдамжаар томилон ажиллуулж, ашиглалтад хүлээн авсан.</p>	40	40
111.	149-151	<p>3.5.2. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. /ЗГҮАХ-2.64./ 1. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна. /ЗГҮАХ-2.64.2/ Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Хуульд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ 2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тодорхой санал гарсан байна. Хугацаа: Жилдээ 3. Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалгаа хийж, хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.69.7/ Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Судалгаа хийгдсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>1. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” хэрэгжин, хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг зохион байгуулалтад оруулах ажлыг холбогдох байгууллагууд /АМГТГ, МХЕГ, орон нутгийн захиргааны байгууллагууд/ хамтраг хэрэгжүүлж байна. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2018.10.31-ний өдрийн хуралдаан, Эдийн Засгийн байнгын хорооны 2018.11.28-ны өдрийн хуралдаан, УИХ-ын 2019.03.26-ны өдрийн чуулганаар тус тус хэлэлцүүлж батлуулсан. Хуулийн төсөл батлагдсанаар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй хоршоо, нөхөрлөл, тэдгээрээс ашигт малтмал худалдан авч экспортолсон, худалдсан этгээд болон ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөх, тайлагнах, бүртгэлжүүлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монголбанкинд тушааж буй алтны хэмжээг бууруулахгүй, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх боломж бүрдсэн болно. 2. Хууль бусаар ашигт малтмал олборлох асуудлыг цэгцлэх ажлын хүрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам болон холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дэд ажлын хэсгийг БОАЖЯ-ны Хуулийн хэлтсийн даргаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан хэлэлцүүлгийг зохион байгуулахад оролцож, санал өгсөн. 3.Тогтвортой бичил уурхайн төслийн 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинээр алтны сорьц тогтоох, худалдан авах цэгийн төвийг Ховд аймгийн төв Ховд хотод шинээр байгуулахаар төлөвлөсөн.</p>	40	40

ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭР, ГАЗРЫН ТӨСНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЗОХИЦУУЛАХ СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:

4.1. Хүнд үйлдвэрийн талаарх хууль тогтоомж, бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:

112.	152.	<p>4.1.1. Монгол Улсын үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. /ЗГҮАХ-2.1.2, ҮЧ-4.4, ТАҮТББ-4.2.2.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн-10 дугаар зүйл/ 1. Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Засгийн газрын 2019.05.29-ний өдрийн 214 дүгээр тогтоолоор Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулсан. Хөгжлийн хөтөлбөр батлагдсантай холбогдуулан түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан УУХҮС-ын 2019.08.26-ны өдрийн А/180 дугаар тушаалаар батлуулсан.</p>	40	40
113.	153.	<p>4.1.2. Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. /ТАҮТББ-4.1.1/ 1. Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулж, үзэл баримтлалыг батлуулна. Тоо хэмжээ: 1 Чанар: Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна. Хугацаа: IV улиралд</p>	<p>Хүнд үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох судалгааг хийж, Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг ХҮГТБХЗГ-тай хамтран боловсруулж байна.</p>	36	36
114.	154.	<p>4.1.3. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангана. /ЗГҮАХ-2.73.4, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6/ 1. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн нэгжийн статусыг өөрчлөх асуудлаар санал боловсруулна. Тоо хэмжээ: 1 Чанар: Санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн байна. Хугацаа: II улирал</p>	<p>МУ-ын ЗГ-ын 2016.09.28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮС-ын 2016 оны А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж байна. Цаашид төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй гэрээ хэлэлцээр хийх, газрын болон холбогдох бусад зөвшөөрлүүдийг авахад уг төслийн үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төсөл хэрэгжүүлэх нэгж бус аж ахуйн тооцоот хуулийн этгээд эрхлэн явуулах бодит шаардлага үүсээд байгаа юм. Мөн тус асуудлыг УУХҮС-ын зөвлөлийн 2019.01.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд УУХҮС-ын зөвлөлөөс ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэрлүүлэх тухай 02 тоот шийдвэрийг гаргасан. Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ННБХҮҮБ төслийн нэгжийг бие даасан төрийн өмчит компани хэлбэрээр зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан УУХҮС-ын 2019.05.02-ны 01/1267 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч төслийн эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөө, үр ашиг тодорхой бус гэсэн шалтгаанаар буцаагдсантай холбогдуулан “Нүүрснээс</p>	40	40

			нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, УУХҮС-ын 2019.09.05-ны өдрийн 01/2514 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Эрдэнэс Монгол” ХХК-иас ирүүлсэн саналын хамт УУХҮС-ын 2019.11.21-ны өдрийн 01/3249 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т дахин хүргүүлсэн.		
115.	155.	<p>4.1.4. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ. (ЗГҮАХ-2.75.1, ТАҮТББ-4.2.3.6)</p> <p>1. Автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрах үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газар болон УИХ-аар хэлэлцүүлсэн байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Хүнд үйлдвэрийн салбарыг татварын бодлогоор дэмжиж ажиллах ажлын хүрээнд тусгуулах саналыг боловсруулан 2019.04.02-ны өдөр Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэн холбогдох зохицуулалтыг хийж ажилласан. Үүнд автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрахад хагас ба бүрэн задаргаа (SCD ба CKD)-аар нийлүүлэгдэх шаардлагатай эд анги, тоног төхөөрөмжийг Гаалийн тариф болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, үр нөлөөний судалгаа зэргийг тооцоолж, боловсруулан 2019.08.16-ны өдөр СБТГ болон ТЗУГ-ын Хуулийн хэлтэст дотоод албан бичгээр чиг үүргийн дагуу шилжүүлсэн.</p>	40	40
116.	156.	<p>4.1.5. “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавина. /Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.2 дахь заалт/</p> <p>1. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмын төслийг боловсруулж батлуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Журмыг төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, УУХҮС-аар батлуулсан байна. Хугацаа: II улиралд</p>	<p>УУХҮС-ын 2019.02.19-ний өдрийн А/35 дугаар тушаалаар “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг 2019.03.19-ний өдөр зохион байгуулж, хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу НҮБ-ын суурин төлөөлөгч Биата Транкманд УУХҮС-ын 2019.02.19-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийг 3 удаа хуралдуулж, журмын төслийн анхны хувилбарыг Уул уурхайн хэлтэс, Газрын тосны хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар 2019.06.24-ний өдөр хүргүүлсэн. Мөн журмын төсөл боловсруулахтай холбогдуулан 21 аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрууд болон нэр бүхий 26 уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-уудаас шаардлагатай мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсний дагуу 2019.10.24-ний өдрийн байдлаар 16 аймаг, 14 ААНБ-аас холбогдох мэдээлэл ирүүлснийг нэгтгэн боловсруулж байна. Мөн журмын төслийн анхны хувилбарт санал авахаар УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны 03/2701 дүгээр албан бичгийг нэр бүхий 22 ААНБ болон БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, СЯ, БХБЯ, ЭМЯаманд тус тус хүргүүллээд байна. Журмын төсөл 2019.12.09-ний өдрийн байдлаар БОАЖЯ,</p>	40	40

			ЗТХЯ, СЯ, ЭМЯ болон 6 ААНБ-аас санал ирүүлээд байна. Мөн журмын төсөлд олон нийтээс санал авах зорилгоор УУХҮЯ-ны болон АМГТГ-ын албан ёсны вэб хуудаст 2019.09.19-ний өдөр байршуулсан. Ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган, журмын төслийн нөлөөллийн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэн, журмын төслийн хэлэлцүүлгийг 12 сард зохион байгуулахаар ажиллаж байна.		
117.	157.	4.1.6. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. /ЗГҮАХ 2.61.4/ 1. Боловсруулах үйлдвэр хүлээн авах Ажлын хэсэгт тухай бүр оролцож, санал өгнө. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Шинээр байгуулсан хүнд үйлдвэрийг ашиглалтад оруулахад оролцож саналаа өгсөн байна. Хугацаа: Жилдээ	УУХҮС-ын 2018.02.26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлагдсан ЭБМЗ-ийн дүрэмд Боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаан шинээр нэмэгдэж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2018-2019 онуудад нийт 10 удаагийн хуралдааныг зохион байгуулж боловсруулах үйлдвэрийн салбарын 20 төслийн ТЭЗҮ, стратегийн ач холбогдол бүхий 3 үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тус тус хэлэлцэж холбогдох шийдвэрийг гаргасан.	40	40
4.2. Хүнд үйлдвэрийн салбарт хар ба өнгөт төмөрлөгийн болон машин байгууламж, металл хийцийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, газрын тос, уламжлалт бус газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрсийг хагас, гүн боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр байгуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгох, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах гол зорилтын хүрээнд:					
118.	158.	4.2.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавина. /ЗГҮАХ-2.70.1, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6/ 1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьсан байна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журамд нийцсэн байна. Хугацаа: Жилдээ	ЗГ-ын 2018.01.03-ны өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг МУ-ын хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт /төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбай/-ын ажлыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнгийн талаар ЗГ-т тухай бүр танилцуулж байхыг холбогдох сайд нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус даалгасан. Мөн Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолоор “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн төмөр замын салбар зам, хүнд даацын тусгай зориулалттай автозам, цахилгаан дамжуулах сүлжээ барих төслийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил болон барилгын ажлын гүйцэтгэчийг тухайн ажлыг гүйцэтгэх туршлага болон техник, тоног төхөөрөмжийн чадавхтай төрийн өмчит хуулийн этгээдүүдээс сонгон хэрэгжүүлэхийг Батлан хамгаалахын сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд нарт даалгасан. Дээрх тогтоол шийдвэрүүдийн хүрээнд газрын тос боловсруулах	40	40

			<p>үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн 27 км урт салаа төмөр зам, 18.2 км, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6.3 МВ-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16.63 км урт хатуу хучилттай автозам барих төслүүдийн барилга угсралтын ажлыг 2018.06.22-ны өдөр Дорноговь аймгийн Алтанширээ суманд эхлүүлж, 2019.10.08-ны өдөр ашиглалтад хүлээж авсан.</p>		
119.	159-160	<p>4.2.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл, байгаль орчин нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг боловсруулна. /ЗГҮАХ-2.70.3, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6/</p> <p>1. Үйлдвэрийн барилгын инженер-техникийн зураг төслийг боловсруулсан байна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Монгол улсын стандарт, норм, дүрэмд нийцсэн байан. Хугацаа: Жилдээ</p> <p>2. Төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг боловсруулсан байна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үнэлгээний тайланг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг төсөл хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон Энэтхэг Улсын “Инженерс Индиа Лимитед” компани хооронд 2019.05.13-ны өдөр байгуулсан. Гэрээлэгч талууд газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, ерөнхий зураг төслийн үндсэн өгөгдлүүдийг тохиролцох, зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлэх уулзалтыг 2019.06.08-14-нд БНЭУ-ын Нью Дели хотод зохион байгуулж, төслийн дараагийн шатны ажлуудыг төлөвлөсөн.</p> <p>Үүнд: Үйлдвэрийн технологийн болон дагалдах байгууламжуудын байршил, хүчин чадал, иргэний барилга, шугам хоолойн трасс, бамбарын систем, ногоон бүс, зам талбай, хашаа хамгаалалт бүхий үйлдвэрийн ерөнхий дэвсгэр зургийг эцэслэн баталж, технологи, техникийн нөхцөлүүд, талбайд хийгдэх нарийвчилсан судалгаа, ус хангамжийн системийн талаар санал солилцож, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг урьдчилсан байдлаар тохиролцсон.</p> <ul style="list-style-type: none"> - Энгийн болон вакуум нэрлэгийн байгууламжийн зураг төслийн үндэслэлийн Хэсэг “А”-г хянаж, баталсан. - Зураг төслийн үндэслэлийн Хэсэг “Б”-г батлахаар ажиллаж байна. - Үйлдвэрийн талбайд баригдах захиргаа, сургалт, аюулгүй ажиллагааны барилга байгууламжууд, агуулах, засварын цех, гал команд, ажилчдын хоолны газрын хэмжээ, барих материал, байрлах ажилчдын тоог тохиролцсон. - Үйлдвэрийн төлөвлөлтийн ажлын үе шат ахих тусам судалгааны ажлын түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан үйлдвэрийн талбайд хийгдэх геотехникийн болон геофизикийн судалгааны ажлын даалгаврыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК боловсруулж Зөвлөх үйлчилгээний компанид хүргүүлсэн. <p>“Газрын тос боловсруулах үйлдвэр, үйлдвэрийн усны эх үүсвэр болон ус хангамжийн шугам хоолойн дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” боловсруулах Зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг сонгож, 2019.08.23-ны өдөр гэрээ байгуулан, үнэлгээний ажлыг хийлгэн батлуулах шатандаа явж байна.</p>	40	40
120.	161.	4.2.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралтын үеийн болон үйлдвэрийн	ЗГ-ын 2019.04.03-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалт, барилга	40	40

	<p>ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд суманд орон сууцны хотхон байгуулах төслийн талаар Засгийн газарт танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулна. (ЗГҮАХ-2.70.3, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6)</p> <p>1. Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Төслийн хүрээнд ажиллах ажилчдыг орон сууцаар хангах ажлыг эхлүүлсэн байна.</p> <p>Хугацаа: II улиралд</p>	<p>угсралтын үед ажиллах ажилчдыг болон цаашид үйлдвэрт ажиллах ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэрт 550 айлын орон сууцны хотхон байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Батлан хамгаалахын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. Энэ ажлын хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд суманд 8,4 мегаваттын цахилгаан станц болон цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдсон 11 га газрыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх тухай А/206 тоот захирамжийг Дорноговь аймгийн Засаг дарга 2019.02.20-ны өдөр гаргасан. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хотхоны архитектур төлөвлөлт, зургийн даалгаврыг боловсруулах, барилгын болон гадна шугам сүлжээний зургийн ажлыг эхлүүлэх, зардал, төсвийг тооцох зэрэг бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн.</p> <p>Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх гадна дэд бүтцийн төслүүдийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийн нийт төсөвт өртгөөс 38 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. Энэхүү хэмнэсэн мөнгөн хөрөнгийг Засгийн газар хотхоны бүтээн байгуулалтад зарцуулахаар шийдвэрлэсэн. Хотхоны өртөг зардлыг бууруулах зорилгоор тус хотхоныг барьж байгуулахад шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа, материалын гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2019.11.30-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Татварын хөнгөлөлт эдлэх бараа материалын жагсаалтыг боловсруулж УУХҮС-ын 2019.12.11-ний өдрийн 03/3426 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, бараа материалын ангиллын кодыг ГЕГ-аар тодорхойлуулж байна.</p> <p>Хотхоны эхний ээлжийн барилга угсралтын ажил энэ оны 8 дугаар сарын сүүлчээр эхэлсэн бөгөөд 95 айлын 2, 40 айлын 1, 32 айлын 1 орон сууц болон оффис-үйлчилгээний төвийн газар шорооны ажил, төмөр бетон суурь, бетон хана, дулаалгын ажил хийгдэж дууссан. 2020 онд ашиглалтад оруулах 40 айлын орон сууцны зоорийн давхрын ажлыг дуусгаад байна. 2019 оны 12 дугаар сарын байдлаар барилгын талбайг өвөлжүүлэх бэлтгэл ажлыг ханган барилгын ажлыг улирлын чанартай түр зогсоож, дараа жилийн ажлыг төлөвлөн ажиллаж байна.</p>	
--	--	--	--

121.	162.	<p>4.2.4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулна. /ЗГҮАХ-2.70.1, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6/ 1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөхтэй байгуулах гэрээний төслийг боловсруулсан байна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Төслийн менежментийн зөвлөхтэй гэрээ байгуулсан байна. Хугацаа: II улиралд</p>	<p>“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК болон Энэтхэг Улсын “Инженерс Индия Лимитед” төрийн өмчит компаниуд 2019.05.13-ны өдөр газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Уг гэрээнд төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани гүйцэтгэлийн баталгаа банканд байршуулах, инженер-геологийн судалгаа хийх болон бусад асуудлуудыг тусган, тус гэрээний нэмэлт, өөрчлөлтийг 2019.09.26-ны өдөр баталсан. Нэмэлт, өөрчлөлт орсон гэрээний 5 дахь хэсгийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад төсөл хэрэгжүүлэгч компанитай ажил эхлүүлэх уулзалт хийснээр гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувь, эх загвар зураг /эскиз/, техникийн төслийн үндэслэл боловсруулж, хүлээлгэн өгснөөр гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх төлбөрийг тус тус захиалагч тал төлөхөөр тусгагдсан. Дээрх гэрээний нөхцөлийн дагуу “Инженерс Индия Лимитед” компаниас 2019.10.01-ний өдрийн B285FL003 дугаартай 14,598,086.60 ам.долларын нэхэмжлэхийг төсөл хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д ирүүлсний дагуу уг төлбөрийг “Инженерс Индия Лимитед” компанид олгох зөвшөөрлийг Энэтхэгийн Эксим банканд хүргүүлэх тухай УУХҮЯ-ны ТНБД-ын 2019.11.14-ний өдрийн 03/3178 дугаар албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.</p>	40	40
122.	163.	<p>4.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийг газрын тосоор хангах дамжуулах хоолой барих төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХ-2.70.1, ҮЧ-4.4, ТАҮТББ- 4.2.3.6/ 1. Газрын тос дамжуулах хоолой барих төслийн талаар гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагуудад танилцуулга хийж, хөрөнгө оруулалт татах чиглэлээр уулзалт зохион байгуулсан байна. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Газрын тос дамжуулах хоолой барих төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэсэн байна Хугацаа: I улиралд</p>	<p>Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгөөр ОХУ болон БНХАУ-д хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг шийдвэрлэхэд ЗГ-ын баталгаа зайлшгүй шаардлагатай байгаа тул “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн зүгээс түүхий тос дамжуулах хоолойн асуудлыг ЗГ болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулсан. Дорноговь аймгийн Алтанширээ суманд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг МУ-ын Ерөнхий сайдын 2019.09.16-ны өдрийн 118 дугаар Захирамжаар байгуулсан. Уг ажлын хэсгийн шийдвэрээр дэд бүтцийн оновчтой хувилбарыг сонгох ажлын хүрээнд төмөр зам, дамжуулах хоолойн төсөл дээр үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоогоор хийж гүйцэтгүүлж байна.</p>	40	40

123.	164.	<p>4.2.6. Газрын тос боловсруулах үйлдвэр барихаар олгогдсон газрыг өргөтгөх асуудлыг шийдвэрлэнэ. /ЗГҮАХ-2.70.1/ 1. Газрын тос боловсруулах үйлдвэрт Засгийн газрын шийдвэрээр олгосон 150 га газрыг 400 га болгон өргөтгөх асуудлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх санал хүргүүлнэ. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Үйлдвэр барих газрыг 400 га болгон өргөтгөсөн байна. Хугацаа: II улиралд</p>	<p>ЗГ-ын 2018.01.24-ний өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 28 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших 150 га газрыг томоохон бүтээн байгуулалтын төсөл болох “газрын тос боловсруулах үйлдвэр” байгуулах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. ЗГ-ын 2019 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах, тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай” 368 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрийн аюулгүйн бүс тогтоох, үйлдвэрийн ирээдүйн боломжит өргөтгөлийн нөөц талбайг харгалзан үзэж газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд зориулж олгогдоод байсан улсын тусгай хэрэгцээний 150 га газрыг 405.17 га болгон өргөтгөж, газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан. Түүнчлэн тус үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээний усыг Бор хөөврийн говийн гүний усны ордоос хангахаар Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн тогтоолоор шийдвэрлэсэн.</p>	40	40
124.	165.	<p>4.2.7. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулна. /ЗГҮАХ-2.71.1/ /ҮЧ-4.4/ /ТАҮТББ-4.2.3.6) 1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулсан байна. Хугацаа: Жилдээ</p>	<p>Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2018.12.12-ны өдрийн “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 378 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолын дагуу 2019.04.03-ны өдөр улсын тусгай хэрэгцээнд газрыг ашиглуулах тухай 2019/01 дугаар бүхий гэрээг байгуулаад байна. Мөн төслийн асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулсан бөгөөд ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 196 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д хамруулсан. Төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөхийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан өмгөөллийн “Монгол Өмгөөлөгч” ХХН-тэй гэрээ байгуулж, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төсөл, холбогдох тайланг хүлээн авсан. Үүний дагуу “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах журам”-ыг олон улсын жишиг аргачлалын дагуу боловсруулан бэлтгэл ажлыг хангасан.</p>	40	40
125.	166.	<p>4.2.8. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах Зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХ-2.71.2/ 1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг зохион байгуулж, Эрдэс</p>	<p>1. УУХҮС-ын 2019 оны төсвийн багцад Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зардлыг тусгуулж, УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны “Үнэлгээний хороо байгуулах тухай” А/113 дугаар тушаалаар Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдан ажилласан боловч ЗББҮ-ийн ТЭЗҮ боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагаа нь Төрийн нууцад хамаарсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-</p>	40	40

		<p>баялгийн мэргэжлийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар уралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулна.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, дүгнэлт гаргуулсан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>т заасны дагуу зохион байгуулахыг Тагнуулын Ерөнхий Газрын 2019.09.18-ны өдрийн 01/1281 дугаар албан бичгээр уламжилсан. Иймд тендерийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон. Улмаар ТНБД-ын 2019.11.28-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/203 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасныг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдан 2019.12 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.</p>		
126.	167.	<p>4.2.9. Алт-2” хөтөлбөрийн хүрээнд алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулна.</p> <p>/ЗГҮАХ-2.69.5/</p> <p>1. “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-тай хамтран Алт цэвэршүүлэх үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг зохион байгуулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар уралдаанаар хэлэлцүүлж, үйлдвэрийг барьж байгуулах бэлтгэл ажлыг хангах.</p> <p>Тоо хэмжээ: 1 удаа</p> <p>Чанар: Алт цэвэршүүлэх үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авч үйлдвэрийг барьж байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна.</p> <p>Хугацаа: Жилдээ</p>	<p>Үнэт металл боловсруулах хамгийн сүүлийн үеийн, инновацийн технологи болох “Вакуум дистилляцийн арга”-ийн Патент эзэмшигч БНКаЗУ-ын нэр бүхий компанитай Алт цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ хийлгэхээр хамтын ажиллагааны гэрээ байгуулан ТЭЗҮ-ийг 2019.09 дүгээр сард УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Хүнд үйлдвэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээн авсан. Мөн алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын хүрээнд үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, дэд бүтцийн болон инженер геологийн судалгааг гүйцэтгэсэн.</p> <p>ЗГ-ын 2019 оны 02 дугаар сарын хуралдаанаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар хэлэлцэж “Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тэмдэглэл гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019.02.27-ны өдөр алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай” зөвлөмж гарсан. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тагнуулын ерөнхий газраас ЗГХЭГ-т алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг нууцад хамруулах асуудлаар ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 196 дугаар тогтоолоор ЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “МУ-ын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна.</p> <p>2019.06.12-16-ны өдрүүдэд Монголбанк, “Эрдэнэс Алт Ресурс” ХХК, Стандарт, хэмжил зүйн газар, “Бринкс Монгол” ХХК-ийн төлөөллүүдийг хамарсан Ажлын хэсэг Швейцарь улсын Argor Heraeus SA алт цэвэршүүлэх үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. Монголбанкнаас “London Bullion Market Association”-ны “Сайн цэвэршүүлэгч” алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийн бизнесийн үйл ажиллагааг судлан холбогдох танилцуулгыг боловсруулан, алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын явцын тайлангийн хамт Эдийн засгийн байнгын хороонд 2019.03.25-ны өдрийн А-1/277 албан бичгээр хүргүүлсэн. Мөн алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийн бэлтгэл ажлын хүрээнд</p>	40	40

			40000 м.кв газрыг 15 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн барилга байгууламж барих зориулалтаар ашиглахаар шийдвэрлүүлсэн.		
127.	168.	<p>4.2.10. Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн ТЭЗҮ болон БОННУ боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусгана. /ЗГҮАХ-2.72.1/ 1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайланг хүлээн авна. Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тайланд хяналт тавьж, хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна. Хугацаа: Жилдээ</p>	Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн БОННУ-ний олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж хүлээж авсан.	40	40
